



МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БА ШҮҮХ ЭРХ  
МЭДЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хот

2023 он

УЛААНБААТАР ХОТ  
2023 он

## УДИРТГАЛ

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн санаачилга дэмжлэгтэйгээр Могол Улсын Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2000 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор баталжээ.<sup>1</sup>

Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө (цаашид “Стратеги төлөвлөгөө” гэх) нь 6 суурь үнэлэхүйн хүрээнд 30 стратеги зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх 101 арга хэмжээг багтаасан байна. Тухайлбал, Хараат бус байх, Хариуцлага хүлээдэг байх, Мэдрэмжтэй байх, Шударга байх, Хүртээмжтэй байх, Бүтээмжтэй байх гэсэн 6 суурь үнэлэхүйг тодорхойлсон байна.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын прокурорын ерөнхий газар хүлээж, өөр, өөрийн чиг үүргийн дагуу хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж ирсэн байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, хууль, тогтоомж зохицуулалт, шүүхийн тогтолцоо, шүүхийн захиргааны байгууллагын бүтэц, үйл ажиллагааны өнөөгийн байдалд тулгуурлан гаргалаа.

Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслөөс 206 онд хийсэн Стратеги төлөвлөгөөний үнэлгээний тайлан болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2018 онд хийсэн Стратеги төлөвлөгөөнд хийсэн үнэлгээний тайланг шинэчлэн баяжуулах замаар Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, дүн шинжилгээг хийлээ.

Стратеги төлөвлөгөө батлагдсанаас хойших 20 гаруй жилийн хугацаанд хийгдсэн эрх зүйн шинэчлэл, шүүх эрх мэдлийн салбарын шинэтгэлийн үр дүнд Стратеги төлөвлөгөөний Хараат бус байх, Хариуцлага хүлээдэг байх, Мэдрэмжтэй байх, Шударга байх суурь үнэлэхүйн хүрээнд дэвшүүлсэн стратеги зорилтууд үндсэндээ хэрэгжсэн, харин төсөв, хөрөнгө оруулалтын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход чиглэгдсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн түвшин хангалтгүй байдалтай байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн өнөөгийн байдал, үнэлгээ, дүгнэлт, цаашдын бодлогод тусгах асуудлуудын талаарх зөвлөмжийг боловсруулав.

## АЖЛЫН ХЭСЭГ

---

<sup>1</sup> “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан Шүүхийн ерөнхий зөвлөл 2018 он

# НЭГ.ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## Суурь үнэмлэхүй 1. ХАРААТ БУС БАЙХ

“Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн харилцан тэнцвэрийг хангахуйц шүүх эрх мэдлийн улс төр, эдийн засаг, зохион байгуулалтын болон шийдвэр гаргах хараат бус байдлаа хамгаалах чадвар”

**Стратеги зорилт 1.1.Шүүгч бие дааж шийдвэр гаргах боломжийг хангахуйцаар бүх шатны шүүхийн хоорондын харилцааг боловсронгуй болгоно.**

*Авах арга хэмжээ 1.1.1.Анхан шат, давж заалдах, хяналтын шатны шүүхийн харьяаллыг давхардалгүй оновчтой тодорхойлох*

1.1963 онд баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар эрүүгийн хэргийг хөнгөн, хүнд, онц хүнд, нарийн төвөгтэй байдлыг харгалзан сум, дүүргийн шүүх, аймаг, нийслэлийн шүүх, Улсын дээд шүүхэд хувааж харьяалуулсан байжээ. Энэ гурван шатны шүүх тус тусын харьяалсан хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байсан байна.

2.1994 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар энэ давхардлыг багасгаж, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар давхардалгүй болгон эрх зүйн хүрээнд цэгцэлснээр хэргийг анхан шатны шүүхэд хүлээн авч хянан шийдвэрлэдэг болсон байна.

3.Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль 2002 онд батлагдаж, 2004 онд байгуулагдсан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн харьяаллыг дээрх зарчмаар тогтоосон байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2011 онд байгуулагдах хүртэл Улсын дээд шүүх нь захиргааны хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үүргийг давхар гүйцэтгэж байсан байна.

4.Эрүү, иргэн, захиргааны хэргийн процесс хуулиудад шүүхийн харьяаллын анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шатлал хоорондын давхардсан байдлыг бүрэн арилж, хэргийн хөнгөн, хүнд хэлбэрээс үл хамааран бүх хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэж байна. Тухайлбал,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд “1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх иргэний бүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. 2.Аймаг, Нийслэлийн шүүх иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. 3.Улсын Дээд шүүх иргэний хэргийг ...хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж шүүхийн харьяаллыг тогтоосон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүхэд ирсэн хэргийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хэрэг хуваарилах журмын дагуу хуваарилна.”, 3 дахь хэсэгт “Хуульд тусгайлан зааснаас бусад эрүүгийн хэргийг сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.”, 4 дэх хэсэгт “Хэрэг тухайн шүүхэд харьяалагдахгүй байвал шүүгчийн шийдвэрээр харьяалах шүүхэд шилжүүлнэ.”, 5 дахь хэсэгт “Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл сум буюу сум дундын шүүхээс дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын

шийдвэрээр, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, эсхүл өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ.” гэж заасан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд “1.Захиргааны хэргийн анхан шатны шүүх энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. 2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуулиар харьяалуулсан захиргааны хэргийг анхан шатны журмаар, анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. 3.Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ. 4.Улсын дээд шүүх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж харьяаллыг тогтоосон.

5.Шүүх харьяалагдан ирсэн хэргийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нийт шүүгчийн чуулганаас баталсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журамд нийцүүлсэн тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан хэрэг хуваарилах нарийвчилсан журмын дагуу хэрэг хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан программ хангамжийг ашиглаж байна.

*Авах арга хэмжээ 1.1.2.Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх харьяаллыг үндэслэн тэдгээрийн зохион байгуулалт, байршлыг өөрчлөх, анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно.” гэж, 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан.

2.1993 оны Шүүх байгуулах тухай хуулиар аймаг, хотын шүүхийг аймаг, нийслэлийн шүүх болгож, мөн хэсэг, район, орон нутгийн хотын шүүхийг сум болон сум дундын, дүүргийн шүүх болгож тус тус өөрчлөн зохион байгуулж, засаг захиргааны нэгжид байршуулсан байна.

3.2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар одоогийн шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон. Энэ хуулийн дагуу анхан болон давж заалдах шатны 116 шүүх 30 байршилд ажиллаж байгаа бөгөөд шүүхүүдийн байршил 1993 оны Шүүх байгуулахаас хуулиас хойш тогтвортой байна.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу зөвхөн хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.”, 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний

байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, 3 дахь хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.”, 4 дэх хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх энэ хуулийн 13.4, 14.3-т заасан шалгуур үзүүлэлтийг Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй зөвшилцөн батална.” гэж хуульчилсан.

5.Орон тооны хувьд, УИХ-ын 1993 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор шүүгчийн орон тоог тогтоосон байх бөгөөд энэ стратеги төлөвлөгөө батлагдах үед бүх шатны шүүхэд 359 шүүгч ажиллаж байжээ.

6. Улсын Их Хурлын 2016 оны “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” 42 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүгчийн тоог 699 байхаар тогтоожээ. Гэвч шүүхийн төсөвт шүүгчийн цалингийн санг дутуу баталж ирснээс шалтгаалан энэ тооны шүүгч ажиллуулж чадахгүй байна.

Шүүгчийн тоог нэмэгдүүлж баталсан нь анхан болон давж заалдах шатны шүүхийг эрүү, иргэн, захиргааны төрлөөр дагнан байгуулсан (шүүхийн тоо 1993 оны үеэс бараг 2 дахин өссөн, мөн шийдвэрлэсэн хэргийн тоо ихээхэн өссөн)-тай холбоотой байна. 2000 онд шүүхэд 31,994 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байсан бол 2022 онд бүх шатны шүүх 105,713 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байна.<sup>2</sup>

7.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөн шүүгчээс бүрдэнэ.” гэж Улсын дээд шүүхийн шүүгчийн орон тоог хуулиар тогтоосон байна.

8.2023 оны 05 дугаар сарын байдлаар, бүх шатны шүүхэд 511 шүүгч ажиллаж байгаагаас анхан шатны шүүхийн шүүгч 384, давж заалдах шатны шүүхийн шүүгч 104, хяналтын шатны шүүхийн шүүгч 23 байна.

*Авах арга хэмжээ 1.1.3.Анхан шатны шүүхийн хараат бус байдлыг хангах үүднээс доод шатны шүүхийн шийдвэрт дээд шатны шүүхийн шүүгч эсэргүүцэл бичих эрхийг, доод шатны прокурорын эсэргүүцлийг дээд шатны прокурор нь эгүүлэн татах замаар нөлөөлөх боломжийг тус тус хуулиар хязгаарлах, энэ талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох;*

1. 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйлд “Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолд; Улсын дээд шүүхийн шүүгч сум буюу сум дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй” байжээ.

2.1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-т “Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч анхан шатны

<sup>2</sup> Шүүн таслах ажиллагааны тайлан, Шүүхийн статистик мэдээ, ШЕЗ



шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт; Улсын дээд шүүхийн шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй хүчин төгөлдөр болсон шийдвэр, давж заалдах хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй” гэж заажээ.

3.Шүүгчийн бие дааж шийдвэр гаргах эрхийг зөрчсөн, шүүгчийн хараат бус байдалд халдсан шинжтэй хуулийн зохицуулалтыг 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар халсан байна.

4.Одоо үйлчилж буй Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад доод шатны шүүхийн шийдвэрт дээд шатны шүүхийн шүүгч эсэргүүцэл бичдэг агуулга бүхий хуулийн зохицуулалт байхгүй байна.

#### *Авах арга хэмжээ 1.1.4.Шүүх эрх мэдлийн байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээтэй болгох, үүнд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх*

1.Улсын Их Хурлын Байнгын хорооны 2015 оны “Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол гарсан байна. Энэ тогтоолыг үндэслэн Хууль, зүй дотоод хэргийн яам, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлсэн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслөөс шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбосон байна.

2.Бүх аймгийн шүүх, Улаанбаатар хотод байрлах Эрүү, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбосон байна. Үүнтэй холбогдуулан нийт шүүхийн интернэтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын зардлыг төсөвт үе шаттай тусган сүлжээний тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж, өндөр хурдны /1000Mbps/ интернэт ашиглаж байна.

#### *Авах арга хэмжээ 1.1.5.Гадаадын зарим орны шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх*

1.1993 онд батлагдсан Шүүхийн тухай хуульд 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн шүүхийг гадаад дотоодод бүхэлд нь төлөөлдөг байсан чиг үүргийг халж, Ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар хуульчилсан.

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийг тэргүүлэх болсноор тухайн үеийн гадаад бодлого Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай найрсаг харилцаж ирсэн уламжлалт өвөрмөц онцлогийг хадгалж, өрнө, дорнын өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцах, хамтын харилцааг хөгжүүлэх эхлэл тавигджээ.

Гэвч шүүх эрх мэдлийн байгууллагын гадаад бодлого гүйцэтгэх эрх мэдлийн харьяанд байснаар шүүх бие даан гадаад харилцаагаа хөгжүүлэхэд боломж

хязгаарлагдмал бөгөөд шүүхийн бие даасан хараат бус байдал хангагдахгүй байсан байна.

2.2002 оны Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт “Ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байна.”, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрхэд “Улсын дээд шүүхийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх”, 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэгт Шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны эрхлэн гүйцэтгэх ажлын чиг үүрэгт тухайн шүүхийн гадаад харилцааны асуудлыг хариуцахаар хуульчилсан байна.

3.2012 оны шүүхийн багц хуулиар шүүхийн захиргааны удирдлагыг бие даасан хууль /Шүүхийн захиргааны тухай/-аар зохицуулж, шүүн таслах эрх мэдлийг шүүхийн захиргааны удирдлагаас салгаж, Ерөнхий шүүгч зөвхөн тухайн шүүхийг гадаад дотоодод төлөөлөхөөр зохицуулсан байна.

Гэвч шүүхийн багц хуульд шүүхийг бүхэлд нь гадаад харилцаанд төлөөлөх асуудал бүрхэг, орхигдсон байна. Тухайлбал, Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн /Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх/ 18.1.2 дахь заалтад “Ерөнхий зөвлөлийг төлөөлөх, бүрэн эрхэд хамаарах асуудлаараа Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын, холбогдох бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;” гэж заасан, харин гадаад харилцаанд төлөөлөх асуудал хуульд тусгагдаагүй байна.

2018 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны бүтцийг шинэчлэн батлахдаа шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг уялдуулан зорилгоор Гадаад харилцааны хэлтсийг Гадаад харилцаа, хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах газар болгон өргөжүүлсэн.

Энэ зохион байгуулалт нь Шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд “сайн туршлага”-ийг судлах, дэвшилтэд арга хэлбэрийг нэвтрүүлэх, шүүгчдийн гадаад сургалтыг өргөжүүлж, нэр хүндтэй Шүүхийн институтэд шүүгчийг давтан сургалтад хамруулах, хөрөнгө оруулалтыг татах, шүүхийн захиргааны байгууллагын гадаад харилцаа хамтын ажиллагааг үр нөлөөтэй өргөтгөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж эхэлсэн.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Шүүхийн гадаад харилцааг тодорхой зохицуулж өгсөн. Тухайлбал, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт /Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх/-ад “Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх, Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгох; гэж заасан.

Мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.23 дахь заалт /Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүрэг/-ад “Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомж, Засгийн газраас баталсан журмын дагуу гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай өөрийн эрх хэмжээний асуудлаар байгууллага хоорондын гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх” гэж, мөн Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрхэд Ерөнхий зөвлөлийг тэргүүлж, дотоод, гадаад харилцаанд төлөөлөх гэж тодорхой заасан байна.

Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид, шүүхийн захиргааны ажилтны гадаад сургалтыг дэмжих, нэр хүндтэй Шүүхийн институтэд давтан сургалтад хамруулах, хөрөнгө оруулалтыг татах, шүүхийн захиргааны байгууллагын

гадаад харилцаа хамтын ажиллагааг үр нөлөөтэй өргөтгөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2023 оны байдлаар, Шүүхийн ерөнхий зөвлөл Олон Улсын хамтын ажиллагааны чиглэлээр 21 улсын холбогдох байгууллагуудтай урт болон богино хугацааны 26 санамж бичиг, 10 санхүүжилтийн болон бусад гэрээ байгуулан ажилласан байна. Мөн гадаад хамтын ажиллагааны 8 санамж бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал,

9.Монгол Улсын шүүх эрх мэдлийн салбарт дагнасан шүүхийн тогтолцоог бий болгох, шүүхийг төрөлжүүлэх бодлогын хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын туршлагаар Захиргааны хэргийн шүүхийг 2002 оноос, Япон улсын “Жайка” олон улсын байгууллагын тусламжтайгаар “Иргэний хэргийг эвлэрүүлэн зуучлах” аргаар шийдвэрлэх ажиллагааг 2013 оноос хэрэгжүүлсэн нь шүүхийн шинэтгэлийн гол үр дүнгийн нэг юм.

10.Шүүхийн ерөнхий зөвлөл хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд шүүгч, шүүхийн захиргааны ажилтны чадавхыг дээшлүүлэх, шүүхэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Герман Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн санхүүжилтийн гэрээг 2013-2023 онд жил тутам байгуулж шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтныг сургаж, хөгжүүлэх, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах, онлайн платформ бий болгох, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх орчин үеийн технологид суурилсан сургалтын арга хэлбэрийг ашиглаж нөхцөлийг бүрдүүлэн ажилласан байна.

11.Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагыг цахимжуулах бодлогыг хэрэгжүүлэх мэргэжлийн зөвлөгөө авах зорилгоор Европын холбооны “Техникийн туслалцаа, мэдээлэл солилцооны хөтөлбөр (TAIEX)”-т хамрагдаж Шүүх эрх мэдлийн байгууллагын цахимжуулалтын ажлыг Монгол Улсын Дээд шүүх, Шүүхийн сахилгын хороотой хамтран хэрэгжүүлэх эхний ажлуудыг 2023 онд амжилттай хэрэгжүүлж байна.

12.Шүүхийн ерөнхий зөвлөл нь Канад Улсын Элчин сайдын яамаар уламжлан Канад Улсын техникийн туслалцааны түншлэлийн хүрээнд “Жендерийн мэдрэмжтэй, сайжирч хөгжсөн шүүхийн тогтолцооны үр шимийг Монгол Улсын иргэд хүртэх нь” төслийг Шүүхийн сахилгын хороо, Канад Улсын Холбооны Шүүхийн Комиссарын албатай хамтран 2022 оны 8 дугаар сараас 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 7 сарын хугацаанд хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд Канад Улсын шүүхийн тогтолцоотой танилцах, туршлага судлах, Монгол Улсын шүүхийн тогтолцоонд жендерийн мэдрэмжийг нэвтрүүлэх стратеги боловсруулах, Ёс зүй, жендерийн тэгш байдал, мэргэжлийн зан үйлтэй холбоотой шүүхийн хүний нөөцийг бэхжүүлэх, хөгжүүлэх, энэ талаарх арга барил, туршлагын талаар гол оролцогч талуудад танилцуулах, олон нийтийг мэдлэг, мэдээллээр хангах, тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон талын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэв.

**Стратеги зорилт 1.2.Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль бус шийдвэрт тавих хяналтын механизм бий болгоно.**

*Авах арга хэмжээ 1.2.1.Захиргааны хэрэг дагнан шийдвэрлэх шүүх байгуулах, үйл ажиллагааг нь төлөвшүүлэх*



1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно..” гэж заасан.

2.Улсын Их Хурлаас 2002 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулиудыг баталж, 2014 оны 6 дугаар сараас нийслэл, аймаг бүрд захиргааны хэргийн бие даасан анхан шатны шүүх, Улсын дээд шүүхэд Захиргааны хэргийн танхим байгуулсан.

3.2010 онд “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай” хуулийг баталж, 2011 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллаж эхэлснээр Улсын дээд шүүх давж заалдах болон хяналтын чиг үүргийг хавсран гүйцэтгэж байсан тогтолцоог халсан байна.

4.Улсын Их Хурлаас 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр “Шүүх байгуулах тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийг тус тус баталж, нийслэл, аймаг бүрд захиргааны хэргийн анхан шатны шүүх, улсын хэмжээнд давж заалдах шатны шүүх, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим ажиллах болсноор захиргааны хэрэг, маргааны төрлөөр дагнасан шүүх ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байна.

**Стратеги зорилт 1.3.Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг боловсронгуй болгоно.**

*Авах арга хэмжээ 1.3.1.Шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангах чиглэлээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүлээх эрх, үүрэг тэдгээрийн харилцан шүтэлцээг боловсронгуй болгох талаар санал боловсруулах*

1.Монгол Улсын Ерөнхийлөгч бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох замаар шүүхийн хараат бус байдлыг улс төрийн нөлөөллөөс хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2-т “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно” гэж заасан.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-т “Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ” гэж Ерөнхийлөгч ямар нөхцөлд шүүгчийг томилохоос татгалзах зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7-д “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно” гэж зохицуулсан.

2. Улсын Их Хурал 2012 онд Шүүхийн тухай багц хуулийг баталснаар Монгол Улс шүүхийн захиргааны байгууллага бие даан ажиллах болсон.

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийн салбарт зарчмын шинжтэй дараах өөрчлөлтийг оруулсан. Тухайлбал,

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно." гэж хуульчилсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно." гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "шүүхийн үйл ажиллагааг явуулах төсвийг төр хангана." гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт "Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно." гэж заасан.

3.Засгийн газар шүүхийн жил бүрийн төсвийг бууруулах чиглэл баримталж ирсэн байдаг байна. Засгийн газар шүүхийн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахгүйгээр шууд парламентаар хэлэлцүүлдэг олон улсын тогтсон жишиг байдаг байна.

2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.3-т "шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;" гэж заасан байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.11-т "Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүнийг Ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Улсын дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжилна", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.", 27 дугаар зүйлийн 27.1.6-д "Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай Улсын дээд шүүхийг төлөөлөн харилцах;", 46 дугаар зүйлийн 46.8.3-т "Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;", 71 дүгээр зүйлийн

71.1.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах саналыг боловсруулан Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт уламжлах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,” 74 дүгээр зүйлийн 74.1.3-т “шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх,” гэж Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүлээх эрх, үүрэг, харилцааны талаар зохицуулсан байна.

4. Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасны дагуу шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох, тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах, Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох гэж заасан байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71-75 дугаар зүйлд Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахаар хуульчилсан байна.

*Авах арга хэмжээ 1.3.2. Шүүх эрх мэдлийн байгууллагуудыг ажиллах байр, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нараас үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх, цалингийн хэмжээг тогтоох, энэ талаар төрийн бүх байгууллагын хүлээх үүргийг хуулиар тодорхойлох*

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.” гэж заасан байна.

2. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэгт “Шүүх өөрийн байртай байх бөгөөд шүүх, шүүхийн захиргааны байгууллагын байр төрийн хамгаалалтад байна.”, 5.10 дахь хэсэгт “Шүүхийн байранд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэж заасан.

3. Анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн 41 тамгын газар 43 байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас 17 шүүх өөрийн байргүй (7 шүүх түрээсийн байранд, 2 шүүх актлагдсан байранд, 8 шүүх прокурорын байгууллагатай нэг байранд) байгаа бол үлдсэн 26 шүүхийн байр нь зориулалтын бус, стандартын шаардлага хангахгүй, ашиглалтын зай талбай багатай барилгад үйл ажиллагаа явуулж байна.

4. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хийсэн судалгаагаар шүүгч болон захиргааны ажилтны ажиллаж буй өрөө, тасалгааны талбайн хэмжээ Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчид ногдох норматив талбайн хэмжээнээс 2.0-5.6 дахин бага байна.

5. Шүүх хуралдааны танхим, зөвлөлдөх тасалгаа хүрэлцэхгүй байгаагийн улмаас хэргийн оролцогч өмнөх шүүх хуралдаан дуустал хүлээх, шүүх хуралдаан хойшлох, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, иргэдэд явдал чирэгдэл учруулах нөхцөл байдал нийтлэг үүсэж байна.

6. 2023 оны байдлаар, анхан болон давж заалдах шатны шүүхэд 1305 принтер ашиглаж байгаагаас 831 (63 хувь) принтерийн ашиглалтын хугацаа дууссан, 2274 компьютер ашиглаж байгаагаар 1386 (61 хувь) компьютерын ашиглалтын хугацаа дууссан байна.

7. Анхан болон давж заалдах шатны шүүхийн хэмжээнд 2013, 2014 онд хуваарилсан нотлох баримт судлах 87 төхөөрөмж, 99 проектор, 85 проекторын дэлгэц байгаа бөгөөд бүгд ашиглалтын хугацаа дууссан байна.

8. Шүүх хуралдааны явцыг дуу, дүрс бичлэгээр бичиж архивлах төхөөрөмж, шүүхийн байрны гаднах болон доторх хяналтын камер, цахим /онлайн/ хурлын төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан, эвдрэл гэмтэл их гарч байгаагаас шалтгаалан шүүхийн хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрээд байна.

9. Анхан болон давж заалдан шатны 166 шүүхэд нийтдээ 125 шүүх хуралдааны танхим байна. Үүнээс 53 шүүх хуралдааны танхимын тавилгыг 2004-2014 онд худалдан авсан ба ашиглалтын хугацаа дуусаж, хэрэглэх аргагүй байдалтай байна.

10. Шүүхэд 2015 оноос хойш хуралдааны танхимын болон шүүгч, шүүхийн захиргааны ажилтны албан хэрэгцээнд тавилга шинээр аваагүй байна.

11. Анхан болон давж заалдах шатны шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан хэрэгцээнд нийт 150 автомашин бүртгэлтэй байна. Норматив буюу ашиглалтын хугацаа дууссан 108 автомашин байна. Нөгөө талаар эдгээр 150 тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа боловч шүүхийн албан үйлчилгээнд хүрэлцэхгүй байдалтай байна.

12. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна”, 46.3-д “Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ болон нэмэгдэл олгох журам, шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно”, 46.4-д “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэж хуульчилсан.

13. Улсын Их Хурлын 2015 оны 101 дугаар тогтоолоор бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноор шүүгч хараат бус, бие даан ажиллах нөхцөлийг сайжруулахад томоохон дэвшил болсон ч түүнээс хойш улсын орны эдийн засгийн өсөлт, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ аваагүйгээс 2023 онд энэхүү цалин нь дундаж цалингийн хэмжээнд хүрэхгүй хэмжээнд байна.



14.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт “Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэж заасны дагуу шүүгчийн цалин хөлсийг тооцож олгосноор шинэ шүүгчийн цалин 40 хүртэл нэмэгдсэн, харин олон жил ажилласан зарим шүүгчийн хувьд цалин нь 630 гаруй мөнгөн төгрөгөөр буурсан байна.

*Авах арга хэмжээ 1.3.3.Шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурал жил бүр сонсож, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байхыг хуульчлах*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин есдүгээр зүйлийн 3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ...” гэж заасан.

2. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20.2.3 дахь хэсэгт нийт шүүгчийн чуулганаар Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсохоор, 81 дүгээр зүйлийн 81.1.10 дахь заалтад шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд жил бүр танилцуулахаар тус тус зохицуулсан байна. Харин шүүх үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд сонсгох зохицуулалт байхгүй. Шүүх үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд сонсгох нь “шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах зарчим”-д нийцэхгүй юм.

3.Прокурорын тухай хуулийн 49 дугаар зүйлийн 49.1-д “Улсын ерөнхий прокурор эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жилд нэгээс доошгүй удаа Улсын Их Хуралд мэдээлнэ” гэж заасан байна.

*Авах арга хэмжээ 1.3.4.Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос хуулийн төсөлд санал өгөх, хуулийг хэрэглэх явцад гарч байгаа хийдэл, доголдлын талаар албан ёсны дүгнэлт гаргах асуудлуудыг судалж хуульчлах*

1.2002 оны Шүүхийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.6 дахь заалтаар “хууль тогтоомжийг боловронгуй болгох талаар санал гаргах” бүрэн эрхийг Шүүгчдийн зөвлөлд анхлан олгосон байна.

2.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.3-т шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, санал өгөх, хууль санаачлагчид уламжлах нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх гэж зохицуулжээ.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд анхан шат, давж заалдах шатны шүүх шүүн таслах ажиллагааны практикийг судалж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа Улсын дээд шүүхэд уламжлахаар заасан.

4. Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хууль санаачлагчид уламжлах, шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах нь Улсын дээд шүүхийн бүрэн эрх байна.



5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд Улсын дээд шүүхийн дэргэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал бэлтгэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллахаар заасан ба мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.4 дэх заалтад Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, эрх бүхий этгээд, хууль санаачлагчид уламжлах талаар тусгагдсан байна.

*Авах арга хэмжээ 1.3.5.Үндсэн хуулийн цэцтэй харилцах шүүх эрх мэдлийн байгууллагуудын харилцааг боловсронгуй болгох.*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно”, 5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно”, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ”, 2 дахь хэсгийн 3 дахь заалтад Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар заасан байна.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүх эрх мэдлийн байгууллагуудаас Үндсэн хуулийн цэцтэй харилцах журмыг тодруулан заажээ.

Тухайлбал, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.5 дахь заалтад “хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх”, 25.8.6 дахь заалтад “энэ хуулийн 73.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 6.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах” 25.8.7 дахь заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах”, 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ” гэж заасан байна.

**Стратеги зорилт 1.4.Шүүхийн төсвийн хараат бус байдлыг бэхжүүлнэ.**

*Авах арга хэмжээ 1.4.1.Шүүхийн төсөв нь улсын нэгдсэн төсвийн тодорхой хувийг эзэлж байх асуудлыг судалж боломжит хувилбарыг сонгох*


1.Улсын төсөвт шүүхийн төсвийн тодорхой хувийг эзлэх асуудлаар гадаад улсын туршлагыг судлахад Үндсэн хуулийн түвшинд хуульчлах хандлага Латин

Америкийн хэд хэдэн улсуудад байна. Нэр бүхий 9 улсын туршлагыг авч үзвэл үндсэн хуульдаа шүүхийн төсвийн эзлэх доод хувийг 2-6 хувь гэж тогтоожээ<sup>3</sup>.

2.Хууль зүйн яамнаас 2000 онд батлагдсан “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх матрикс”-ын А-3.4 дэх хэсэгт “Улсын төвлөрсөн төсвийн 1 хувийг Шүүх эрх мэдэлд хуваарилах тухай асуудлыг Төсвийн тухай хуулиар хуульчлах”-аар төлөвлөсөн боловч хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн баталсан “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-т шүүхийн төсөв нь улсын төсвийн 1.5-3 хувийг эзэлсэн байна гэж заасан боловч шүүхэд хуваарилсан төсвийн хэмжээ 2013 онд улсын нэгдсэн төсвийн 0,65 хувь, 2014 онд 0,85 хувь, 2015 онд 0,82 хувь, 2016 онд 0,46 хувьтай тэнцэх хэмжээгээр баталсан. 2014, 2015, 2016 онуудад шүүхийн хөрөнгө оруулалт “0” дүнтэйгээр тус тус батлагджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.3 дахь заалтад “Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэж тус тус хуульчилсан байна.



Шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор төсөвт шүүхээс төвлөрүүлсэн орлого тогтмол өссөн дүнтэй байна. Тухайлбал, 2021 онд шүүхээс улсын тэмдэгтийн хураамж болон бусад хэлбэрийн төлбөр нийт 31.1 тэрбум төгрөгийг төсвийн орлого болгох шийдвэр гаргасан нь 2014 онтой харьцуулбал 3.4 дахин нэмэгджээ.

*Авах арга хэмжээ 1.4.2.Шүүхийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, аудитын дүгнэлт гаргуулах, тайлагнах хугацаа, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах*

1.2002 оны Шүүхийн тухай хуулийн төсөлд “...шүүхийн төсөв боловсруулах, өргөн барих, батлах аргачлал, арга замыг боловсронгуй болгох замаар шүүхийн хараат бус байдлыг сайжруулах...” тухай санал өгсөн<sup>4</sup> боловч Шүүхийн төсвийн

<sup>3</sup> Шүүхийн төсвийн хэмжээг тодорхойлсон үндсэн хуулийн зохицуулалт /Хавсралтаас үзнэ үү./

<sup>4</sup> Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, 2006 он, УБ хот, 2 дахь тал

төсөл, гүйцэтгэлийн тайланг УИХ-д шууд өргөн мэдүүлэх санал дэмжигдээгүй, Санхүү, эдийн засгийн яамны мэдэлд хараат хэвээр үлдсэн байна.

2.2002 оны Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь тус шүүхийн төсвийн, ШЕЗ-ийн даргын хувиар аймаг, нийслэл, сум, дүүргийн шүүхийн төсвийн Ерөнхийлөн захирагч болсон байна. Шүүх гүйцэтгэх эрх мэдлийн салбарын буюу яам, төрийн захиргааны байгууллагын төсөвтэй адил арга зарчмаар санхүүжихээр хуульчлагдсан байна.

3.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.1-т “Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх”-ээр заасан. Шүүхийн төсөв 2014, 2015 онд улсын төсөвт эзлэх шүүхийн төсвийн хувь анх удаа 1 хувьд хүрсэн нь ололт боловч 2014-2017 онд шүүхийн хөрөнгө оруулалтын төсөв 0 дүнтэй байсан ба шүүхийн төсвийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурал танадаг, өмнөх жилээс бууруулахыг хориглосон эрх зүйн хамгаалалтыг хүчингүй болгосон зэрэг нь Монгол Улсад шүүхийн төсвийн хараат бус байдал бүрэн бэхжээгүй гэж үзэхээр байв<sup>5</sup>.

4.Энэ хуулийн зохицуулалтыг 2016.09.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.

5.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэгт шүүхийн төсвийг боловсруулж батлах журмыг тодорхойлсон ба Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс төсвийг төлөвлөн Улсын Их хурлын байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх, байнгын хороогоор хянагдсан улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх, Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр журамласан байна.

## **Стратеги зорилт 1.5. Шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлнэ.**

*Авах арга хэмжээ 1.5.1.Шүүгчийн албан тушаалыг хаших нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хуульчийн нэр төрийн хэрэг болохуйц хэмжээнд эдийн засгийн баталгаа, хөшүүрэг бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх*

1.2002 оны Шүүхийн тухай хуульд

- Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн болон эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх;

- Улсын дээд шүүх-ийн Ерөнхий шүүгчийн цалин нь төрийн албан тушаалын зэрэг зиндаанд тохирсон, мөн шүүхийн шүүгчийн цалин нь Ерөнхий шүүгчийнхтэй буюу бусад шүүгчийн цалин нь түүнтэй зохист харьцаатай байхаар Улсын Их Хурал тогтоож байх;

- Шүүгчдэд 2 жил тутам өөр газар ээлжийн амралт, сувилалд ирж очих замын зардлыг төсвөөс олгох;

<sup>5</sup> Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, 2017 он, УБ хот, 35 дахь тал

- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний эрүүл мэндийн даатгалын мөнгөнөөс хэтэрсэн төлбөрийг болон протез хийлгэсний үнийг төсвөөс олгох;
- Хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдвал тэтгэмж, тэтгэврийн ба авч байсан цалин хөлсний зөрүүг мөн төсвөөс тэтгэвэрт гарах үед нь авч байсан 24 сарын цалинтай тэнцэх тусламж, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдвал ар гэрт нь уул шүүгчийн авч байсан цалингийн 3 жилийн нийлбэртэй тэнцэх буцалтгүй тусламж олгох;
- Улсын дээд шүүхийн шүүгчдэд төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон шаардлагатай бусад хангамж эдлүүлэх зэрэг зохицуулалт тусгасан байна.

2.2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна” гэж заасан байна. Энэ заалтын дагуу Улсын Их Хурлын 2015 оны 101 дүгээр тогтоолоор шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 2.7-3.3 сая төгрөгөөр тогтоосон байна.<sup>6</sup>

3.2021 онд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт шүүгчийн цалингийн хэмжээг эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна гэж тодорхойлж, цалин, нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их хурал тогтоохоор хуульчилсан байна.

*Авах арга хэмжээ 1.5.2.Бүх шатны шүүхийн шүүгчдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд төрөөс хөнгөлөлт, туслалцаа үзүүлэх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх журмыг боловсруулах*

1.Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолоор аймгийн ерөнхий шүүгч, прокурорт албаны (төрийн өмчийн) орон сууц эзэмшүүлэхээр заасан байна.

2.Анхан болон даж заалдах шатны шүүхийн хэмжээнд нийт 103 албаны орон сууц байгаагаас орон нутаг дахь шүүхийн Тамгын газруудад 97, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эзэмшлийн 6 албаны орон сууц байна.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөвт орон сууцны дэмжлэг үзүүлэх зардал тусгагдаагүй байна.

**Стратеги зорилт 1.6.Шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн хувьд хараат бус байх явдлыг хангана.**

*Авах арга хэмжээ 1.6.1.Шүүхийн хараат бус бие даасан байдлыг хангах үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцтэй хэрхэн харилцах асуудлыг судалж боловсруулан хуульчлах*

1.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн 1993, 2002, 2012 оны Шүүхийн тухай хуулиар өөрчлөгдөн зохицуулагдаж ирсэн байна. Шүүхийн ерөнхий зөвлөл 2013 оноос шүүхийн захиргааны бие даасан байгууллага болсон.

<sup>6</sup> Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, 2017 он, Улаанбаатар хот, 39 дэх тал



2.Монгол Улсын үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох, тэдгээрийг дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллуулахаар, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгохоор тогтоосноор Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн тодорхойлж, тогтвортой бүтэц, бүрэлдэхүүнтэй ажиллах нөхцөл бүрдэв.

3.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Шүүхийн ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлэх, Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлэхээр 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан байна.

Мөн Улсын дээд шүүхээс хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэцээс шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах, шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл харшилсан гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний талаарх саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахаар хуульчилсан байна.

Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэхээр хуульчилсан байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүгчийг хуульчдаас шилж олох, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.

*Авах арга хэмжээ 1.6.2.Хуулийн байгууллагын удирдлага болон шүүгч, прокурорыг томилох, чөлөөлөх асуудлыг улс төрийн нөлөөллөөс ангид байлгах асуудлыг судалж баталгаажуулах*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт шүүгчийг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр заасан.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилохоор, Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн



шүүгчид нэр дэвшигчтэй танилцахаар тусгасан байна. Мөн сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглохоор заажээ.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хуульд “Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ” гэж, “Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн саналыг дахин нягталж, томилохоос татгалзсан үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгох” гэж тус тус хуульчилсан байна.

4.2017 оны Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Прокурорын байгууллагыг Улсын ерөнхий прокурор тэргүүлэх бөгөөд Улсын ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилохоор, Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилохоор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон хүнийг Улсын Их Хурал дэмжихгүй бол нэг удаа өөр хүний нэрийг дэвшүүлэхээр хуульчилсан байна.

*Авах арга хэмжээ 1.6.3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн улс төрийн нөлөөнөөс аль болох ангид байлгах аргаар гишүүдийн төлөөллийг бүрдүүлэх асуудлыг судалж хэрэгжүүлэх*

1.1993 оны Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөл 12 гишүүнээс бүрдэнэ”, 33.2-д “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга албан тушаалаараа, УИХ, Ерөнхийлөгчөөс томилсон тус бүр нэг хүн, Улсын дээд шүүх сонгосон бүх шатны шүүхээс тус бүр 2 шүүгч орно” гэж тус тус хуульчилсан байна.

2.Шүүхийн тухай хуулийн 33.3 дахь хэсгийг “Ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна” гэж 1996 онд өөрчлөн найруулсан байна.

3.2002 оны Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Ерөнхий зөвлөл 14 гишүүнтэй байна”, 61.2-д “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилсон тус бүр нэг хүн, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор албан тушаалаараа, Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон Улсын дээд шүүх, аймаг, анхан шатны шүүхээс тус бүр хоёр, нийслэлийн шүүхийн нэг шүүгч тус тус орно.” гэж заасан байна.

4.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийг баталж, шүүхийн захиргааг бие даасан хэлбэрээр зохион байгуулж, бүрэлдэхүүнийг “анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно” гэж хуульчилсан байна.

5.Улсын Их Хурлаас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилохоор, тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулахаар хуульчилсан.

6.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг нарийвчлан баталгаажуулсан нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах эрх зүйн орчин бүрдсэн байна.

**Стратеги зорилт 1.7.Шүүх эрх мэдлийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн нөлөөллөөс ангид, хараат бус байх нөхцөл бүрдүүлнэ.**

*Авах арга хэмжээ 1.7.1.Шүүх эрх мэдлийн байгууллагыг хэвлэл мэдээллийн нөлөөллөөс хамгаалах болон шүүх эрх мэдэл ба хэвлэл мэдээллийн хоорондын харилцааг боловсронгуй болгох механизм бүрдүүлэх*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж заасан.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүн, аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.” гэж заасан.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 75 дугаар зүйл /Мэдээллээр хангах/-ийн 75.2.1-д “шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг захиргааны удирдлагаар хангах, шүүгчийг шилж олох, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлэх”, 75.2.2-д “шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудаст тогтмол байршуулах”, 75.2.3-д “шүүхийн цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх”, 75.2.4-д “мэдээлэл, лавлагааны үйлчилгээг зохион байгуулах”, 75.2.5-д “шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулах” гэж заасан.

*Авах арга хэмжээ 1.7.2.Шүүх эрх мэдлийн байгууллагууд иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл боловсруулах, түүнийг тогтмол хүргэж байх мэдээллийн технологи бий болгох;*

Шүүхийн захиргааны тухай хуулийн 12 дугаар зүйлээр ШЕЗ-ийг олон нийтийг мэдээллээр хангах гэсэн чиг үүргийг заасан. Уг чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014 оны 114 дүгээр тогтоолоор “Шүүх ба олон нийт” хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Шүүхийн шинэтгэлийн талаарх онцлох мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхэд чиглэсэн “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг сар тутам тогтмол зохион байгуулах, “Дэнс”, контентыг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn), шүүхийн тамгын газрын сайтуудаар дамжуулан олон нийтэд хүргэх механизм бүрдүүлжээ.

Мөн шүүхийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх “judcouncil.mn” домэйн хаяг бүхий мэдээллийн суваг, бусад цахим сүлжээ (фэйсбүүк хуудас, инстаграмм хаяг, ютүб суваг, твиттер хаяг) ажиллуулж, шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбоотой үйл ажиллагааг тус тус нийтэд мэдээлж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12-р сарын 15-ны өдөр 343 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам”-ын дагуу шүүгч өөрийн шийдвэрлэсэн хэрэгтэй холбоотой иргэнд зориулсан тойм мэдээллийг бэлтгэн, тухайн шүүхийн цахим хуудас болон “Шүүхийн шийдвэрийн тойм” фэйсбүүк хуудсаар нэгдсэн байдлаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Иргэд олон нийт, шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаар энгийн ойлгомжтой мэдээллийг цаг алдалгүй, мэдээллийн нэгдсэн сангаас хүлээн авдаг байна.

*Авах арга хэмжээ 1.7.3.Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг олон түмэнд ил тод байлгаж, хуулиар тусгайлан нууцад хамааруулаагүйгээс бусад мэдээ, мэдээллийг чөлөөтэй олгох үүрэг бүхий хэвлэл мэдээллийн албадыг төв байгууллагууд дээр бий болгох*

1.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ардчилсан нийгэм дэх ёс суртахуун, нийгмийн хэв журам буюу үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс эсхүл талуудын хувийн амьдралын эрх ашгийн үүднээс, эсхүл нээлттэй явуулах нь шүүн таслах ажлын эрх ашгийг зөрчинө гэж шүүхээс үзсэн онцгой нөхцөл байдалд, тэрхүү шүүхийн өөрийн саналаар зайлшгүй гэж тогтоосон хэмжээгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг шүүх ажиллагаанд бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт оролцуулахгүй байж болно; гэхдээ насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн (matrimonial) эхнэр нөхрийн маргаан буюу хүүхдэд асран хамгаалагч тогтоохтой холбоотойгоос бусад эрүүгийн болон иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр олон нийтэд нээлттэй байна” гэж заасан байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж хуульчилсан байна.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.1-д “шүүхийн захиргааны үйл ажиллагааны статистик мэдээлэл гаргах”, 75.1.2-д “шүүхийн санхүүгийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх”, 75.1.3-д “шүүхийн захиргааны ажлын практикийг судлах”, 75.1.4-д “шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх”, 75.1.5-д “эрх зүйн онол, практикийн судалгаа, гарын авлага зэрэг албан хэрэгцээний сан бүрдүүлж, тогтмол шинэчлэх, ашиглалтыг зохион байгуулах”, 75.1.6-д “шүүхийг Монгол Улсын хуулийн албан ёсны эхээр тогтмол хангах болон хууль тогтоомжийн актын бүртгэл, хөдөлгөөн, лавламжийн ажлыг зохион байгуулах” гэж заасан байна.

4.Улсын дээд шүүхийн тамгын газарт Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийг 2006 оноос, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албанд Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийг 2013 оноос байгуулан ажиллуулж байна.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд шүүхийн шийдвэрийг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) цахим санд байршуулдаг болсон бөгөөд 2023 оны байдлаар, шүүхийн шийдвэрийн цахим санд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн нийт 455.075 шийдвэрийг байршуулсан байна. Энэхүү цахим сан нь улсын хэмжээнд хамгийн хандалт өндөртэй сайтын нэг болсон төдийгүй шүүхийн шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах гол эх сурвалж болжээ.

Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулан архивд хадгалдаг болсон бөгөөд шүүх хуралдааны тов, тоймыг хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд нээлттэй байлгах шүүх хуралдааны явцын мэдээлэх [www.live.shuukh.mn/](http://www.live.shuukh.mn/) системийг нэвтрүүлсэн байна.

Шүүн таслах ажиллагааны статистик мэдээлэл болон шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх шатны шүүхийн Тамгын газрын цахим хуудас, пейж хуудсаар олон нийтэд шуурхай хүргэн ажиллаж хэвшсэн байна.

## **Суурь үнэлэхүй 2. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ БАЙХ**

“Шүүх эрх мэдлийн байгууллага татвар төлөгчдийн мөнгийг хамгийн үр ашигтай зарцуулах чадвар буюу түүний дотор шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан бүрийн өдөр тутмын үйл ажиллагаандаа сахих ажлын гүйцэтгэл, ёс зүйн хариуцлага хүлээх чадвар”

Стратеги зорилт: 2.1. Шүүх эрх мэдлийн байгууллага бүрийн хүлээх хариуцлагын хүрээг тодорхойлно:

*Арга хэмжээ 2.1.1. Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны алдаанаас иргэн аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг арилгах талаарх хууль тогтоомж болон түүнийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох;*

1. Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг баталж байх үед буюу 1993 оны Шүүхийн тухай хуульд шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалтгүй байсан байна.

2. 2002 оны Шүүхийн тухай хуулийн 86.5-д “шүүн таслах ажиллагааны явцад шүүгчийн гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна”, 2012 оны Шүүхийн тухай хуулийн 27.2-т “Шүүгч, шүүх бүрэлдэхүүний хэрэг, маргаан шийдвэрлэхдээ гаргасан алдааны улмаас бусдад учирсан хохирлыг төр хариуцаж, улсын төсвөөс нөхөн төлнө” гэж тус тус заасан байна.

3. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” талаар зохицуулсныг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэвээр хадгалсан байна.

4. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д “Шүүгчийн гаргасан мэргэжлийн үйл ажиллагааны алдаа, зөрчлийн улмаас хүн,



хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасны дагуу төр хариуцан арилгана.” гэж заасан байна.

5.2017 оны Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.9-д “Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.” гэж хуульчилжээ.

*Арга хэмжээ 2.1.2.Шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг хооронд нь өрсөлдүүлж харьцуулан дүгнэдэг практикийг зогсоох*

1.2012 онд батлагдсан Шүүхийн тухай багц хуулиар шүүгчдийг хооронд нь өрсөлдүүлэх боломж олгосон хуулийн зохицуулалт тусгагдаагүй. Үүний дагуу шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхүйц буруу арга хэлбэрээр шүүх, шүүгчийг өрсөлдүүлэх харилцааг зохицуулж байсан ШЕЗ-ийн 2007 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Шүүх, шүүгчийн ажлыг дүгнэх журам”-ыг хүчингүй болгосон байна.

Энэ журмыг хүчингүй болгосноор шүүх, шүүгчийн үйл ажиллагааг хооронд нь өрсөлдүүлж харьцуулан дүгнэдэг практикийг зогсоосон байна.

*Авах арга хэмжээ 2.1.3.Шүүхийн шүүн таслах ажиллагааны мэргэжлийн удирдлагыг шүүхийн захиргааны удирдлагаас ялган зааглах буюу Ерөнхий шүүгч зөвхөн шүүн таслах ажиллагааг удирдаж, Шүүхийн ерөнхий зөвлөл, тамгын хэлтэс шүүхийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх*

1.Шүүхийн шүүн таслах ажиллагаанаас захиргааны чиг үүргийг салгаж, шүүхийн захиргааны бие даасан байгууллага байх эрх зүйн орчинг 2012 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулиар бүрдүүлжээ. Тухайлбал, Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрхийг Ерөнхий шүүгч болон шүүгч хэрэгжүүлэхийг хориглоно” гэсэн маш тодорхой зохицуулсан байна.

2.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, 2021 онд шинэчлэн баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөл шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

**Стратеги зорилт: 2.2. Шүүгчийн ёс зүйн дүрэм, түүний хэрэгжилтийг хангах механизмыг бий болгох замаар шүүгчийн хариуцлага хүлээдэг тогтолцоог боловсронгуй болгоно.**

*Арга хэмжээ 2.2.1.Хуульчдын, тухайлбал шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйн онцлогийг тусгасан хэм хэмжээг боловсруулах, хуульчдад заах ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг баяжуулах*

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1997 оны 3 дугаар тогтоолоор Монгол Улсын Шүүгчдийн ёс зүйн дүрмийг анх удаа баталжээ. 1993-2002 онд шүүгч сахилгын зөрчил гаргасан эсэх маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй Шүүгчийн сахилгын хороод Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэд тус тус байгуулагдаж ажиллаж байжээ.



2.Олон улсад шүүгчийн ёс зүйн дүрмийг хэн нэгнээс хараат бусаар шүүгчийн хараат бус байх зарчимтай уялдуулан шүүгчид өөрсдөө баталдаг байна. Үүнтэй уялдуулан 2002 оны Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлд зааснаар Шүүгчийн ёс зүйн дүрмийг Шүүгчдийн зөвлөл 2002 оны 5 дугаар сарын 07-ны өдөр анх батлан гаргаж, Шүүгчдийн зөвлөлийн 2003 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор шинэчлэн баталжээ. 2010 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн ёс зүйн дүрэм” нэртэйгээр шинэчлэн мөрдөж байжээ.

3.Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлоос гадна 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай” байна гэж тусгайлсан шаардлагад шүүгчийн ёс зүйтэй байх талаар хуульчилж өгсөн байна.

4.2012 оны Шүүхийн тухай багц хуульд нийцүүлэх үүднээс Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооноос 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолоор “Шүүгчийн ёс зүйн дүрэм” нэрээр шинэчлэн баталсан. Энэ дүрмийн хэрэгжилтийг хангах “Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм”-ийг Монгол улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан байна.

5.Шүүгчдэд зориулсан шүүгчийн ёс зүйн суурь сургалтыг Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2021 он хүртэл хариуцан зохион байгуулж байсан байна.

6. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн шүүгчийн сургалтыг зохион байгуулж байна.

7.Прокурорын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-д “Улсын ерөнхий прокурорын газрын дэргэд эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, прокурорыг мэргэшүүлэх сургалт, судалгааны нэгж байна.”, 63 дугаар зүйлийн 63.1-д “Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мэдлэг, мэргэшлээ дээшлүүлж, жил бүр сургалтад хамрагдана.”, 63.2-т “Прокурорын мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг прокурорын байгууллага, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага хэрэгжүүлнэ.” гэж хуульчлан зохицуулсан байна.

8.Өмгөөллийн тухай хуульд Өмгөөлөгчдийн холбооны их хурлаар “өмгөөлөгчдийн ёс зүйн дүрэм”-ийг батлахаар, Өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй, мэдлэг, ур чадвар, үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр, Өмгөөлөгчдийн Холбооны дэргэдэх Мэргэшлийн хороо нь өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулахаар зохицуулсан байна.

*Арга хэмжээ 2.2.2.шүүгчид сахилгын хэрэг үүсгэх санал гаргах эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөл болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүнд олгох асуудлыг хуульчлах. Сахилгын хороог Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байгуулах, түүний үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох, уг хорооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих боломжийг судлан шийдвэрлэх*

1.Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороог шинээр бий болгосон байна. Хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг батлахаар заасан бөгөөд Улсын ерөнхий прокурор, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн хурал, Шүүгчдийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн нийт 15 гишүүнтэй ажиллаж байсан байна.

2.Мөн хуулийн 50.2-д Сахилгын хорооны гишүүн сахилгын хэрэг үүсгэх үндэслэлтэй эсэхийг хянаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргах, 51.1-д Сахилгын хороо сахилгын хэргийг анхан шатны журмаар гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр олонхын саналаар хянан шийдвэрлэж, тогтоол гаргах, 55.4-д Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлал эцсийнх байхаар тус тус зохицуулсан байжээ.

3.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн сахилгын хороо шинээр байгуулагдах хуулийн үндэс бүрдсэн байна.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүгчийг албан тушаалаас түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зүй зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоосон байна.

Шүүхийн сахилгын хороо нь шүүхийн төсвөөс санхүүжих, бие даасан байгууллага байх, орон тооны 9 гишүүнээс бүрдэх, гишүүд нь 6 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар зөвхөн 1 удаа сонгогдож, томилогдох, Сахилгын хороо нь Улсын хэмжээнд нэг байхаар хуульчлагдсан байна.

*Арга хэмжээ 2.2.3.Шүүгчийн ёс зүйн зөрчлийг илрүүлэх эрх бүхий байгууллага, субъектийг оновчтой тодорхойлж, хуулиар тэдний эрх, үүрэг үйл ажиллагааны журмыг нарийвчлан тодорхойлох*

2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Шүүхийн сахилгын хорооны эрх, үүрэг үйл ажиллагааны журмыг нарийвчлан зохицуулсан байна. Тодруулбал, Сахилгын хороо нь үйл ажиллагаагаа хуралдаан хэлбэрээр явуулах ба хуралдаанаас захирамж, тогтоол, магадлал гаргахаар, сахилгын хорооны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс ажлын албатай байхаар, Ажлын албаны бүтэц, орон тоо, үйл ажиллагааг зохицуулах дүрэмтэй байхаар хуульчилсан байна.

Шүүгчтэй холбоотой сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэх, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэхээр мөн хуульчилсан байна.

Үүнээс гадна, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнтэй холбоотой ёс зүйн өргөдөл мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн батлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд заасан байна.

**Арга хэмжээ 2.2.4. шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнаас албан үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл оногдуулах тохиолдолд тухайн этгээдийг биечлэн байлцуулж, тайлбар гаргах эрхээр хангах**

1.Шүүхийн захиргааны тухай хуульд ёс зүйн хэрэг үүсгэгдсэн этгээдийн эрхийн талаар нарийвчлан тусгаагүй хэдий ч тус хуулийг үндэслэн баталсан Шүүгчийн ёс зүйн хорооны дүрэмд ёс зүйн хэрэг үүсгэгдсэн этгээдийг биечлэн байлцуулж, тайлбар гаргах эрхийн талаар дэлгэрэнгүй зохицуулсан байжээ.

Тухайлбал, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3.4-т “Шүүгч ... шалгалтын материалтай танилцах, хуулбар, тэмдэглэл хийж авах, хуралдаанд биечлэн оролцох, өмгөөлөгч авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, Ёс зүйн хорооны гишүүнийг татгалзах эрхтэй” гэж заажээ. Энэхүү эрхийг баталгаажуулах хүрээнд дүрэмд заасны дагуу дараах ажиллагааг явуулна. Үүнд:

- Ёс зүйн хорооны гишүүн гомдлыг хүлээн аваад хувийг шүүгчид 2 өдөрт багтаан хүргүүлэх бөгөөд шүүгч тайлбараа 14 хоногт багтаан ирүүлэх ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайлбар ирүүлээгүй бол шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. [Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3.3.1]
- Ёс зүйн хорооны Ажлын алба шүүгчид хуралдааны товыг мэдэгдэнэ. [Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3.3.6]

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.2.1-д “сахилгын хэрэг үүсгэсэн захирамж тогтоол гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамж, тогтоолыг өргөдөл, мэдээллийн хуулбарын хамт холбогдох шүүгчид гардуулж, эсхүл энэ хуулийн 112.6, 112.7-д заасан журмаар хүргүүлж, энэ тухай баримтжуулах”, мөн хуулийн 105.2.2-д “сахилгын хэргийн оролцогчид эрх үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай баримтжуулах”, 105.3-д “холбогдох шүүгч энэ хуулийн 104.2, 104.7-д заасан сахилгын хэрэг үүсгэсэн тухай захирамж, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээллийн талаар бичгээр хариу тайлбар, нотлох баримт гаргах хүсэлт гаргаж болно” гэж заасан байна.

**Арга хэмжээ 2.2.5.Шүүгчийн шүүн таслах ажиллагааны явц дахь мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчлийн бүртгэлийг хөтөлж, дүн шинжилгээ хийх хараат бус хяналтын тогтолцоо бий болгох**

1.Шүүгч шүүн таслах ажиллагааны явцдаа хууль буруу хэрэглэж мэргэжлийн алдаа гаргасан бол хуульд зааснаар дээд шатны шүүх хянан, зөвтгөх замаар шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1-д “...Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан байна.

2.Шүүхийн мэргэшлийн хорооноос шүүгчийн мэргэжлийн алдаа, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшний үнэлгээ, дүгнэлт өгөх заалт нь 1993 болон 2002 оны Шүүхийн тухай хуульд орсон байжээ. Тодруулбал, Улсын дээд шүүхийн хуралдаан, давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч хүсэлт гаргаж аль ч шатны шүүхийн шүүгчийн, шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин, ажил хэргийн чадварын талаар дүгнэлт гаргуулах эрхтэй байсан байна.

3.2012 оны Шүүхийн багц хуулийн хүрээнд аль нэг Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүний хүсэлт, шийдвэрээр бус хуульд заасан хугацаанд буюу 3-5 жил

тутам шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшнийг дүгнэхээр зохицуулжээ. Гэвч шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшнийг дүгнэхтэй холбоотой Шүүхийн захиргааны тухай хуулийн болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалтыг 2015 оны хуулиар хүчингүй болсонд тооцжээ.

4. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, мөн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллахаар тусгаж, түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтоохоор баталгаажуулжээ. Шүүхийн сахилгын хорооны ажлын алба нь шүүгчийн сахилгын зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авах, өргөдөл, мэдээлэл гаргагчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг өгөх болон бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Шүүхийн сахилгын хороон нь Шүүхийн ёс зүйн хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна зарим талаараа өмнөх хуулийн дагуу ажиллаж байсан Шүүхийн мэргэшлийн хорооны чиг үүргийг хамтатган хэрэгжүүлж байна. Шүүхийн мэргэшлийн хорооны шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар үнэлгээ өгөх чиг үүргийг одоогийн хүчин төгөлдөр хуулийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр хуульчлагдсан байна.

### **Стратеги зорилт 2.3. Шүүх эрх мэдлийн байгууллагын нэг ажилтанд ногдох ажлын ачааллын жишиг шалгуур тогтооно.**

*Арга хэмжээ 2.3.1. шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны ажлын ачаалалд хамаарагдах үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, тэдэнд ногдох ачааллын хамгийн их хязгаарыг тогтоох*

1. 2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5- д “Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах, ...” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасан байжээ.

2. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7-д “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж хуульчилсан.

3. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.3-д “Шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог тухайн шүүхийн ажлын ачаалал, онцлогийг харгалзан Ерөнхий зөвлөл батална.” гэж заасан.

*Арга хэмжээ 2.3.2. Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны ажлыг хөнгөвчлөх, техник, тоног төхөөрөмж, гарын авлагаар хангах, туслах ажилтны орон тоог нэмэгдүүлэх*

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин найм дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заасан.

2. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-д “Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөн шүүгчээс бүрдэнэ.” гэж хуульчилсан. Одоо 23 шүүгч ажиллаж байна.



3.Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхэд 699 шүүгч ажиллах орон тооны хязгаарыг тогтоож өгсөн. Гэвч анхан болон давж заалдах шатны шүүхэд 488 шүүгч ажиллаж байна.

4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 76 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн 41 Тамгын газарт 1885 шүүхийн захиргааны ажилтан ажиллахаар орон тоог баталсан. 2023 оны байдлаар, 1458 ажилтан ажиллаж байна.

Улсын Их Хурал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тогтоосон шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтны орон тоонд хүргэж ажиллуулж чадахгүй байгаа нь төсөв, цалингийн санг хүрэлцээтэй хэмжээнд баталж өгдөггүйтэй холбоотой юм.

5. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 онд хийсэн судалгаагаар, анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн 41 шүүхийн Тамгын газарт 2124 компьютер ашиглаж байгаагаас 1296 буюу 61 хувь, 1155 принтерийн 831 буюу 72 хувь, цахим хурал хийх боломжтой дууны, дуу-дүрсний төхөөрөмж бүхий 71 танхимын 41 танхимын тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан, хэрэглээний шаардлагад нийцэхгүй болсон байна.

*Арга хэмжээ 2.3.3.Ажлын ачааллын жишгийг үндэслэн шүүгч, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулах*

1.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах, ...” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заажээ.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7-д “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж хуульчилсан.

3.Шүүхийн ерөнхий зөвлөл 2022 онд ХААИС-ийн судалгааны багтай хамтран шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлох багц судалгаа хийж, шүүгчийн зохист ачааллыг эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээр тогтоосон. Уг судалгаанд тулгуурлан шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ажлын хүрээнд өндөр ачаалалтай ажиллаж байгаа нийслэл, дүүргийн зарим шүүхэд орон нутгийн шүүхүүдээс 25 орон тоог шилжүүлэх асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж, УИХ-ын 2022 оны 79 дүгээр тогтоол гаргуулан шийдвэрлүүлсэн.

4.Шүүхийн захиргааны ажлын ачааллыг тогтоох талаар хуульд тусгайлан заагаагүй. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны ажилтны чиг үүргийн шинжилгээ хийж, ажлын зохист ачааллыг тогтоох судалгаа хийж байна.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.4-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж хуульчилжээ.

**Стратеги зорилт: 2.4. Шүүгчийн хариуцлага хүлээх зарчмын хэрэгжилтийг хангах үүднээс шүүгчийг сонгон шалгаруулах, томилох, дэвшүүлэх, огцруулах механизмыг боловсронгуй болгоно.**



*Арга хэмжээ 2.4.1.Шилдэг хуульчдыг шүүгчийн албан тушаалд татан ажиллуулах арга замыг судлан оновчтой хөшүүрэг бий болгох /сургалт, сонгон шалгаруулалт, давтан сургалт гэх мэт/ замаар хуульчдаас шүүгчийг шилж сонгох журмыг боловсронгуй болгох*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” гэж заасан.

2.2002 оны Шүүхийн тухай хуулиар шүүгчид нэр дэвшигчийг ямар шалгуураар үнэлэх талаар нарийвчилсан заалт байгаагүй байна. Энэ хуулийн 28 дугаар зүйлд нэр дэвшигч нь Үндсэн хуулийн 51.3 дахь хэсэгт заасан болзлыг хангасан, ял шийтгүүлж байгаагүй гэсэн шаардлага тавьж байсан. 2002 онд батлагдсан “Шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам”-ын 3.1-д зааснаар эрх зүйн мэдлэгийн түвшин өндөр, ажил хэргийн илүү чадвартай нэр дэвшигчийг шүүгчээр шалгаруулахыг зорьж байсан байна. Шүүхийн ерөнхий зөвлөл хуралдаанаараа Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдийг хүн нэг бүрээр хэлэлцэж, санал нууцаар хурааж, гишүүдийн олонхийн санал авсан нэг нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлдэг байжээ.

3.2012 оны Шүүхийн багц хуулиар шүүгчийн карьерын хатуу тогтолцоог зөөлрүүлж, хуульчийн мэргэжлээр ажиллаж байсан туршлагатай хүнийг шүүгчээр томилох үзэл баримтлал батлагджээ. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4-7 дугаар зүйлд шат, шатны шүүхийн шүүгчид болон ерөнхий шүүгчид тавигдах болзол шаардлагыг нарийвчлан зохицуулсан нь өмнөх зохицуулалтаас дэвшилттэй болжээ. Хуульд шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааны агуулгыг мэдлэг, чадвар, зан төлөв, ёс зүй гэсэн хүрээнд хуульчлан, хуулиас гадуур шалгуур тогтоохыг хориглож, сонгон шалгаруулалт зарлах, мэдээлэх ажиллагааг хуульчилсан байна.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.”, 34 дүгээр зүйлийн 34.1-д “... Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ.” гэж тус тус хуульчилсан.

*Арга хэмжээ 2.4.2.Шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуульд тодорхой тусгах*

1.2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана” гэж зохицуулсан байжээ.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд шүүгчид тавих болзол, шаардлагыг тодорхой тусгаж, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-д “Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ.”, 36.5-д “Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн саналыг дахин нягталж, томилохоос татгалзсан үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон

тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.” гэж хуульчилсан байна.

*Арга хэмжээ 2.4.3.Хуульч, шүүгчийн үйл ажиллагааны алдаа, зөрчлийг түүнийг томилох, дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах асуудалтай уялдуулах*

1.2002 оны Шүүхийн тухай хуульд тухайлан системтэй үндэслэл, журам тогтоогоогүй боловч Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд дараах хэм хэмжээ тусгагджээ. Үүнд:

- шүүгчээр нэр дэвшигч эрүүгийн ял шийтгэгдэж байгаагүй байх;
- ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингээр уг ажилд тэнцэхгүй гэж (Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлтээр) чөлөөлөх;
- нэг жилд ёс зүй, сахилгын зөрчил дахин гаргавал Сахилгын хорооноос зэрэг дэв бууруулах, ажлаас хасах шийтгэл хүлээлгэх;
- сахилгын шийтгэлтэйд тооцох (нэг жилийн) хугацааг хуульчилсан зэрэг нь шүүгчийн алдаа зөрчлийг томилох, дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулахтай холбож үзэх үндэслэл болно.

2.2012 онд батлагдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шат, шатны шүүхийн шүүгч болон ерөнхий шүүгчид тавих болзол шаардлагыг хуульчилсан байна. Тухайлбал анхан шатны шүүхийн шүүгчид тавих нийт 9 болзол шаардлагыг тус хуулийн 4 дүгээр зүйлээр зохицуулсан байна. Мөн давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол шаардлагаас гадна нийт 3 болзол, шаардлага тавьсан байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ болон Хуульчдын холбоо нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж, Ерөнхий зөвлөл хуралдаанаар шийдвэрлэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр тусгажээ.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд шүүгчид тавих болзол шаардлага, 32 дугаар зүйлд шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг тус тус зохицуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д зааснаар шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчээс Хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигчээс мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтыг авч үнэлгээ өгөхдөө хуульч, шүүгчийн алдаа, зөрчилд дүгнэлт хийж, мэргэшил, ёс зүйн асуудалтай уялдуулан зохицуулснаар онцлог болсон байна.

Мөн шүүгчийн гаргасан зөрчилтэй холбогдуулан сахилгын зөрчил оногдуулах, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “огцруулах”, мөн зүйлийн 56.9 дэх хэсэгт “сахилгын хороо шүүгчийг огцруулсан бол Ерөнхийлөгчид танилцуулна” гэсэн зохицуулалт тусгагдсан байна.

*Арга хэмжээ 2.4.4.Бүх шатны шүүхийн шүүгчийн ёс зүй, мэргэшлийн түвшин, ажил хэрэгч чанарыг үнэлэх шалгуурыг нарийвчлан тодорхойлж хуульчлах.*

1.2002 оны Шүүхийн тухай хуульд хуульчийг шүүгчээр шалгаруулж томилох, дэвшүүлэх, зэрэг дэв олгохдоо “ёс зүй, ажил хэрэгч чанар, мэргэжлийн түвшин”-г үнэлэх, харгалзахаар зохицуулсан байжээ.

2.2012 оны Шүүхийн захиргааны тухай хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох

үнэлгээний шалгуур болон шүүгч нь шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авахаар, түүнчлэн уг нэмэгдэл нь мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс хамаарах зэрэг асуудлыг хуульчилсан байжээ. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5-д шүүгчид тавигдах шаардлагад “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай” байх гэж заажээ.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Шүүгч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна: “31.1.5.шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх;” гэж хуульчилсан.

#### *Арга хэмжээ 2.4.5.Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарын үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг нарийвчлан тодорхойлж хуульчлах*

1.Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д зааснаар Ерөнхий шүүгч нь танхимын тэргүүний тусгайлсан бүрэн эрхийг энэ хуулиар, шүүгчийн нийтлэг бүрэн эрхийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой бүрэн эрхийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар тус тус зохицуулна гэж хуульчилсан байна. Мөн хуульд зааснаар бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусмагц нээлттэй сонгон шалгаруулалт зарлах үндсэн дээр шилж олох журам тогтоожээ. Шүүгчид тавигдах Үндсэн хуулийн болон Шүүхийн тухай хуулийн ерөнхий шаардлага, шалгуураас гадна Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд ерөнхий шүүгчид тавих шаардлагыг зохицуулсан байна. Тодруулбал, ерөнхий шүүгч нь анхан, давах, хяналтын шатны шүүхийн шүүгчид тавигдах шалгуураас гадна анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид тухайн шатны шүүхдээ 3-аас доошгүй жил ажилласан байх, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч мэргэжлээрээ болон шүүгчээр 10 жил ажилласан байх гэсэн ажлын туршлагаас гадна удирдан зохион байгуулах авьяас, манлайлах ур чадвартай байх гэсэн болзол шаардлагын дагуу шүүгчийн сонгон шалгаруулалтыг явуулахаар тус тус зохицуулжээ.

2.2012 оны Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д зааснаар Ерөнхий шүүгч нь танхимын тэргүүний тусгайлсан бүрэн эрхийг энэ хуулиар, шүүгчийн нийтлэг бүрэн эрхийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой бүрэн эрхийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар тус тус зохицуулна гэж хуульчилсан байна. Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хуульд зааснаар хэрэгжүүлж буй эсэх нь үндсэн шалгуур байхаар хуульчлагдсан байна.

#### *Авах арга хэмжээ 2.4.6.Шүүгчийг дэвшүүлэх шалгуур үзүүлэлтийг хуулиар зохицуулах асуудлыг судлах*

1.2002 оны Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд шүүгч дээд шатны болон дагнасан шүүхэд дэвшин ажиллах бол түүнийг бусад нэр дэвшигчийн адил сонгон шалгаруулалтад оролцуулахаар хуульчилсан байна.

2.2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол шаардлагыг, мөн ерөнхий шүүгчид тавигдах болзол шаардлагыг тус тус зохицуулсан. Давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол шаардлагаас гадна нийт 3 болзол, шаардлагыг тавьсан. Тодруулбал, анхан шатны шүүхэд

шүүгчээр тодорхой хугацаанд ажилласан байх, тухайн шийдвэрлэсэн хэргийнхээ талаар үнэлэлт дүгнэлт өгөх чадвартайн дээр хууль тогтоомжийн хүрээнд судалгаа шинжилгээ хийж хэвлэн нийтлүүлсэн байх зэрэг болзол шаардлагуудыг тус хуулийн 5 дугаар зүйлд зохицуулжээ. Хяналтын шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол шаардлагаас гадна хуульч мэргэжлээр ажилласан ажлын туршлагыг нэмэлт болзол шаардлага болгон хуулийн 6 дугаар зүйлд хуульчилсан байна. Мөн хуулийн 7 дугаар зүйлд ерөнхий шүүгчид тавих шаардлагыг заажээ.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид тавигдах шаардлага, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д давж заалдах болон хяналтын шатны шүүгчид нэр дэвшигчээс авах шалгалтын төрөл, түүнийг үнэлэх, оноо өгөх аргачлалыг тус тус заасан байна.

## **Стратеги зорилт 2.5. Хуульчдыг сонгон шалгаруулах нэгдмэл тогтолцоо бий болгоно.**

### ***Арга хэмжээ 2.5.1.Хуульчдыг сонгон шалгаруулах ажлыг эрхлэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх***

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хуульчийн мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, хуульчдын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх үндсэн чиг үүрэгтэй, мэргэжлийн өөрөө удирдах ёс бүхий Хуульчдын холбоог байгуулсан байна. Тус холбоо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сургалт зохион байгуулж, мэргэжлийн хөгжлийг дэмжих, хуульчийн ёс зүйн асуудлыг харьяалан шийдвэрлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### ***Арга хэмжээ 2.5.2.хуульчдыг сонгон шалгаруулах БАР-ын тогтолцоо бий болгох***

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Монгол хуульчдын холбоог байгуулсан бөгөөд тус холбоонд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хуульчдыг хамруулсан байна. Тухайлбал, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад субъектүүдийг энэ холбоонд оруулж, БАР-ын тогтолцоог бий болгосон байна.

2.2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгчдийн өөрөө удирдах ёсны төрийн бус байгууллага Өмгөөлөгчдийн холбоо байгуулагдсанаар Хуульчдын холбооны гишүүнчлэлээс өмгөөлөгч нарыг салгасан байна.

### ***Арга хэмжээ 2.5.3.Хуульчдыг сонгон шалгаруулахад баримтлах ёс зүйн шалгуурыг боловсруулах, цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох***

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар байгуулагдсан Монголын хуульчдын холбоо дотроо Мэргэжлийн хариуцлагын хороо, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалтын үйл ажиллагаа хариуцсан Шалгалтын зэрэг мэргэжлийн хороотой байна.

Монголын хуульчдын холбоо нь өөрөө удирдах ёсны байгууллага болохын хувьд шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын төлөөллийг оролцуулсан



холбооны Удирдах зөвлөлийг дотроосоо сонгон байгуулсан ба тус зөвлөл нь шалгалтын бодлого, бусад үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажилладаг байна. Хууль зүйн яам, Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл хамтран 2013 онд Хуульчийн ёс зүйн гарын авлагыг боловсруулж, түүнд тулгуурлан Хуульчийн ёс зүйн дүрмийг баталжээ.

### **Суурь үнэлэхүй 3.МЭДРЭМЖТЭЙ БАЙХ**

*“Шүүх эрх мэдэлд тавигдаж байгаа нийгмийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан харж, өөрчлөлт шинэчлэлтийг цаг тухайд нь хийж байх чадвар”*

**Стратеги зорилт: 3.1. Нийгмийн эрэлт хэрэгцээ, эрх зүйн орчинд тогтмол судалгаа явуулах, түүний дагуу арга хэмжээ авна.**

*Арга хэмжээ 3.1.1.Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хуулийн хэрэгжилтийн байдал, тэдгээрийн талаарх олон нийтийн саналыг судлах, хуульч, шүүгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийн нэр хүндийн талаарх олон нийтийн санаа бодол болон статистик мэдээнд боловсруулалт хийж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хэрхэн ашиглах талаарх судалгааг мэргэжлийн түвшинд явуулах судалгааны төв байгуулан ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх*

1.Энэ арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоолоор Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг байгуулж, төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 222 дугаар тушаалаар баталсан байна. Тус байгууллага нь шүүх эрх мэдлийн болон түүнд оролцогч бусад байгууллагын үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, тэдгээрийн ажилтны боловсролын түвшнийг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлийг дээшлүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Засгийн газрын харьяа байгууллага бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн судалгаа, мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиг үүргийг гүйцэтгэж байна. Тус хүрээлэн шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаатай шууд холбоотой ажилладаггүй.

2.2012 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 11, 12 дугаар зүйлээр шүүхийг судалгаа, мэдээлэл, мөн олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийг шүүхийн захиргааны байгууллага буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулсан бөгөөд мөн хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулжээ. Тус хүрээлэн шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, шүүхийн практик судлалын чиг үүргийг хэрэгжүүлэн 2021 оны 03 дугаар сарын 01-нийг хүртэл ажилласан байна.

3.”Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2011, 2003, 2005 онуудад Сант-Марал судалгааны төвөөр шүүхэд хандах хандлага, үзүүлэх итгэлийг судлах зорилгоор олон нийтийн дунд судалгаа явуулсан байна.

4.Шүүхийн захиргааны тухай хуулийн 12.1.6-д “шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг авах” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл гүйцэтгэхээр заасны дагуу шүүхийн талаар олон нийтийн санаа бодлыг судлах

ажлыг шүүхийн захиргааны байгууллага 2013 оноос хойш тодорхой давтамжтай хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшнийг 2015, 2016, 2017 онуудад өөрөө болон бусдаар тодорхойлуулсан байна. Тухайлбал, 2015 онд "Хөгжлийн эрэлд" судалгааны төв болон Нээлттэй нийгэм форумаас, 2016 онд Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс тус тус судалгаа хийсэн.

5.Нээлттэй нийгэм форумаас шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин тодорхойлох "Шүүхийн индекс" судалгааг 2021 онд хийж Шүүхийн ерөнхий зөвлөлд 2022 онд танилцуулсан.

6."Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлогыг боловсруулах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газруудтай хамтран 2022 онд асуумжийн аргаар иргэдийн шүүхэд итгэх итгэлийн судалгааг 2022 онд хийсэн.

7.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлаас баталсан шинэчлэн найруулж баталсан 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнг байгуулжээ. Тус хүрээлэн шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан шүүгчдэд сургалт зохион байгуулах; бүх шатны шүүхийн шүүн таслах ажлын практик, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг салбар эрх зүй, хэрэг, маргааны төрөл зэрэг чиглэлээр судалж, шүүх, шүүгчдийг судалгаа, мэдээллээр хангах; Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах; шүүн таслах ажлын хууль хэрэглээний талаарх судалгаанд үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах; шүүхийн статистикийн нэгдсэн мэдээг батлагдсан маягтын дагуу шүүхүүдийн Тамгын газраас цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх; шүүхийн шинэчлэл, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлахад оролцох; онол, арга зүй, мэдээллийн улирал тутмын "Монголын төр, эрх зүй" сэтгүүл, Хүрээлэнгийн үйл ажиллагааны цахим сонин гаргах; хууль тогтоомжоос бусад эрх зүйн актын нэгдсэн бүртгэл, лавлагааны сан бүрдүүлж, шүүхийг мэдээллээр хангах; сургалт, судалгаа, мэдээллийн бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох; олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурал, сургалт, семинар зохион байгуулж, хууль зүйн шинжлэх ухаан, шүүхийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Арга хэмжээ 3.1.2.Холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор шүүн таслах ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах үүргийг Шүүхийн тамгын хэлтэст хуулиар олгох, уг ажилд шаардлагатай техник технологи, гарын авлага, мэдээллээр тэднийг хангах асуудлыг хуульд тусгаж өгөх, сургалт зохион байгуулах*

1.Шүүхийн захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжид санал өгөх.", 11 дүгээр зүйлийн 11.1.3-д "Шүүн таслах ажиллагааны болон захиргааны ажлын практикийг судлах,", 11.1.4-д "Шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх" үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заажээ.

2.Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дээрх чиг үүргийг анхан болон давж заалдах шатны шүүхэд түүний Тамгын газар хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээсэн байна.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 5.2.5-д шүүхийн тамгын газар шүүн таслах ажлын төрлөөр бүртгэл хяналтын программд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийг цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, нэгдсэн программыг шүүгч, шүүхийн захиргааны ажилтан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашиглах нөхцөлийг бүрдүүлэхээр заажээ.

4.Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүн таслах ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах ажилд шаардлагатай техник технологи бүрдүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхүүдийн хооронд хэргийн шийдвэрлэлтийн явцыг цогцоор нь харах, хэргийн хөдөлгөөний мониторинг хийх, цахим сангаас мэдээлэл хайх ажиллагааг иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Иргэн, Эрүү, Захиргааны хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын нэгдсэн программыг үе шаттайгаар ашиглалтад оруулан ажиллаж байна. Үүнд:

- 2011-2013 онд иргэн-1, иргэн-2 программыг ашиглалтад оруулж шүүхүүдэд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд тухайн үед шилэн кабель байхгүй байсантай холбоотой Иргэн-1 программ шүүх тус бүр дээр тус тусдаа ажилладаг байсан. Харин 2014 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дата төв байгуулж, шүүхүүдийг шилэн кабелиар холбосноор “Иргэн 2014” нэгдсэн систем болгон нэгтгэж, хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн.

- Шүүхийн шийдвэрийн цахим санг /www.shuukh.mn/ 2012 онд нэвтрүүлэн тус системд шүүхийн шийдвэрийг нээлттэй, ил тод байршуулан олон нийт хүргэж байна.

- Захиргааны хэргийн шүүхийн бүртгэл хяналтын системийг 2013 онд захиргааны хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд нэвтрүүлсэн бөгөөд үүнээс хойш хэрэглэгчдийн саналыг үндэслэн тус системд хэд хэдэн сайжруулалт хийгдэж өнөөдрийн байдлаар Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг нийт захиргааны хэргийн шүүхүүд өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

- Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа 2013 оноос шүүхийн практикт шинээр нэвтэрч, үр дүнгээ өгч, иргэний хэргийн шүүхийн ачааллыг бууруулж байгаатай холбогдуулан эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны бүртгэл тайлангийн программыг 2015 онд ашиглалтад оруулан ашиглаж байна.

- Эрүү, иргэн, захиргааны хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхэд оролцох иргэдийн төлөөлөгчийг сонгон бүртгэх, бүртгэсэн жагсаалтаас цахим хэлбэрээр тохиолдлын журмаар сонгон шүүх хуралдаанд оролцуулах, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцсон талаар тайлан мэдээ, статистик тоо баримт гаргах зориулалттай дотоод цахим системийг 2018 онд нэвтрүүлэн ашиглаж байна.

- Шүүхийн эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг 2017 оноос бүх шатны эрүүгийн хэргийн шүүхүүдэд нэвтрүүлэн ашиглаж байна.

- Анхан болон давж заалдах шатны шүүхийн хэмжээнд эрэн сурвалжлах албадан ирүүлэх захирамжийг бүртгэх, уг захирамжийн дагуу цагдаагийн байгууллага холбогдох ажиллагааг хийхэд зориулагдсан цахим системийг 2018 онд ашиглалтад оруулан ашиглаж байна.

○ “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээс шүүхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолт татах “Шүүхийн цахим лавлагааны систем”-ийг 2020 онд иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд нэвтрүүлснээр 18 төрлийн мэдээлэл татан авч шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар үнэлэх нөхцөлөөр хангагдсан.

○ Бүх шатны шүүхийн шүүх хуралдааны тов, шүүх хуралдааны явцын мэдээлэл, шүүх хуралдааны тоймыг олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар текстэн хэлбэрээр хүргэх зориулалтай live.shuukh.mn цахим системийг 2020 онд ашиглалтад оруулсан.

○ Хэргийн хөдөлгөөний удирдлагын E-CASE системийг 2021 онд нэвтрүүлсэн. Энэ систем нь эрүү, иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системүүдэд хэрэглэгчийн буруугаас болон системийн алдаанаас шалтгаалан гарсан алдааг залруулах, өгөгдлийн санд засвар өөрчлөлт хийх хүсэлтийг ШЕЗ цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг систем юм.

5. Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газарт ажиллаж байгаа мэдээллийн технологийн мэргэжилтнийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулдаг шүүхийн захиргааны ажилтны сургалтад тодорхой давтамжтай хамруулан мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

*Арга хэмжээ 3.1.3. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хандлагыг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий судалгааны төв байгуулж ажиллуулах*

1. Улсын дээд шүүхийн Судалгааны төвийг Шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн статистик, практикийг нэгтгэн судалж, сана дүгнэлт хийх үндсэн дээр хууль хэрэглэх, тайлбарлахад эрх зүйн онол, практикийн зөвлөмж өгөх үүрэгтэй байхаар өөрчлөн зохион байгуулсан байдаг.

2. Хууль зүйн үндэсний төвд 2003 онд Криминологийн судалгааны сектор байгуулсан байна.

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах ажлыг эрхлэх эрдэм шинжилгээний байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний харьяанд ажиллаж, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа баримтална.”, 24.2-т “Энэ хуулийн 24.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон сонирхогч бусад хүн, хуулийн этгээдийн захиалгаар гүйцэтгэж, санхүүжнэ.” гэж тус тус заажээ.

4. Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүнд “гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн нь гэмт явдал, цагдаа судлалын чиглэлээр суурь болон хавсарга судалгааны ажил гүйцэтгэх, салбарын яам, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, төрийн бусад байгууллагын захиалга, гэрээгээр бодлогын болон хэрэглээний судалгаа хийх” чиг үүрэг бүхий Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн<sup>7</sup> ажиллаж байна.

*Арга хэмжээ 3.1.4. Хэрэг, маргааныг эвлэрлийн аргаар шийдвэрлүүлэх, цаазаар авах болон хорих ялаас аль болох татгалзах, бусад ялыг илүү өргөн*

<sup>7</sup> <https://www.uia.gov.mn/listener/19>



## *хэрэглэх, ялтныг засан хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн “амьд явах эрхтэй. Эрүүгийн хуульд заасан онц хүнд үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглоно” гэж хүний амьд явах эрхийг баталгаажуулсан.

2.УИХ-аас Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт 2-р протоколд нэгдэн орох тухай хуулийг 2012 онд баталсан байна.

3.Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2002 оноос хойш батлагдсан Иргэн, Эрүү, Захиргааны процессын хуулиудад талуудын хүсэлтээр хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх зохицуулалт тусгагдан хэрэгжиж байна.

4.2015 онд батлагдаж, 2017 оноос хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар цаазаар авах ялыг халсан бөгөөд ял шийтгэлийн төрлийг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах, албадан ажил хийлгэх, хорих гэсэн төрлөөр ногдуулахаар зохицуулсан байна.

5.2012 онд батлагдаж, 2013 оноос хэрэгжиж байгаа Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дагуу эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй шийдвэрлэх тогтолцоо Монгол Улсад нэвтэрч, амжилттай хэрэгжиж байна.

### **Стратеги зорилт 3.2.Хэрэг, маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх арга механизмыг өргөжүүлэх, боловсронгуй болгоно.**

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2013 оноос хэрэгжиж эхэлснээр эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа Монгол Улсад шинээр нэвтрэн төлөвшсөнөөр иргэд хоорондын ойлголцол, харилцан зөвшилцлийг бүрдүүлж, иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт ирсэн маргааны ачааллыг 20 орчим хувиар бууруулж байна.

Монгол Улс шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх тогтолцоотой болсон нь шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон ололтын нэг юм.

**Арга хэмжээ 3.2.1.Талууд хэргийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч, эвлэрэхийг харилцан зөвшөөрч байгаа үед тэднийг эвлэрүүлэх арга хэмжээ авах, ээдрээ, төвөг багатай хэрэг, маргааныг чирэгдэл багатай, бага хугацаанд шийдвэрлэх арга зам бий болгох, зуучлалын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж шийдвэрлэх;**

1.Дэлхийн улс орнуудад иргэний болон гэр бүлийн эрх зүйн хэрэг, маргааныг шүүх, арбитрын журмаар шийдвэрлэхээс гадна шүүхийн бус журмаар гуравдагч этгээдийн дэмжлэгтэйгээр талуудыг эвлэрүүлэн, маргааныг шийдвэрлэх аргыг хэрэглэх болжээ. Эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо Монгол Улсад 2014 оноос нэвтэрч амжилттай хэрэгжиж байна.

2.Шүүхийн ерөнхий зөвлөл эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах зэрэг ажлыг зохион байгуулж ирснээр шүүх

дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хуульд заасан нөхцөл, журмын дагуу тогтмол, хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн.

3.Шүүхийн ерөнхий зөвлөл Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон “Интерактив” ХХК-тай хамтран “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны бүртгэлийн нэгдсэн систем”-ийг боловсруулан 2015 оноос шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн. Уг бүртгэлийн нэгдсэн системийг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нийт процесс буюу өргөдөл хүлээн авахаас эхлэн эвлэрлийн гэрээг шүүхийн захирамжаар баталгаажуулах хүртэлх ажиллагаанд хэрэглэж байна.

4.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Анхан шатны шүүх дээр орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллана." гэж заасны дагуу иргэний хэргийн анхан шатны 37 шүүхэд 45 эвлэрүүлэн зуучлагч, 40 эвлэрүүлэн зуучлагчийн туслах ажиллаж байна.

5.2022 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 22059 өргөдөл, шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн шилжүүлсэн 2 нэхэмжлэл, шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлсэн иргэний хэрэг 553 байна. Дээрх 22059 өргөдлөөс 14646 өргөдлийг шийдвэрлэж, 9373 буюу 64.0 хувьд нь эвлэрэл амжилттай болсон байна. 2022 онд нийт 45895 (хэрэгсэхгүй болгосон хэргийг хассанаар) иргэний хэрэг шийдвэрлэсэн ба шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар 9373 өргөдлийг амжилттай шийдвэрлэсэн нь иргэний хэргийн 16.9 хувь байна.

*Арга хэмжээ 3.2.2.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд арбитр, зуучлагч, хөндлөнгийн шүүхийн оролцоог дээшлүүлэх боломжийг судлах, эрх зүйн орчин бүрдүүлэх;*

1.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зохицуулах ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсад шүүх дэх болон төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлал гэсэн холимог загвар хэрэгжих хуулийн үндэс бүрдсэн.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дүрэм, тус зөвлөлийн хуралдааны дэг, Эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, бэлтгэх, давтан сургах журам, Шүүх дэх орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийн ажлын хөлс, зардал, урамшуулал олгох журам, Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн зөрчлийг шалгах үйл ажиллагааны журам, шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрэглэгдэх баримт, тэмдэглэлийн 13 төрлийн загвар, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны албан хэрэг хөтлөлтийн загварыг баталснаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах эрх зүйн орчин бүрэн бүрдүүлсэн.

3.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно” гэж заасны дагуу Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв 2014 оноос ажиллаж байна. Уг төвд 16 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байгаагийн 14 эвлэрүүлэн зуучлагч нь олон улсын эвлэрүүлэн зуучлах эрхтэй байна.

4.Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д "Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно." гэж заасны дагуу Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр нь 1960 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. Монголын олон улсын 77 арбитрч ажиллаж байгаагийн 52 нь монголын арбитрч, 25 нь олон улсын арбитрч байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Арбитрын тухай хууль батлагдан, шинэчлэгдэж ирснээр Монгол Улсад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд арбитр, зуучлагчийн оролцоог хангах эрх зүйн бүрдсэн байна.

*Арга хэмжээ 3.2.3.Ээдрээ, төвөгтэй боловч талууд нь эвлэрэх сонирхолтой байгаа хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэдэг талаар зарим орны шүүхийн практиктэй танилцаж, нэвтрүүлэх боломжтой эсэхийг судалж шийдвэрлэх*

Монгол Улс шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх тогтолцоог Япон улсын туршлага, туслалцаатайгаар нэвтрүүлсэн байна.

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага "ЖАЙКА" болон Монгол Улсын Дээд шүүхийн хооронд "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2010-2015 онд 2 үе шаттай хэрэгжүүлснээр эвлэрүүлэн зуучлалын хууль, эрх зүйн орчин шинээр бүрдэж, "ЖАЙКА"-ын туслалцаатайгаар эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлалын сургагч багш нарыг сургаж бэлтгэн, шүүхэд эвлэрүүлэн зуучлагч ажиллах орчин, нөхцөлийг анхлан бүрдүүлсэн байдаг.

Шүүхийн ерөнхий зөвлөл "ЖАЙКА" байгууллагын санхүүжилтээр "Эвлэрүүлэн зуучлалын хүний нөөцийг чадавжуулах бэхжүүлэх" сургалтыг 2014, 2015, 2016 онуудад 3 удаа Япон улсад зохион байгуулж, 12 эвлэрүүлэн зуучлагч, 40 сургагч багш, нийтдээ 50 гаруй хүнийг Япон улсад сургасан байна.

Түүнчлэн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх "Бизнесийн маргааныг эвлэрүүлэн эвлэрүүлэн зуучлах төв"-ийн эвлэрүүлэн зуучлагчдыг бэлтгэх зорилгоор 2014 оны 3 дугаар сард Европын Сэргээн Босголт хөгжлийн банкны тусламжтайгаар эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтыг явуулж, уг сургалтаар олон улсын эвлэрүүлэн зуучлал хийх эрх бүхий 15 эвлэрүүлэн зуучлагч бэлтгэжээ.

Монголын хууль зүйн салбарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх шинжлэх ухааны болон онол арга зүйн аливаа судлагдсан бүтээл, сурах бичиг, гарын авлага байхгүй байсантай холбогдуулан 2014-2018 онуудад "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах" төсөл, Хуульчдын холбооны "эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дэмжих" хороотой хамтран эрдэмтэн судлаач, хуульч, оюутан сурагчдын хүрээнд "Эвлэрүүлэн зуучлалын тухай" эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааныг зохион байгуулж, оролцсон илтгэлийн эмхэтгэлийг 2 удаа хэвлэн олон нийтэд хүргэсний зэрэгцээ "Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага"-ыг бэлтгэн хэвлүүлж, эвлэрүүлэн зуучлагчдад хүргэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014-2022 онуудад эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтыг нийт 21 удаа, орон нутагт 15 удаа зохион байгуулж, нийт 882 эвлэрүүлэн зуучлагч бэлтгэсэн.

Эрүү, захиргааны хэрэг, маргаанд эвлэрүүлэн зуучлах эрх зүйн орчин байхгүй байна.

### *Арга хэмжээ 3.2.4.Арбитрын шүүхийг боловсронгуй болгох, арбитрын хуралдаанд оролцогч талууд өөрийн эрх ашгаа хамгаалах асуудлыг өргөжүүлэх*

1.Арбитрын тухай хуулийн 3.1-д “Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.” гэж заажээ.

2.Арбитрын тухай хуулийн 30.1-д “Арбитрын ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба талууд өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана.”, 31.1-д “Талууд арбитрын ажиллагааны журмыг энэ хуулийн хүрээнд чөлөөтэй тохиролцон тогтооно.”, 39.1-д “Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр талууд нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болох бөгөөд шүүх уг хүсэлтийг эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан нотлох баримт гаргуулах журмын дагуу шийдвэрлэнэ.”, 43.1-д “Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрсэн бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг дуусгавар болгох ба талууд ийнхүү хүсэлт гаргасныг арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаж баталгаажуулна.” гэж заажээ.

3.Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлд арбитрын хэлэлцээр, түүний хэлбэрийг, 9 дүгээр зүйлд арбитрын харьяаллын маргааныг, 11 дүгээр зүйлд Арбитрын хэлэлцээр ба шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар шүүхээс авах арга хэмжээг, 13 дугаар зүйлд арбитрчийг томилох журам, 14, 15 дугаар зүйлд арбитрчийг татгалзан гарах үндэслэл, журмыг, мөн хуулийн Тавдугаар бүлэгт арбитрын үйл ажиллагааг, Зургаадугаар зүйлд арбитрын үндсэн шийдвэр гаргах, арбитрын ажиллагаа дуусгавар болох харилцааг нарийвчлан зохицуулжээ.

### **Стратеги зорилт: 3.3.Хууль тогтоомжийг нийгмийн эрэлт хэрэгцээний дагуу шуурхай өөрчлөх санал гаргана.**

*Арга хэмжээ 3.3.1.шүүн таслах болон байцаан шийтгэх ажиллагааны явцад гарч байгаа хуулиар зохицуулах шаардлага бүхий харилцааны эрэлт хэрэгцээг нэгтгэн судалж, хууль санаачлагчид уламжилдаг тогтолцоо бий болгох асуудлыг судлах*

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулахад Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам голлох үүрэгтэй ажиллаж байна.

2.Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.3-т “шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, санал өгөх, хууль санаачлагчид уламжлах”, 6.1.4-т “шүүх байгуулах, өөрчлөн байгуулах асуудлыг боловсруулан Засгийн газартай зөвшилцөн Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/-д уламжлах”, 6.1.5-т. “шүүхийн зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад уламжлах” гэж тус тус заажээ.

3.Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5 дахь заалтад “шүүхийн болон гэмт хэргийн статистик мэдээлэл гаргах, шүүхийн статистикийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх, шүүхийн шүүн таслах болон захиргааны



ажлын практикийг судлах, шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, эрх зүйн онол, практикийн судалгаа, гарын авлага зэрэг албан хэрэгцээний сан бүрдүүлж, тогтмол шинэчлэх, ашиглалтыг зохион байгуулахыг хуульчилснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнг байгуулан ажиллуулж байжээ.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйл (Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх)-ийн 25.8.3-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хууль санаачлагчид уламжлах” гэж заасан байна.

5.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.4-д “шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, эрх бүхий этгээд, хууль санаачлагчид уламжлах”, 71.1.2-д “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах саналыг боловсруулан Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт уламжлах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах”; 71.1.4-д “шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, эрх бүхий этгээд, хууль санаачлагчид уламжлах” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр хуульчилсан байна.

**Стратеги зорилт: 3.4. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдлагыг боловсронгуй болгоно.**

*Арга хэмжээ 3.4.1.Шүүхийн удирдлагын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, байцаан шийтгэх ажиллагааны болон шүүхийн захиргааны удирдлагын зааг ялгааг тогтоож оновчтой тодорхойлох*

1.Улсын Их Хурлаас 2012 онд Шүүхийн багц хуулийг баталж, тус хуулийн дагуу шүүн таслах ажиллагааны болон шүүхийн захиргааны удирдлага тусдаа байхаар хуульчилснаар Шүүхийн ерөнхий зөвлөл бие даан ажиллах болсон.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” гэж, 5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж хуульчилсан.

3. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 70 дугаар зүйлд зааснаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зорилго бүхий шүүхийн захиргааны төв байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан байдлыг хангах; шүүхийг хүний нөөцөөр хангах; шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль

ёсны ашиг сонирхлыг хамгаалах; шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах; мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д “Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.”, 76.2-т “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.” гэж заасан.

*Авах арга хэмжээ 3.4.2.Ажлын ачааллыг харгалзан шүүгч, прокурорыг адил шатны шүүх, прокурорын байгууллагад түр томилон ажиллуулах, тухайн шүүгч, прокурортой зөвшилцсөний үндсэн дээр тодорхой хугацаанд сэлгэн ажиллуулах асуудлыг хуулиар зөвшөөрөх*

1.Улсын Их Хурлаас 2002 онд баталж, 2012 онд хүчингүй болгосон Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дунд, дүүргийн шүүхийн шүүгчийн шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, боловсон хүчнийг оновчтой байршуулах зорилгоор, адил шатны шүүхэд өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулж болно” гэж, 42.3-д “Энэ хуулийн 42.1-д зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана”, 62 дугаар зүйлийн 62.1.4-т “Шүүгчийг томилуулах, сэлгэн ажиллуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх” зохицуулалтыг тус тус анх удаа хуульчилжээ. Мөн Улсын дээд шүүхийн шүүгчийг Ерөнхий шүүгчийн шийдвэрээр танхим хооронд сэлгэн ажиллуулж болохоор хуульчлагдсан байна.

2. 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т “Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно” гэж зааснаас өөр хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс шүүн таслах ажлын туршлага, ажилласан жил, мэдлэг, ур чадвар, тухайн нутаг дэвсгэр, харьяалал нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөл байдал зэргийг тодруулах ямар ч боломжгүй байсан байна.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.7-д “Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2016 оны 47 дугаар тогтоолоор “Шүүгч томилолтоор ажиллах нийтлэг журам”-ыг баталсан байна. Уг журмаар эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх таслах ажиллагааг хуульд заасан дэг журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр түүний гаргасан хүсэлтийн дагуу 3 ба түүнээс дээш сараар анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг адил шатны шүүхэд томилолтоор ажиллуулах боломжтой болсон байна. Шүүгч томилолтоор ажиллахад Шүүхийн ерөнхий зөвлөл тогтоол гаргаж шийдвэрлэдэг байжээ.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Шүүгчийн мэргэшил, чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны шүүхэд хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.”, мөн хуулийн 43.4-т “Энэ хуулийн 43.3-т заасан үндэслэлээр шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж тус тус заасан

Хуулийн дээрх заалтыг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөл 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Шүүгчийг сэлгэн ажиллуулах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

#### **Суурь үнэлэхүй 4. ШУДАРГА БАЙХ**

“Аливаа этгээдэд хүндэтгэлтэй хандаж, ямар ч тохиолдолд хуулийг чанд, нэг мөр хэрэгжүүлдэг байх чадвар”

**Стратеги зорилт 4.1. Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан хууль тогтоомжийг зөв хэрэглэж, чанд мөрддөг байна.**

*Арга хэмжээ 4.1.1. шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гарсан эргэлзээтэй, хоёрдмол утгаар ойлгож болох хуулийн заалтуудын талаарх санал бодлыг тухай бүр бүртгэн нэгтгэж танилцуулсны үндсэн дээр Улсын дээд шүүхээс тайлбар гаргуулах механизм бүрдүүлэх асуудлыг судлах;*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд зааснаар Улсын дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” үүрэгтэй байна.

Эл үндэслэлийг хэрэгжүүлэхийн тулд 2002 оны Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “Шүүх тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал оруулна. Улсын дээд шүүх уг саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ мэдүүлнэ.”, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах. Улсын дээд шүүхийн тайлбарыг тухайн хуулийг хэрэглэж байгаа хүн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө” гэж нарийвчлан зохицуулжээ.

2.2012 оны Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т Улсын дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж зохицуулсан байна.

Үндсэн хуулийн цэц нэр бүхий иргэдийн гаргасан гомдлын дагуу маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн 2015 оны 10 сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг тус тус зөрчсөн гэж хүчингүй болгожээ.

3.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтад Улсын дээд шүүх “шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах ...” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.”, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “... Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, ... бэлтгэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.” гэж заажээ.

Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхим шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулахаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-т зохицуулжээ.

Прокурорын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх асуудлаар тайлбар гаргуулахаар Улсын дээд шүүхэд санал оруулж болно.” гэж заасан байна.

Улсын дээд шүүхээс 2022 онд 5, 2023 онд 2 удаа хуулийн албан ёсны тайлбар гаргасан байна.<sup>8</sup>

*Арга хэмжээ 4.1.2.шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудад шинээр батлагдан гарсан хуулийг цаг алдалгүй хүргэх тогтолцоо бий болгох;*

1.Хууль зүй дотоод хэргийн яамнаас санаачлан Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) сайтыг 2006 онд нэвтрүүлсэн бөгөөд өдгөө нийтийн хүртээл болсон байна.

“Legalinfo.mn” эрх зүйн нэгдсэн системд шинээр батлагдсан хуулийн өөрчлөлтийг тухай бүр оруулан баяжуулж байгаа бөгөөд уг системийг шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагч үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.

2.Шүүхийн эрх мэдлийн байгууллага болон Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын прокурорын ерөнхий газар, тэдгээрийн харьяа байгууллагууд өөр, өөрийн цахим хуудсанд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг байршуулан тэдгээртэй танилцах, ажил хэрэгтээ ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

3.Монгол Улсын шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.20-т “шүүхийг Монгол Улсын хуулийн албан ёсны эхээр тогтмол хангах болон хууль тогтоомжийн актын бүртгэл, лавламжийн ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2013 оноос эхлэн шүүх, шүүгчийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлээр үнэ төлбөргүй хангах ажлыг тасралтгүй хэрэгжүүлж ирсэн байна. Түүнчлэн Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач

---

<sup>8</sup> <https://www.supremecourt.mn/home?page=advice&id=15&pr=0&tp=list&h=0>



холбогдолтой шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлэн нийтийн хүртээл болгож байна.

4.Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-ийг шүүх, шүүгчдэд үнэ төлбөргүй хүргэж, шинээр гарсан нийтээр дагаж мөрдөх актуудтай танилцах боломжоор хангаж байна.

5.Онол, арга зүй, мэдээллийн улирал тутмын "Монголын төр, эрх зүй" сэтгүүл, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийг улирал тутам эрхлэн гаргаж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажилтны хүртээл болгож байна.

6.Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хууль тогтоомжоос бусад эрх зүйн актын нэгдсэн бүртгэл, лавлагааны сан бүрдүүлж, шүүхийг мэдээллээр хангаж байна.

*Арга хэмжээ 4.1.3.Шүүн таслах ажиллагаанд шинээр гарч байгаа аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх асуудлаар шүүгчдэд нэгдсэн ойлголтыг шуурхай олгодог механизм бий болгох;*

1.2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 10.1.4-д “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Хуульчдын холбоо, Төрийн албаны зөвлөл болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах” гэж зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс шүүгчийн сургалтыг бүлгийн, ганцаарчилсан болон эрүү, иргэн, захиргааны төрлөөр төрөлжүүлэн хийж, шинээр гарч байгаа хэрэг, маргааныг шийдвэрлэх асуудлаар шүүгчдэд нэгдсэн ойлголтыг олгож ирсэн байдаг. Тухайлбал, шүүгчдэд зориулсан “Шинэ хууль тогтоомж”-ийн сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр Монгол Улсын бүх шүүгчийг хамруулан тухай бүр зохион байгуулж, Улсын Их Хурлаас шинээр баталсан хуулийн тухай болон түүнийг шүүхэд хэрэглэхэд анхаарах асуудлын талаар тухай бүр нэгдсэн ойлголт өгч байжээ.

2.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн шүүгчийн сургалтыг хариуцан зохион байгуулж байна. Тус хүрээлэнд Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын тэргүүн, анхан болон давж заалдах шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Их сургуулийн төлөөлөл бүхий Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хороо ажиллаж байна. Мөн тус хүрээлэнгээс шүүхийн хэрэгцээ, шаардлагын судалгаанд тулгуурлан шүүгчийн сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг авдаг практик 2022 оноос эхлэн тогтсон байна.

3.Хууль хэрэглээний нэгдсэн ойлголт, практик тогтооход шүүхийн практикийг судалж, нийтлэх асуудал чухал байдаг. Энэ үүднээс Улсын дээд шүүхийн тайлбарын албан ёсны эхийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлж, нийт шүүгчдэд хүргэж хэвшсэн.

4.Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэнгээс шүүн таслах ажиллагааны чиглэлээр ном, сэтгүүл, судалгааны тайлан бэлтгэн цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүх шатны шүүх, шүүгчдэд хүргэн ажиллаж байна.

5.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүн таслах ажиллагааны эрдэм шинжилгээний онол, мэдээлэл, арга зүйн “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийг 2014 оноос эхлэн улирал тутам бэлтгэн гаргаж шүүгч, шүүхийн ажилтны албаны хэрэгцээнд тасралтгүй хүргэж байна.

*Арга хэмжээ 4.1.4. Шүүгчдэд шүүн таслах ажиллагаанд шинээр гарч байгаа аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх асуудлаар нэгдсэн ойлголтыг шуурхай олгодог механизм бий болгосноор шүүгчдийг шинэ мэдээллээр хангах, чадавхжуулахад уг арга хэмжээ оновчтой байна.*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй”, 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээг шүүх, прокурор зэрэг хуулийн байгууллагын хэрэгцээнд зориулан Гадаад хэргийн яам албан ёсны орчуулгыг ёсчлон гүйцэтгэж, Улсын Их Хурлын Тамгын газар “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлэх ажлыг хариуцан, ХЗДХЯ, ХЭҮК хамтран бэлтгэж,

I ботийг- 2004 оны 12-р сарын 10

II ботийг- 2005 оны 1-р сарын 28

III ботийг- 2005 оны 12-р сарын 25

IV ботийг- 2006 оны 3-р сарын 1

V ботийг- 2006 оны 4-р сарын 18-нд тус тус 2000 хувь хэвлэн гаргажээ.

2.Улсын дээд шүүхээс “Дээд шүүхийн мэдээлэл”, “Нийслэлийн шүүхийн мэдээлэл” гэсэн сэтгүүлээр дамжуулан шүүн таслах ажиллагааны мэдээ, мэдээлэл, нэгдсэн практикийн мэдээлэл, зөвлөмжийг шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад хүргэж байжээ.

3.Шүүхийн ерөнхий зөвлөл 2015 оноос эхлэн “Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл”-ийг цувралаар бэлтгэн хэвлүүлж, нийтийн хүртээл болгож ирсэн.

4.Улсын дээд шүүх байгууллагынхаа цахим хуудсанд эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачдын гаргасан ном, судалгааны тайлан, илтгэл зэргийг тухай бүр байршуулан шүүгч нар шинэ мэдлэг, мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлж байна.

**Стратеги зорилт 4.2. Шүүгч хэрэг, маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэхийн тулд шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд бусад оролцогч этгээдийн дэмжлэг туслалцааг бүрэн авах боломжийг бүрдүүлэх**

*Арга хэмжээ 4.2.1.шүүх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа, зааг, ялгаа, хариуцлага хүлээх тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлэх;*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.”, Дөчин ёсдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь

түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах ...”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж тус тус заажээ.

2. Монгол Улсын шүүхийн тухай тухай хуулиар анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны, Прокурорын тухай хуулиар прокурорын байгууллагын чиг үүргийг зааглан зохицуулж, хариуцлага тооцох харилцааг хуульчилж өгсөн байна.

3. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага хоорондын ажил үүргийн уялдаа, зааг ялгааг хэрхэн зохицуулсныг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаар тухайлан авч үзлээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулж, шат, шатны шүүхийн эрх хэмжээг тодорхой зааглажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд цагдан хорих арга хэмжээг шүүгч авахаар, бусад таслан сэргийлэх арга хэмжээ, байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч авч болохоор заасан байна. Түүнчлэн, 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд таслан сэргийлэх арга хэмжээг авах эрхийг шүүгч, прокурор, мөрдөн байцаагчид аль алинд нь тодорхой хэмжээнд зааглан олгосон бөгөөд 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд таслан сэргийлэх арга хэмжээний төрлөөс хамааран хэн уг арга хэмжээг авах тухай илүү тодорхой зохицуулжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 2, 3-т 14.1.1, 14.1.4, 14.1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөн байцаалтын явцад авах бол прокурор, 14.1.2, 14.1.3, 14.1.5-д заасан арга хэмжээг шүүх авах зэргээр зааглан хуульчилжээ.

Нөгөө талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүхээр шийдвэрлэх ажиллагаа (сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, шүүхийн хэлэлцүүлэг хийх зэрэг)-г тодорхойлсон бөгөөд шүүх болон прокурорын байгууллагын уялдаа холбоог нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт “хуульд заасан үндэслэл байгаа бол прокурор сэжигтнийг баривчлах тухай мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш шүүхэд даруй хүргүүлэх” гэх зэргээр прокурор ба шүүхийн уялдаа холбоог зохицуулсан байна. Мөн хуульд хамтран ажиллах этгээдээр тогтоолгох саналыг прокуророос шүүхэд хүргүүлэн, шүүх түүнийг нь хянан шийдвэрлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд шүүх, прокурорын ажлын уялдааг нарийвчлан хуульчилжээ.

3. Эрүүгийн процессын хуулиудад шүүхийн эрх хэмжээг хуульчлахдаа мөрдөн байцаагч, прокурорын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэхийг хянах, хариуцлага тооцох агуулгаар тусгагджээ. Тодруулбал, шүүгч нь хэрэг, маргааныг Монгол Улсын нэрийн өмнөөс бие даан шийдвэрлэх бөгөөд прокурор, мөрдөгчийн шийдвэр, үйл ажиллагааг заавал зөвшөөрөх үүрэггүй юм. Энэ нь прокурор, мөрдөгчийн шийдвэр, үйл ажиллагааг шүүхээс хүчингүй болгох, өөрчлөх зэргээр тэдгээр албан тушаалтны хариуцлагагүй үйлдлийг залруулах механизм болсон байна.

Үүнээс гадна 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” талаар зохицуулсан бөгөөд 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар уг зохицуулалтыг хэвээр хадгалсан байна.

*Арга хэмжээ 4.2.2. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын хооронд хэрэг, маргаанд холбогдолтой мэдээллийг харилцан дамжуулах боломжийг хангах*

1.”Judge” 2005 бүртгэлийн программыг боловсруулж ашигласнаар шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд төдийгүй аливаа сонирхогч этгээд тухайн шүүх, шүүгчийн ажиллагаа хэрхэн явагдаж байгаа талаарх мэдээллийг бүрэн авах боломж бүрдсэн байдаг.

2.Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг 2017 онд нийт шүүхийн хэмжээнд нэвтрүүлсэн бөгөөд энэ нь шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага болох шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундын мэдээллийн нэгдсэн сан юм. Уг системийг ашиглан дээр 4 байгууллага 40 орчим мэдээлэл дамжуулах, хүлээн авах боломжоор хангагдсан.

Уг системийг ашигладаг болсноор эрүүгийн хэргийн шүүхэд хавтаст хэрэг ирэхэд хэргийг санамсаргүй тохиолдлоор хуваарилах, прокурорын байгууллагаас хэргийн мэдээлэл татах, улсын бүртгэлийн байгууллагаас иргэний мэдээлэл татах, холбогдох мэдээллийг бүртгэх, нэгтгэх, тусгаарлах, шүүхэд шилжүүлэх, талуудад мэдэгдэх, хуралдаан хийж шийдвэр гаргах, давж заалдах, хяналтын шатны шүүхэд шилжүүлэн эцэслэн шийдэгдэх хүртэлх бүх ажиллагааг бүртгэж байна. Мөн “Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем”-ээр таслан сэргийлэх арга хэмжээ болон захиргааны зөрчлийн санал бүртгэн шийдвэрлэх нэгдсэн тайланг гаргах боломжтой болжээ.

## **Суурь үнэлэхүй 5. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ**

“Шүүх эрх мэдлийн байгууллагад хандаж байгаа аливаа этгээдэд шүүхээс хүндрэл, чирэгдэл багатай, түргэн шуурхай, хямд зардалтай үйлчилгээ хүргэх чадвар”

**Стратегийн зорилт 5.1. Шүүх эрх мэдлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байцаан шийтгэх хуулиудыг боловсронгуй болгоно.**

*Арга хэмжээ 5.1.1.шүүхийн зардал болон өмгөөллийн хөлс төлөх чадваргүй иргэдэд төрөөс тусалцаа үзүүлэх боломж болон тэдгээр иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагад төрөөс тодорхой хэмжээгээр тусалцаа үзүүлэх боломжийг судлах*

1.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх



хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх” үүргийг төрд ногдуулжээ.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн “... хуулийн зүйн туслалцаа авах...” эрхийг хуульчилсан байна.

3.Төлбөрийн чадваргүй иргэд хууль туслалцаа авах эрхийг төрөөс хангах ажлын хүрээнд УИХ-аас 2013 онд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталж, “Хууль зүйн туслалцааны төв” гэсэн төрийн байгууллагыг байгуулж, төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх 2 чиглэлээр хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлсэн байдаг. Энэ хуулийн хүрээнд зөвхөн төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байжээ.

4.Шүүн таслах ажиллагааны хүрээнд процессын хуулиудад төлбөрийн чадваргүй хэргийн оролцогч, яллагдагчид хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхийг хангахад чиглэсэн тодорхой зохицуулалтыг хуульчилсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах журмыг хуулиар тогтооно.”, 5.3 дугаар зүйлийн 1.6-т “төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан” бол өмгөөлөгч заавал оролцуулах, 11.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, шүүгдэгчийг цагаатгасан, эсхүл ял шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон бол түүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас чөлөөлж, зардлыг төр хариуцна” гэж заажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52.1-д “Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.”, 52.2.-т “Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”, 55.1-д “Зохигч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.” гэж заажээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1-д “Хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал тэдгээрийг нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлж болно.” гэж зохицуулжээ.

5.Улсын Их Хурлаас Хууль зүйн туслалцааны тухай хуулийг 2022 онд баталснаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааг дан ганц эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлахгүйгээр зарим төрлийн гэмт хэргийн хохирогч, эрх нь зөрчигдсөн болон гэрч хүүхэд, иргэн болон захиргааны зарим төрлийн хэрэг, маргааны төлбөрийн чадваргүй оролцогч, нэхэмжлэгчид үзүүлэхээр хуульчилж, хамрах хүрээг өргөжүүлжээ.

6. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв нь улсын хэмжээнд ажлын алба болон 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, хүн ам ихээр төвлөрсөн 2 сумыг хамруулан нийт 31 салбарын 72 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл

өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн мэдээлэл хийх, сургалт сурталчилгаа явуулах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 55 улсын өмгөөлөгч ажиллаж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны тайлан<sup>9</sup>

Он	Өмгөөлөгч ажиллаж байгаа байршил	Хууль зүйн зөвлөгөө өгсөн тоо	Өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлсэн тоо	Шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг
2020	-Нийслэлийн 8 дүүрэг, -21 аймаг, 2 сум	8363	2888 хэргийн 3145 холбогдогч	1787
2021	-Нийслэлийн 8 дүүрэг, -21 аймаг, 2 сум	6631	2482 хэргийн 2749 холбогдогч	1438

Шүүн таслах ажиллагааны хүрээнд процессын хуулиудад төлбөрийн чадваргүй хэргийн оролцогч, яллагдагчид хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхийн хангахад чиглэсэн тодорхой зохицуулалтыг хуульчилж өгсөн. Тухайлбал:

- Иргэний процессын хуульд: Зохигч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө. [ИХШХШТХ-ийн 55.1],
- Эрүүгийн процессын хуульд: Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. [ЭХХШТХ-ийн 1.14.1] Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд төлбөргүй чадваргүй этгээд хүсэлт гаргасан тохиолд өмгөөлөгчийг заавал оролцуулна. [ЭХХШТХ-ийн 11.6.4]
- Захиргааны процессын хуульд: Хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал тэдгээрийг нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлж болно. [ЗХШХШТХ-ийн 46.1]

*Арга хэмжээ 5.1.2. Урьдчилан хорих зэрэг хүний эрх, эрх чөлөөг хөндсөн байцаан шийтгэх ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох эрхийг шүүхэд шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх*

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан бөгөөд олон улсын

<sup>9</sup> <https://lac.gov.mn/backend/f/ls7sh5KnQ7.pdf>

жишгийн дагуу хүний эрх, эрх чөлөөг хуульд зааснаар хязгаарлах бол гагцхүү хөндлөнгийн хараат бус шүүхийн зөвшөөрлийг авах ёстой.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүх өгөхөөр хуульчилснаар энэ асуудал зарчмын хувьд шийдвэрлэгджээ. Тус хуулийн 59.1-т сэжигтнийг баривчлах, 68.3-т цагдан хорих зөвшөөрөл олгохыг шүүх шийднэ гэж зааснаар хүний эрхийг хязгаарлах ажиллагааг шүүхийн хяналтад анх удаа оруулсан. Гэвч уг хуулийн хэрэгжилтийн байдалд зарим төрлийн хүндрэлүүд гарч байсныг хууль хэрэгжүүлэгч, судлаач, хүний эрхийн байгууллагууд нотлон илэрхийлж байжээ.

Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлд “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно” гэж тус тус нийтлэг стандартыг тогтоосон байна.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13-т яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүхийн хэлэлцүүлэг хийх, биеэр байлцуулахаар зохицуулсан нь хүний эрхийг хууль бусаар зөрчихөөс сэргийлж, богино хугацаанд шийдвэр гаргах, зөрчигдсэн эрхийг нь хамгаалах зохицуулалт болжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах гэсэн хоёр төрлийг хуульчилсан байна. Хүний эрхийн Үндэсний Комисс “2020 онд 793 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 50.1 хувь буюу 398, 2021 онд 809 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 41.2 хувь буюу 334, 2022 онд 1075 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 33.1 хувь буюу 355 сэжигтнийг сэжигтний тогтоолыг шүүхэд хүргүүлэхгүйгээр 48 цагийн хугацаатайгаар баривчилсан байна. Нийт баривчлах арга хэмжээний 73 орчим хувь нь шүүхийн хяналтад орохгүй байна” гэж 2022 оны Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлдээ дүгнэжээ.

### [Арга хэмжээ 5.1.3. Гэрч, хохирогч, шинжээчийг хамгаалах асуудлыг судалж хуульчлах](#)

Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх тухай асуудал Монгол Улсын хувьд төдийгүй олон улсын түвшинд анхаарал татсан асуудал юм. Дэлхий нийтэд гэмт хэргийн шинж чанар улам бүр зохион байгуулалттай өндөр түвшинд үйлдэгдэх болсон өнөө үед Монгол Улс нэгдсэн орсон олон улсын гэрээ конвенцын дагуу гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бий болгох шаардлага үүссэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны санаачилгаар гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурал Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд баталжээ. Тус хуулиар гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоожээ.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “Шинжээч”-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ.

Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий Тахарын албыг шинээр байгуулсан боловч Тахарын албаны тухай хуулийг 2016 онд хүчингүй болгож чиг үүргийг нь цагдаагийн байгууллагад, баривчлах байр, хорих ангиас оргосон яллагдагч, ялтныг мөрдөн хөөх, баривчлахтай холбогдсон ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тус тус шилжүүлжээ.

Хэдийгээр хууль, эрх зүйн орчин бүрдсэн боловч гэрч, хохирогч, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах бие даасан, үр нөлөөтэй тогтолцоо байхгүй байна.

Түүнчлэн “Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх матрикс”-т заасан “Гэрч, хохирогч, шинжээчийг хамгаалах сан байгуулах, бүрдүүлэх” ажил хэрэгжээгүй байна.

*Арга хэмжээ 5.1.4.Шүүгчээс бусад шүүн таслах ажиллагаанд оролцогчдод ажиллах нөхцөл бүрдүүлэх, байр, бусад боломжоор хангах асуудлыг судалж шийдвэрлэх*

1.Шүүгчээс бусад шүүн таслах ажиллагаанд шууд оролцогч болох шүүхийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон шүүгч ажил үүргээ хэвийн тасралтгүй явуулах нөхцөлийг хангах чир үүргийг хэрэгжүүлдэг шүүхийн тамгын газар, шүүхийн захиргааны ажилтнаас шүүхийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх зайлшгүй хүчин зүйл бол шүүхийн зориулалтын ажлын байр, техник тоног төхөөрөмж, орчин нөхцөлөөр хангах асуудал байдаг.

Гэвч Монгол Улсад шүүхийн зориулалтаар барьсан, стандартын шаардлагад нийцсэн нэг ч байр байхгүй байна. Тухайлбал, 2 шүүх актлагдсан байранд, 6 шүүх түрээсийн байранд, 6 шүүх прокурорын байгууллагатай нэг байранд, бусад шүүхүүд зориулалтын бус, стандартын шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа, шүүх хуралдааны танхимын хүрэлцээ, багтаамж дутагдалтай байгаагаас шүүх хуралдаан хойшлох, шүүн таслах ажиллагаа сунжрах, шүүхээр үйлчлүүлэгч иргэдэд зардал, чирэгдэл учруулах, иргэд шүүхийн үйлчилгээг тав тухтай орчинд авч чадахгүй байдалтай байна.

2. Монгол Улсын шүүхийн байгууллагад 1989 оноос мэдээллийн технологийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд шүүх, шүүхийн Тамгын газарт 20 гаруй систем, программ хангамж хэрэглэгдэж байна.

Гэвч эдгээр системүүд нь хоорондоо болон шүүхийн үйл ажиллагаанд оролцогч хууль сахиулах, прокурорын байгууллагын системүүдтэй уялдаа холбоо байхгүй, тайлан, мэдээ гаргах боломж хязгаарлагдмал, гар ажиллагаа их шаардагддаг, цаасан материалд суурилсан зэргээр хэрэглэгчдийн өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна.

Шүүн таслах ажиллагаанд болон шүүхийн захиргааны үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа эдгээр программ хангамжид сүүлийн жилүүдэд хөгжүүлэлт хийгдээгүй, компьютер техник хэрэгслийг шинэчлээгүйгээс тэдгээрийг ашиглахад



ихээхэн хүндрэлтэй, байнгын гацалт, доголдол үүсэж байгаа нь шүүхийн үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна.

3.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүхийн захиргааны ажилтанд тавигдах ерөнхий болон ёс зүйн шаардлага, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын гүйцэтгэх чиг үүргийг заасан боловч шүүхийн захиргааны ажилтны ангилал зэрэг, цалин хөлс, ажиллах нөхцөл, нийгмийн хамгааллын чиглэлээр тодорхой зохицуулалт тусгаагүй байна.

ШЕЗ-ийн ажлын албанаас 2022 онд зарим шүүхийн тамгын газруудын хэмжээнд хийсэн шүүхийн захиргааны ажилтнуудын чиг үүргийн шинжилгээний нэгдсэн дүнгээс үзэхэд, шүүхийн захиргааны ажилтнуудын 50 хувь нь томилогдсоноос хойш 3 жилийн дотор ажлаасаа гарч байгаа бөгөөд үүний үндсэн шалтгаан нь ажлын орчин тааруу, ачаалал өндөр, программ хангамж, техник хэрэгслийн гацалт ажил хийхэд ихээхэн хүндрэл учруулдаг гэж үзжээ.

2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.3-т “шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;” эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон. Шүүхийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн байр болон бусад хангамжийг шийдвэрлэх тооцоо судалгаанд үндэслэн жил бүрийн улсын төсөвт санал өгдөг боловч төсөвт шаардлагын хэмжээнд баталж өгөхгүй явж ирсэнтэй холбоотой юм. УИХ-аас 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж, төрийн төсөвт байгууллагын хөрөнгө оруулалтын төсвийг багасгасан, тэр дундаа ШЕЗ-ийн төсөвт хөрөнгө оруулалтын зардлыг төсөв тусгаагүй байна.

**Стратеги зорилт 5.2. Олон нийтийг эрх зүйн мэдээллээр хангах ажлыг өрнүүлэх, иргэний нийгэмтэй харилцах харилцааг боловсронгуй болгоно.**

*Арга хэмжээ 5.2.1. шүүх эрх мэдлийн байгууллагаас олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан сонин, сэтгүүл зэрэг тогтмол хэвлэл гаргах асуудлыг судалж шийдвэрлэх*

Шүүх эрх мэдлийн хүрээнд олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан дараах тогтмол сонин сэтгүүл гаргаж байжээ:

- Улсын дээд шүүхээс “УДШ-ийн мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй” гэсэн хоёр сэтгүүлийг улирал тутам;
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийг Ханнс-Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр улирал тутам;
- Хууль зүйн үндэсний төвөөс “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, “Хууль зүйн мэдээ” сониныг улирал тутам;
- Улсын прокурорын ерөнхий газраас “Мэдээлэл” сэтгүүлийг улирал тутам.

2.Хуулийн байгууллагын сонин хэвлэлийг уялдуулах зорилгоор ГТХАН-ийн “Хуульчдын сургалт, давтан сургалт” төсөл, ШЭМШХ ба ХЗҮТ “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг Хууль зүйн үндэсний төвөөс улирал тутам эрхлэн гаргах талаар хамтран ажиллах 1 жилийн гэрээг 2005 оны 6-р сард байгуулж, ХЗҮТ-ийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг бие даан гаргах чадавхыг бүрдүүлэхийг зорьсон юм. Өнгөрсөн хугацаанд энэ сэтгүүлийн нийт 5 дугаарыг хэвлэн гаргаж, захиалагчдын тог 500-д хүргэжээ.

3.2012 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 12.1.2-д “шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудсанд тогтмол байрлуулах;” гэж заасны дагуу “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийг өнөөг хүртэл жил бүр 4 дугаар улирал тутам гаргаж байна. Энэ сэтгүүл шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд төдийгүй эрдэмтэн судлаачид, олон нийтэд мэргэжлийн сэтгүүлийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тогтмол хэвлэл болж чадсан байна.

4.2013 оноос эхлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны бүтцэд Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудлыг хариуцсан нэгж ажиллуулж байна. Мөн нийслэлийн зарим ачаалал ихтэй шүүхүүдийн тамгын газарт олон нийттэй харилцах мэргэжилтнийг орон тоогоор ажиллуулж байна.

5.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12.4-д “Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ.” гэж заасны дагуу УДШ, ШЕЗ, шүүхийн Тамгын газрууд, ШСХ, УЕПГ байгууллагынхаа цахим хуудас, пейж хуудас, shuukh.mn, live.shuukh.mn, “Шүүхийн шийдвэрийн тойм” нэртэй фэйсбүүк хуудас зэрэг платформоор шүүхийн шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа олон нийт тасралтгүй мэдээлж байна.

6.Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс “Монголын төр эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргаж байна.

7.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлагын мэдээ” сониныг сар бүр гаргаж, шүүн таслах ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

8.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулдаг “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурал, “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч” сургалт зэрэг шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүргэх, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

*Арга хэмжээ 5.2.2.Олон нийтэд эрх зүйн мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл /сонин, сэтгүүл, телевиз, радио/-тэй хамтран ажиллах механизм төлөвшүүлэх*

1.Шүүх эрх мэдлийн байгууллагууд 2006 оны 1-р сараас өөрийн мэдээллийн бие даасан нэгж, ажилтантай болж шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, хамтран ажиллах ажил жигдэрсэн.

2.Хэвлэлийн баг хурал хийж, цаг үеийн асуудлаар олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагад цогц мэдээлэл өгөх механизмыг хэрэглэж хэвшсэн.

3.Иргэд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) сайтаар хууль, тогтоомжтой танилцах, татан авах боломж бүрэн бүрдсэн.

4.Монгол Улсын шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сан болох [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад нууцад хамаарахаас бусад шүүхийн шийдвэрийг байршуулан олон нийтэд нээлттэй танилцуулж байна. Цахим санд 7 хоногт дунджаар 150 гаруй мянган хүн хандаж шүүхийн шийдвэр болон бусад мэдээллийг авч байна.

2023.04.20-ны өдрийн байдлаар, тус цахим санд бүх шатны шүүхийн 454152 шийдвэр байршсан байна. Тухайлбал,

	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх
Эрүүгийн хэрэг	110827	22475	4439
Иргэний хэрэг	244178	31750	12839
Захиргааны хэрэг	16508	7264	3872
Нийт	371513	61489	21150

5. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс "Шүүхийн мэдээ" пейж хуудас болон твиттер хуудас хөтөлж, шүүхэд хянан шийдвэрлэж буй олны анхаарал татсан хэргийн шийдвэрийг цаг алдахгүй мэдээлж, сэтгүүлчдийн хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна.

6. Сэтгүүлчдийн шүүх эрх мэдлийн талаарх ойлголтыг дээшлүүлэх зорилгоор жил бүр "Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч" сургалтыг зохион байгуулж ирсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны байдлаар, 10 удаагийн сургалт, мэдээллийг хүргэсэн. Тус зөвлөлөөс 2022 онд зохион байгуулсан "Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч" сургалтад 40 гаруй сэтгүүлчийг хамруулав

7. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх хүрээнд шүүхийн шийдвэрийг энгийн үг хэллэгээр иргэдэд ойлгомжтой байдлаар хураангуй хэлбэрээр бэлтгэх ажлыг 2022 онд хэрэгжүүлж, "Шүүхийн шийдвэрийн тойм" фейсбуук хуудсаар болон бүх шатны шүүхийн цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж байна.

8. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Нээлттэй шүүх" хэвлэлийн бага хурлыг улирал бүр хийж, шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан хэргийн талаар олон нийтэд мэдээлдэг механизмыг бий болгосон бөгөөд 2022 оны байдлаар 12 хэвлэл мэдээллийн байгууллагатай олон нийтэд эрх зүйн мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зорилгоор хамтран ажиллаж, 280 удаагийн давтамжтай мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.

9. Монголын хуульчдын холбоотой хамтран иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлэх, хууль тогтоомж, шүүхийн үйл ажиллагааг сурталчлах "Хуульчийн про боно" өдөрлөгийг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдөр орон даяар зохион байгуулж хэвшсэн.

*Арга хэмжээ 5.2.3. Олон нийтэд зориулан Улсын Дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбар, хууль тогтоомж болон шүүхийн шийдвэрийн мэдээллийн сүлжээ бий болгох*

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт "Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ." гэж заасны дагуу Улсын дээд шүүхийн цахим хуудаст "тайлбар, зөвлөмж, тойм" гэсэн цэс байрласан. Үүнээс Улсын дээд шүүхийн тайлбар, зөвлөмж, тоймыг огноо, дугаар, текстээр хайж харах боломжтой байна.

2.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол бүх шатны шүүх шийдвэрээ шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим санд байршуулна. Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэж болно.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 тоот тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-ыг батлуулж, шүүхийн шийдвэрийн мэдээллийн сүлжээг бий болгосон.

3.Улсын дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбар, тогтоолыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn-д оруулж нийтийн хүртээл болгодог бөгөөд өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхээс 1990-2023 онд гаргасан 185 баримт бичиг байршсан байна.

4.Улсын дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбарыг Улсын дээд шүүхийн цахим хуудсанд тухай бүр байршуулан нийтэд ил тод болгон ажиллаж байна.

*Арга хэмжээ 5.2.4.Мэтгэлцэх зарчмын утга агуулга, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.*

Шүүх шүүн таслах ажиллагааны мэтгэлцэх зарчим нь шүүх хуралдаанд талууд, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагчид асуулт асуух, хариулах, нотлох баримтыг танилцуулах, өөрсдийн тайлбар өгөх, үндэслэлээ хамгаалах, үгүйсгэх боломжийг тэгш олгох зорилготой юм.

Шүүх хуралдааны үеэр мэтгэлцэх журмыг хэрэг хянан шийдвэрлэх хуулиудаар зохицуулсан байдаг. Тухайлбал,

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, Мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжихээр, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдаанд биеэр оролцож үг хэлэх, бичгээр тайлбар өгөх, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцохоор хуульчилсан байна.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд талууд шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэх, шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох, шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн хэлэлцүүлгийг яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн хэлэлцүүлэг нь яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдахаар заасан байна.

Үүнээс үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд мэтгэлцэх зарчим хэрэгжих боломжтой байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрууд шүүхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, нээлттэй өдөрлөг зохион байгуулах зэрэг арга хэмжээний хүрээнд шүүн таслах ажиллагааны оролцогч нарт эрх, үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл, эрх зүйн мэдлэг өгөх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Хэргийн оролцогч болоод олон нийтийн хяналтыг



хэрэгжүүлж буй иргэдийн төлөөлөгч нарт хэрэг хянан шийдвэрлэх хуулиар олгогдсон мэтгэлзэх эрх үүргийг тайлбарлан таниулах, сургалт сурталчилгаа явуулах ажил чухал байдаг.

**Стратеги зорилт: 5.3. Шүүхүүдийн байршил, орон тоонд тавих шаардлага, стандартыг боловсруулж мөрдөнө.**

*Арга хэмжээ 5.3.1. Нэг шүүхийн харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, үйлчлэх хүн амын тоог оновчтой тогтоох, үйлчлэх хүрээнд ойр хүртээмжтэй байх, шүүх эрх мэдлийн бусад байгууллагатай үйл ажиллагаагаа харилцан уялдуулахтай холбоотой шаардлага, шалгуурыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх*

1.1992 онд батлагдсан Үндсэн хуулиар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн засаглалын 3 салаа мөчир харилцан хяналт тэнцвэртэй ажиллах, шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх хуулийн үндэс бүрдэж, 1993 оны шүүх байгуулах тухай хуульд шүүх байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, бүс нутаг, нутаг дэвсгэрийн ойр дөт байдал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг харгалзан үзэхээр хуульчилжээ.

2.1993 оны Шүүх байгуулах тухай хуулиар 2000 онд улсын хэмжээнд 28 байршилд 58 шүүх ажиллаж байсан ба 2000-2013 оны хооронд шүүхийн байршилд шүүхийг иргэдэд ойр дөхөм болгох бүтцийн шинжтэй өөрчлөлт оруулаагүй байна.

3.2012 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил , шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна” гэж шүүх байгуулахад харгалзан үзэх нөхцөлийг хуульчилжээ.

4.2015 оны шүүх байгуулах хуулийн дагуу Монгол Улсад 117 шүүх ажиллаж байна. Тухайлбал, Улсын дээд шүүх, эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 25 шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүх, аймаг дахь эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны тус бүр 21 шүүх, 9 дүүргийн эрүү болон иргэний хэргийн анхан шатны 18 шүүх, аймаг, нийслэл дэх захиргааны хэргийн хэргийн 22 шүүх, 8 сум дахь сум дундын 8 шүүх байна.

2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар анхан болон давж заалдах шатны шүүхийн байршлыг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

Шүүхийн нэршил	Шүүхийн бүгд тоо	Үүнээс			
		Нийслэлд байрших	Аймгийн төвд байрших	Сумдад байрших	
<b>Давж заалдах шатны шүүх -26</b>					
Үүнээс	Иргэний хэргийн давж заалдах	3	1	2	-
	Эрүүгийн хэргийн давж заалдах	3	1	2	-
	Эрүү, иргэний давж заалдах	19	-	19	-
	Захиргааны хэргийн давж заалдах	1	1	-	-

		Анхан шатны шүүх-88				
Үүнээс	Захиргааны анхан шатны шүүх	22	1	21	-	
	Сум дундын шүүх /иргэн, эрүү/	42	-	42	-	
	Сум дундын шүүх	8	-	-	8	
	Дүүргийн шүүх	18	16	-	-	
<b>Бүгд</b>		<b>116</b>	<b>20</b>	<b>86</b>	<b>8</b>	

Анхан болон давж заалдах шатны 116 шүүхийг засаг захиргааны нэгжүүдэд байршихаар байгуулсан нь байршлын хувьд шүүхийн үйлчилгээ иргэнд ойр, шүүхэд хандах иргэний эрхийн баталгаа хангагдах зорилготой.

5.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх энэ хуулийн 13.4, 14.3-т заасан шалгуур үзүүлэлтийг Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй зөвшилцөн батална.” гэж хуульчилсан.

6.Шүүхийн ерөнхий зөвлөл “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх 34 шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулж, Улсын дээд шүүхтэй зөвшилцөн тогтоолоороо баталсан байна.

7.Дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл, хөндлөнгийн байгууллагатай хамтран багц судалгаа хийж, шүүх, шүүгчийн аажлын ачааллыг тодорхойлсон байна. Энэ судалгаа нь шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик, шүүхийн захиргааны тайлан, мэдээлэл болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд хийсэн ажлын байрны ажиглалт, асуумж, хэрэг уншилтын тоо, мэдээнд тус тус үндэслэжээ.

8.Уг судалгаа нь 2022 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх байгуулах талаар саналын төсөл боловсруулахад үндсэн эх сурвалж болсон байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулсан Шүүх байгуулах саналын зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж, шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал, байрших газар, зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн болно.

*Арга хэмжээ 5.3.3.Шүүх эрх мэдлийн байгууллагын нэг ажилтанд ногдох ажлын ачааллын жишиг шалгуурыг үндэслэн шүүгч, туслах ажилтны орон тоог нэмэгдүүлэх*

1.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах, ...” гэсэн чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр хуульчилжээ. Үүний дагуу ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн 2015 онд гадаад улс орнуудын шүүхийн практикт шүүгчийн ажлын ачааллыг тооцдог аргачлалын талаар судалгаа хийсэн байдаг.

Энэхүү судалгаанд “шүүгчийн ажлын ачааллыг тооцдог аргачлалууд /хэргийн жингийн ачаалал үнэлэх аргачлал, дельфи аргачлал, норматив аргачлал, холимог аргачлал зэрэг/-ыг дэлхийн улс орнууд шүүхийн практиктаа хэрэглэх болсон бөгөөд бусад улсууд өөрийн орны онцлогт тохируулан тус аргачлалуудыг дангаар эсхүл хосолмол байдлаар сонгон авч хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо норматив аргачлал буюу тухайн шүүхэд ирсэн нийт хэргийн тоог, нийт шүүгчдийн тоонд харьцуулж шүүгчийн ажлын ачааллыг гаргадаг механизм шүүхийн практикт хэрэгжиж байна” гэж дурдсан байдаг.

2.УИХ-ын 2016 оны 42 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн тоог нийтдээ 699 байхаар тогтоосон нь 2000 оноос хойш шүүгчийн орон тоог 50,7 хувиар нэмэгдүүлэх нөхцөлийг эрх зүйн хүрээнд бүрдүүлсэн боловч УИХ-аас баталсан орон тоогоор шүүгч ажиллуулах төсөв, цалингийн санг баталж байгаагүй байна.

Өнөөдрийн байдлаар, Монгол Улсын хэмжээнд 117 шүүхэд 511 шүүгч, тухайлбал, УДШ-эд 23, давж заалдах шатны 26 шүүхэд 104, анхан шатны 90 шүүхэд 384 шүүгч ажиллаж байна.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ХААИС, МУИС-ийн эрдэмтэд, судлаагчидтай хамтран 2022 онд хийсэн 5 цуврал судалгаагаар шүүгчийн ажлын ачааллыг анхан болон давж заалдах шатны 116 шүүх тус бүрээр гаргасан.

Судалгаагаар, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилд 91 эрүүгийн хэрэг, 731 зөрчлийн хэрэг, ИХАШШ-ийн шүүгч жилд 209 хэрэг, ЗХАШШ-ийн шүүгч 35 хэрэг, ЭХДЗШШ-ийн шүүгч жилд 49 эрүүгийн хэрэг, 110 зөрчлийн хэрэг, ИХДЗШШ-ийн шүүгч жилд 126 хэрэг, ЗХДЗШШ-ийн шүүгч жилд 31 хэрэг хянан шийдвэрлэх нь иргэд шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн зохист ачаалал гэж тогтоосон.

Мөн судалгаагаар төвийн 6 дүүргийн ЭХАШШ-ийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал 50%, ЭХАШШ-ийн зөрчлийн хэргийн шүүгчийн ачаалал 150%, ИХАШШ-ийн шүүгчийн ачаалал 80%, орон нутаг дахь ЭХАШШ-ийн шүүгчийн ачаалал 8.6 цаг буюу 10%-р, ИХАШШ-ийн шүүгчийн ачаалал 81%-р, НЭХДЗШШ-ийн шүүгчийн ачаалал 10 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын хэмжээнээс 25%-р, НИХДЗШШ-ийн шүүгчийн ачаалал 10%-аар тус тус хэтэрсэн байна гэж тогтоосон.

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх эхний алхам болгож, орон нутгийн ачаалал харьцангуй багатай шүүхүүдээс 25 шүүгчийн орон тоог нийслэлийн төвийн 6 дүүргийн зарим шүүхэд шилжүүлэх санал боловсруулан УИХ-аар шийдвэрлүүлсэн.

4.шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг тооцох талаар 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуульд зохицуулалт байхгүй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны ажилтнуудын ажил үүргийг оновчтой тогтоох, ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд албан тушаалын чиг үүргийн шинжилгээг ХААИС-ын эрдэмтэн судлаачтай хамтран хийж байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д шүүгч туслахтай байна гэж заасан бөгөөд 2023 оны байдлаар, анхан болон давж заалдах шатны шүүхийн 488 шүүгч, 490 шүүгчийн туслах ажиллаж байна.

## **Стратеги зорилт 5.4. Шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа, шийдвэрийг олон түмэнд ил тод, хүртээлтэй, нээлттэй байлгана.**

*Арга хэмжээ 5.4.1.Иргэд хуулийн байгууллагад хандах, хуулийн байгууллагаас гарсан шийдвэртэй цаг алдалгүй танилцах боломжийг хангах, энэ үйл ажиллагаанд гарах чирээдлийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;*

1.Шүүхийн ерөнхий зөвлөл анхан болон давж заалдах шатны шүүх бүрт шүүх хуралдааныг танхимын гаднаас шууд үзэх төхөөрөмж, дэлгэц суурилуулснаар иргэд өөрийн сонирхсон хэргийн шүүх хуралдааны үйл ажиллагаатай чөлөөтэй танилцах, эрх зүйн боловсролоо дээшлүүлэх боломж бүрдсэн. Шүүх хуралдааны явцыг live.shuukh.mn системийг ашиглан хүргэж байна.

2.Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж архивт хадгална” гэж заасны дагуу 2013 оноос хойш шүүх хуралдааны бүх бичлэгийг бичиж хадгалж байна. Иргэд шүүх хуралдаанд орж чадаагүй тохиолдолд шүүх хуралдааныг нөхөж үзэх, өөрийн эрх, ашгаа хамгаалах боломж хангагдсан. Энэ нь шүүхийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн чухал ажил болсон юм.

3.Шүүхийн бүх шийдвэр олон нийтэд нээлттэй болсон бөгөөд shuukh.mn сайтаас иргэд шүүхийн шийдвэрийг харах, танилцах боломж бүрэн бүрдсэн.

4.Хэргийн оролцогч шүүх хуралдаанд зайнаас цахимаар оролцох боломж бүрдсэн. 2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж ирсэн. Тухайлбал, 2021 оны 06 сарын 28-ны өдрөөс 2022 оны 06 сарын 28-ны өдөр хүртэл хугацаанд давж заалдах шатны шүүхүүд нийтдээ 26075 хэргийн оролцогч бүхий 8876 шүүх хуралдаан хийсний 5191 шүүх хуралдаан буюу 58.4% цахимаар явуулсан байна.

5.Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол шуудан” ХК-тай хамтран ачаалал ихтэй ажиллаж байгаа анхан шатны шүүхүүдэд буюу нийслэлийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, Орхон, Дархан-Уул аймаг дахь шүүхийн тамгын газар, Багануур, Налайх, Багахангай дүүргийн шүүхүүдэд шүүхийн зарлан дуудах, мэдэгдэх хуудасны хүргэлтийн шуудангийн програм болох “Гибрид” үйлчилгээг амжилттай нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэрийг 14 хоногийн дотор, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 15 хоногийн дотор хэргийн оролцогчдод гардуулах зохицуулалттай байна. Шүүхийн шийдвэрийг шуудангаар, бичиг хүргэгчээр, мөн хэргийн оролцогчид биечлэн гардуулж байна.

*Арга хэмжээ 5.4.2.Шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргасан шийдвэр, шүүгчийн үйл ажиллагаа, нэр хүндийг үндэслэлгүйгээр гүтгэсэн, гуйвуулсан аливаа мэдээ, мэдээлэлд тухай бүр няцаалт өгдөг механизм бүрдүүлж, үнэн зөвийг олон түмэнд мэдээлэхэд уг механизмыг ашиглах*



1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, 2-д “...шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.”, 3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.”, 4-д “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” гэж шүүх, шүүгчийн хараат бус байдлыг хангах хамгаалах зарчмыг тусгажээ.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулсан хууль тогтоомж, хэм хэмжээний акт гаргах, бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тухайлсан хэрэг, маргаантай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглосон бөгөөд шүүгчийн хараат бус байх зарчим, баталгааг хуульчилсан байна.

3.Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахтай холбоотой хийгдсэн томоохон ололт нь шүүгчид нөлөөлөхийг оролдсон тохиолдолд шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зохицуулалтыг хуульчилсан. Хэрэв шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол Шүүхийн ерөнхий зөвлөл холбогдох байгууллагад уламжилж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг хуулиар хүлээлгэсэн.

4.Шүүгчээс нөлөөллийн мэдүүлэг хөтлөх явдлыг тусгайлан зохицуулсан нь шүүх эрх мэдлийн нэр хүндийг үндэслэлгүйгээр гүтгэсэн этгээдэд үзүүлэх хариуцлагын тогтолцоог бий болгож, шүүн таслах ажиллагааны явцад шүүхэд нөлөөлөх, олон нийтэд буруу мэдээлэл түгээх үйлдлийг таслан зогсоох чухал механизм болсон.

5.Шүүхийн ерөнхий зөвлөл ажлын албаны бүтцэд Шүүгчийн хараат бус байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах алба байгуулан ажиллаж байна.

6.Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, шүүгчээс хөтөлж ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийг эрх бүхий байгууллагаар шалгуулах, энэ талаар олон нийтэд мэдээлэх ажил хэрэгжиж хэвшсэн байна. 2022 онд 16 шүүгчээс 15 нөлөөллийн мэдүүлэг хөтлөн ирүүлснийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар тухай бүр хэлэлцэн нөлөөллийн мэдүүлэгт дурдсан үйлдлийг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй эсэхийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шалгуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнээс 3 нөлөөллийн мэдүүлэгт холбогдох үйлдлийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 нөлөөллийн мэдүүлэгт холбогдох үйлдлийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, 2 нөлөөллийн мэдүүлэгт холбогдох үйлдэлд Зөрчлийн тухай хуульд зааснаар торгох шийтгэл оногдуулж тус тус шийдвэрлэсэн бол 9 нөлөөллийн мэдүүлэгт холбогдох үйлдлийг шалган шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэн явагдаж байна.

7.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн гэх 4 асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөл даруй хуралдан дээрх шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад чиглэсэн зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авч, 1 асуудалд “Мэдэгдэл”, 3 асуудалд “Хүсэлт” гарган эрх бүхий байгууллагаар шалгуулахаар шийдвэрлүүлсэн.

8.Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар 12 шүүгчээс гомдол, хүсэлт гаргасан асуудалд шүүгчийг төлөөлөн 1 асуудалд “Мэдэгдэл” гарган, 11 асуудлыг хуульд заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад хандан шалгуулахаар гомдол, хүсэлт гаргажээ.

9.Цахим орчинд шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй мэдээ, мэдээлэл түгээсэн 6 асуудлыг эрх бүхий байгууллагаар шалгуулахаар гомдол, мэдээлэл гаргаж эрх бүхий байгууллагад шилжүүлжээ.

10.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар гаргасан гомдол, хүсэлтийн дагуу эрх бүхий байгууллагаас явуулсан шалган шийдвэрлэх ажиллагаанд нэр бүхий шүүгчдийг төлөөлөн хохирогчийн хууль ёсны төлөөлөгч болон гэрчээр тогтоогдон, тухай бүр мэдүүлэг өгч ажиллажээ.

11.Шүүгчийн хараат бус байдлыг хангах, алдагдуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын шүүхийн Сахилгын хороонд “Мэдэгдэл”, хуулийн хэрэгжилтийг хангуулах агуулга бүхий “Албан шаардлага”-ыг Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлсэн байна.

12.Нэр бүхий өмгөөлөгч нарын хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр шүүгч, шүүгч бүрэлдэхүүнийг гүтгэсэн, хараат бус байдалд халдсан шинжтэй мэдээ, мэдээлэл тараасантай холбогдуулан хууль болон Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн заалтуудыг зөрчсөн эсэх асуудлыг холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу хянан шийдвэрлүүлэхээр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол, мэдээлэл гаргаж, тус хорооны хуралд шүүгчдийн төлөөлөн оролцож, нэр бүхий өмгөөлөгч нарт хариуцлага тооцуулжээ.

## **Стратеги зорилт 5.5. Шүүхийн шийдвэрийг хуулийн дагуу, шуурхай биелүүлдэг нөхцөл бүрдүүлнэ.**

### ***Арга хэмжээ 5.5.1.Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, зах зээлийн нөхцөлд нийцсэн оновчтой хувилбар бий болгох***

1.Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 1921 оноос гяндан салаа; 1936 оноос Улсын төв засан сайжруулах газар; 1940 оноос Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газар; 1956 оноос Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэс; 1963 оноос Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газар; 1981 оноос Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газар; 1992 оноос Монгол Улсын Хорих байгууллагуудыг удирдах газар; 1996 оны 12 дугаар сараас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, 2002 оноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гэж тус тус нэрлэгдэн үйл ажиллагаагаа явуулж иржээ.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 1921 оноос Шүүх яаманд, 1936 оноос Дотоод явдлын Яаманд /хожмоо НАХЯ/, 1985 оноос НАХЯ-ны Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газарт, 1991 оноос Монгол Улсын Хууль зүйн яамны эрхлэх ажлын хүрээнд харьяалагдан ажиллаж иржээ.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог шинээр тодорхойлж, түүний алба хаагчийн баталгааг улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн 4 болон

бусад баталгаа болгон нарийвчлан зааж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг тогтоосон байна.

Ийнхүү ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, чиг үүрэг оновчтой болгосноор ял, албадлагын арга хэмжээг ялгамжтай, үр нөлөөтэй эдлүүлэх нөхцөл бүрдээ хорих ангийг нээлттэй, хаалттай хэлбэрт шилжүүлснээр хорих ялыг хувь хүний онцлогт тохируулан ялгамжтай эдлүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Мөн иргэний болон зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтийг сайжруулж, иргэний зөрчигдсэн эрхийг сэргээх тогтолцоог бэхжүүлэх хуулийн үндэс сайжирсан байна.

4.Шүүхийн шийдвэр гүйцэх ажиллагааны мөнгөн дүнгийн тодорхой хувиар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд урамшуулал олгохоор 2002 оны хуульд зохицуулалт байсныг 2017 оны хуулиар хүчингүй болгосон байна.

*Арга хэмжээ 5.5.2.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд прокурорын байгууллага хяналт тавихаар холбогдох хуулиудад тусгах*

1.Прокурорын тухай хуулийн 22, 23, 24 дүгээр зүйлд ял эдлүүлэх ажиллагаанд прокурорын тавих хяналт, түүний төрөл, хэлбэр болон прокурорын бүрэн эрхийг хуульчлан заажээ.

2.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаа прокурорын байгууллагын хяналт дор явагдах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147, 153, 154, 155, 156, 157, 158, 159, 160, 161, 173, 174, 182, 185, 186, 188, 189, 190, 191, 192, 193, 195, 196, 200, 201, 206, 212, 217, 225, 226, 227, 228, 229, 249, 256, 271, 272, 290, 296, 298, 300 дугаар зүйлд нарийвчлан заажээ.

*Арга хэмжээ 5.5.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид нөхөн төлөх зориулалт бүхий тусгайлсан сан бий болгох асуудлыг судлах*

1.Амар тайван, аюулгүй нийгэм бий болгох хүрээнд **иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангахаар** “Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.” гэж Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан байна.

2.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт хохирогч гэж нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ гэж заасан. Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаарна. Энэ хохирлын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсон хэвээр үлдэж байна.

3.Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг, дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж

байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог байна.

4.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9 дэх хэсэгт заасны дагуу хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг баримтална. Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан. Эдийн бус хохирол нь материаллаг бус бүх хохирлыг багтааж байдаг. Иргэний хуулийн тайлбарт дурдахдаа Бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна. Гэхдээ Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.” гэсэн нь хохирол барагдуулах үйл ажиллагааг явцууруулж байна. Үүнийг Улсын дээд шүүхийн 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 6.2.4-т тайлбарлахдаа “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй.” гэж заасан. Үүнийг иргэний хуулийн тайлбарт дурдахдаа “... энэ нөхөн төлбөрийг харин хуульд илүү тодорхой тусгасан тохиолдолд шаардаж болно” гээд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсгийн заалтыг жишээ болгожээ.

*Арга хэмжээ 5.5.4.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагын ажилтныг шаардлагатай техник хэрэгсэл, бусад эдийн засгийн баталгаагаар хангах нөхцөлийг хуульчлан тогтоох*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эдийн засгийн баталгааг тусгайлан заасан байна.

*Арга хэмжээ 5.5.5.Иргэд, хуулийн этгээдийн хоорондын төлбөр гаргуулах тухай шүүхийн шийдвэрийн бодитой биелэгдээгүй хэсэгт нь эрсдэлээ төлбөр авагч өөрөө хариуцах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллага бодитой биелэгдэхгүй шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгуулдаг тогтолцоо бий болгох асуудлыг судлах*

1.Тогтоол гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэлийн бүх ажиллагааг явуулсны үндсэн дээр тухайн этгээдийг төлбөрийн чадвартай болох, хорихоос суллагдах хүртэл хугацаагаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах шүүхийн тогтоол гаргуулдаг байсан. Энэ тогтоолд жил бүр хяналт хийж, дахин сэргээх ажиллагааг Ерөнхий шүүгч хийдэг байсныг эс тооцвол иргэд, хуулийн этгээдийн хоорондын төлбөр гаргуулах тухай шүүхийн шийдвэрийн бодитой биелэгдээгүй хэсэгт нь эрсдэлээ төлбөр авагч өөрөө хариуцах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллага бодитой биелэгдэхгүй шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг



хэрэгсэхгүй болгуулдаг тогтолцоо бий болгох асуудал биелээгүй гэж үзэж болохоор байна.

2.Улсын Их Хурал 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, журмыг тогтоожээ. Энэ хуулиар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдал, алба хаагчид дотоодын цэргийн хувцас хэрэглэх зэрэг шинэ зохицуулалтыг тусгажээ.

3.Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэсэн.

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэл Монгол Улсын Дээд шүүхийн харьяанд 2002 оныг хүртэл байх хугацаанд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80-85 %-тай байсан бол 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-аар иргэний иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд ирснээр 50% орчим биелэлттэй болсон байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл, 2020 онд иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл 50.1%, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэл 50.7%, 2021 онд иргэний хэргийн гүйцэтгэл 53.1%, захиргааны хэргийн гүйцэтгэл 55.3%, 2022 онд иргэн хэргийн гүйцэтгэл 50.7%, захиргааны хэргийн гүйцэтгэлийн 54.6%-тай гэсэн статистик байна.

**Стратеги зорилт: 5.6. Шүүхийн үйлчилгээг эдийн засгийн хувьд хүртээмжтэй болгоно:**

*Арга хэмжээ 5.6.1.Шүүхэд хэрэг хэлэлцэх шат бүрт гарч байгаа зардлын хэмжээг бодитойгоор тооцож, энэ тооцоог шүүхийн төсвийн төслийг боловсруулах үед харгалзан үздэг болох*

1.Шүүхийн төсвийн төслийг боловсруулахдаа шүүн таслах ажиллагааны зардлаар бус төсвийн зүйл, заалтын аргачлалаар тооцож төсвийн саналаа боловсруулж ирсэн байна.

2.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д “шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д “шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх” дунд хугацааны бодлогыг боловсруулж, 2022 оны 332 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Энэ бодлогын “Бодлого хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн хүрэлцээг нэмэгдүүлнэ” гэсэн 3.1 дэх дэд зорилтын 3.1.3-д “Шүүн таслах ажиллагааны зардлыг бодитой тооцох, төлөвлөх, санхүүжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, шүүхийн эдийн засгийн баталгааг хангана” гэж заасан.

Үүний үр дүнд шүүн таслах ажиллагааны зардлын хэмжээг бодитойгоор тооцож, түүнд үндэслэн шүүхийн төсвийг төлөвлөх, удирдах буюу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх бодлого тодорхой болж байна.

*Арга хэмжээ 5.6.2.Шүүхийн зарим үйлчилгээг зохих хэмжээний төлбөртэй болгож, түүнийг чөлөөтэй хүртээх боломжийг бүрдүүлэх.*

1.Шүүхийн ерөнхий зөвлөл 2020 оноос эхлэн Монгол Улсын шүүхийн үйлчилгээг “Гэрэгэ киоск” системээр дамжуулан иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэж байна.

Шүүхийн тэмдэгтийн хураамжийн төлбөр болон шүүхийн бусад үйлчилгээний хураамж төлөхөд ашиглаж байгаа “Гэрэгэ киоск”-ийн төхөөрөмж нь шүүхийн өмч, программ хангамж нь Гэрэгэ системс ХХК-ийн өмч юм.

2.2021 оны 9 дүгээр сарын 14-ны өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хүртэл хугацаанд “Гэрэгэ киоск”-оор хийгдсэн шүүхийн 3 төрлийн үйлчилгээний нийт гүйлгээний тоо, орлогын тайланг доорх хүснэгтээр харуулав.

№	Үйлчилгээний төрөл	Гүйлгээний тоо	Нийт орлого
1	Улсын тэмдэгтийн хураамж	35,332	7,708,080,957
2	Эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэл	15,293	1,073,568,600
3	Эвлэрүүлэн зуучлал	6,479	194,370,000
НИЙТ		57,104	8,976,019,557

3.2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд “Гэрэгэ киоск”-оор хийгдсэн шүүхийн 9 төрлийн үйлчилгээний нийт гүйлгээний тоо, орлогын тайланг доорх хүснэгтээр харуулав.

№	Үйлчилгээний төрөл	Гүйлгээний тоо	Нийт орлого
1	Шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол болон захиргааны бусад акт хуулбарлах	3,569	7,479,000
2	Тендэртэй холбоотой тодорхойлолт /аж ахуйн нэгж, байгууллага/	4,040	41,620,000
3	Үйлчилгээний хураамж	1,626	13,724,122

4	Гүйцэтгэх хуудас бичигдсэн эсэх	547	5,690,000
5	Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан эсэх	144	1,450,000
6	Иргэн /Хувь хүн харьяатаас гарах болон компанийн хувьцаа эзэмшигчид тендерт оролцоход/	294	3,060,000
7	Иргэн, Захиргааны хэрэг, баримтыг судалгаа шинжилгээний ажилд ашиглуулах	28	140,000
8	Хэргийн оролцогч баримттай танилцах	150	1,050,000
9	Материал хувилж, олшруулах	542	1,172,400
НИЙТ		10,940	75,385,522

4.Монгол Улсын шүүхээс 2022 онд нийт 49 тэрбум 670 сая 38 мянга 695 төгрөгийг төрийн санд оруулахаар шийдвэрлэжээ. Үүнээс улсын тэмдэгтийн хураамжаар 35 тэрбум 230 сая 147 мянга 895 төгрөг, торгох ялаар 11 тэрбум 369 сая 847 мянга 200, зөрчлийн хэргээр 2 тэрбум 231 сая 805 мянга 600 төгрөг хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээгээр 838 сая 238 мянга 000 төгрөгийг төрийн санд оруулахаар тус тус шийдвэрлэсэн байна.

#### **Стратеги зорилт: 5.7. Шүүхийн гадаад харилцааг хөгжүүлнэ.**

*5.7.1.шүүгчдийг бусад орны шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломжоор хангах, гадаад орны шүүгчидтэй уулзалт зохион байгуулах;*

1.2002-2012 онд хэрэгжсэн Шүүхийн тухай хуулиар Ерөнхий зөвлөлийн дарга нь УДШ-ийн Ерөнхий шүүгч байсан бөгөөд УДШ-ийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх гэж заасны дагуу шүүхийг бүрэн төлөөлж байсан. Мөн Шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны эрхлэн гүйцэтгэх ажлын чиг үүрэгт тухайн шүүхийн гадаад харилцааны асуудлыг хариуцахаар хуульчилсан байжээ.

2.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийг шүүн таслах ажиллагааны чиг үүргээс салгаж, шүүхийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэхээр хуульчилснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны бүтцэд Шүүхийн гадаад харилцааны асуудлыг эрхлэх зохион байгуулалтын нэгжийг байгуулсан байдаг.

3.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх, Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгохоор заасан.

4.Мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.23, 81 дүгээр зүйлийн 81.1.3 дахь заалтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомж, Засгийн газраас баталсан журмын дагуу гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай өөрийн эрх хэмжээний

асуудлаар байгууллага хоорондын гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Шүүхийн ерөнхий зөвлөлийг тэргүүлж, дотоод, гадаад харилцаанд төлөөлөхөөр заасан.

5.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, шүүгчдийг бусад орны шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломжоор хангах, гадаад орны шүүгчидтэй уулзалт зохион байгуулах, гадаад сургалтыг дэмжих, давтан сургалтад хамруулах, хөрөнгө оруулалт татах, шүүхийн захиргааны байгууллагын гадаад харилцаа хамтын ажиллагааг үр нөлөөг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2023 оны байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөл Олон Улсын хамтын ажиллагааны чиглэлээр 21 улсын холбогдох байгууллагуудтай урт болон богино хугацааны 26 санамж бичиг, 10 санхүүжилтийн болон бусад гэрээ байгуулан ажиллаж байна.

6.Шүүгчдийг бусад орны шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломжоор хангах, гадаад орны шүүгчидтэй уулзалт зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээнд оролцуулж ажилласан байна. Тухайлбал:

- 2001-2023 онд АНУ, ХБНГУ, Канад, БНСУ, БНХАУ, ОХУ, Турк, Польш, Унгар, Австрали, Япон, Энэтхэг, Египти, Шинэ Зеланд, Сингапур, Итали, Индонези, Палау, Квинсланд, Марокко, Мексик, Малайз, Аргентин, Бүгд Найрамдах Киргиз Улсад зэрэг 30 орчим орон Макао, Хонг Конг, Тайваны хууль зүйн салбар, шүүх, прокурорын байгууллагад айлчлах, шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаатай, танилцаж, туршлага судлахад давхардсан тоогоор 350 гаруй шүүгч, 40 орчим шүүхийн захиргааны ажилтан оролцсон байна.

- 2001 онд Шинэ Зеланд Улсын Крайсчурч хотод, 2003 онд Япон Улсын Токио хотод, 2007 онд Хонг Конгод, 2008 онд ОХУ-ын Владивосток хотод, 2011 онд БНСУ-ын Сөүл хотноо болсон Ази Номхон далайн орнуудын Ерөнхий шүүгчдийн бага хуралд, 2002-2004, 2006-2012 онд БНЭУ-ын Лакнау хотод болсон Дэлхийн Ерөнхий шүүгчдийн бага хуралд, мөн 2002 онд Мексик Улсын Валле де Браво хотноо болсон “Олон Улсын шүүгчдийн холбооны 17 дугаар бага хуралд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Иргэний хэргийн танхимын тэргүүн, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын нийтдээ 78 шүүгч оролцож Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагын дуу хоолойг олон улсын тавцанд хүргэж, бүс нутгийн болон олон улсын шүүхийн дэвшилтэд арга барилыг судалжээ.

- Бүс нутгийн болон олон улсын түвшинд тулгамдсан асуудал, гэмт хэргийн нөхцөл байдал, шийдвэрлэх талаар 2002 онд Индонези Улсын Бали хотод “Хүн дамлах, хууль бусаар зөөвөрлөх болон үндэстэн дамнасан бусад гэмт хэргийн асуудлаар”, 2005 онд Япон улсын Нагоя хотод “Монголын нүүдэлчин нийгэм ба газар өмчлөл-шилжилтийн үеийн улс орнуудын газар хувьчлал”, 2006, 2007 онд Тайланд улсад “Хүүхдийн эрхийг хамгаалах”, “Хүн худалдах, хүн наймаалах гэмт хэргийн эсрэг”, 2011 онд Сингапур улсад “Авилгын эсрэг тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг таслан шийдвэрлэх нь” 2011 онд АНУ-ын Вашингтон хотод “Шүүгчдийн оюуны өмчийн эрхийг хамгаалах” 2007 онд Хонг-Конгод “Авилгын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх зарим асуудал” 2013 онд Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо “Өөрчлөгдөж буй дэлхий ертөнц дэх шүүхийн төгс байдал”, 2015 онд БНИУ-ын Ром хотноо гишүүн болон ажиглагч улс орнуудын “Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг эрх баригчид анхааралдаа авах нь” 2016 онд БНСУ-ын Сөүл хотноо “Шүүхийн захиргааны менежментийн сайн туршлага судлах нь” сэдэвт бага хурал,



сургалт, хэлэлцүүлэгт УЛСЫН ДЭЭД ШҮҮХ-ийн эрүүгийн танхимын тэргүүн, шүүгч, нийслэлийн төвийн 6 дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч, зарим орон нутгийн шүүгчид нийтдээ 80 орчим шүүгч тус тус оролцжээ.

- Шүүх эрх мэдлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, шүүхийн шинэтгэлийн хүрээнд 2005 онд Филиппин Улсын Манила хотод “Шүүхийн шинэчлэл”, 2007 онд БНХАУ-ын Шанси мужийн Сиан хотноо “Бүс нутгийн эрх зүйн хамтын ажиллагаа”, Сингапур улсад “Ази, Номхон далайн бүсийн шүүхийн шинэтгэл төсөл-2009”, БНСУ-ын Сөүл хотноо “Судлаачдын хөтөлбөр-2009” хөтөлбөр, Сингапур улсад “Ази, Номхон далайн бүсийн шүүхийн шинэтгэл”, 2010 онд БНХАУ-ын Бээжин хотод “Ази, Номхон далайн бүсийн орнуудын Эрх зүйн шинэтгэл” форум, 2011 онд Индонези Улсын Жакарта хотод “Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст шүүхийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгох нь”, 2010 онд Беларусь Улсын Аж ахуйн шүүхээс “Эдийн засгийн хямралын үе дэх шүүхийн үйл ажиллагаа”, 2012 онд Катар улсын Доха хотод “Дэлхий дахинд хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх нь” сэдэвт чуулга уулзалтад 56 шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, 8 шүүхийн захиргааны ажилтан оролцсон ба 2013 онд АНУ-ын Вашингтон хотноо “Шүүх эрх мэдлийг сургалтаар дамжуулан бэхжүүлэх нь” форумд оролцож шүүхийн олон улсын чиг хандлагатай танилцаж, харилцан мэдээлэл солилцсон байна.

- 2006 онд АНУ-ын Ричмондын Их сургуулийн Хуулийн сургуулийн “Хууль дээдлэх ёс” сэдэвт бага хурал, 2006 онд БНХАУ-ын Шинжаан Уйгарын өөртөө засах орны Үрэмч хотноо “Бүсийн хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын бага хуралд Иргэний хэргийн танхимын тэргүүн, 2008 онд ОХУ-ын Владивосток хотноо ОХУ-ын Арбитрын Дээд шүүхээс зохион байгуулсан Ази номхон далайн бүсийн улс орнуудын “Хувийн өмч бол орчин үеийн эдийн засгийн харилцааны суурь” сэдэвт олон улсын 4 дүгээр форумд Улсын Дээд шүүхийн Судалгааны төвийн захирал оролцож, “Монгол Улс дахь өмчлөлийн эрх ба бизнесийн эрх чөлөө” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлжээ.

- 2009 онд Марокко Улсын Марракеш хотод “Олон Улсын шүүгчдийн холбооны 52 дахь удаагийн чуулга уулзалт”-д Монголын шүүгчдийн холбооны тэргүүн, төлөөлөл оролцсон нь Олон улсын шүүгчдийн холбоонд өөрийн холбооны үйл ажиллагааг сурталчлах бусад орны шүүгчдийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудын талаар мэдээлэл авах, шүүгчдийн холбооны гадаад харилцаа, холбоог өргөтгөхөөс гадна цаашид Монголын шүүгчдийн холбоог Олон Улсын шүүгчдийн холбооны жинхэнэ гишүүнээр элсүүлэхэд чиглэсэн онцгой үүрэгтэй арга хэмжээ болсон байна.

- 2010 онд Ханнс Зайделийн сангийн шугамаар ХБНГУ-ын Мюнхен мужид “Эрүүгийн эрх зүйн сургагч багшийг бэлтгэх, эрүүгийн хэргийг шийдвэрлэх, хууль хэрэглэхэд шүүгчийн сургалтын үр нөлөө” зэрэг асуудлаар Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, 12 шүүгчийн хамт туршлага судалсан байна.

- БНХАУ-ын Ардын дээд шүүхийн Сургалтын хүрээлэнтэй хамтран ажиллаж 2011-2018 он хүртэл жил тутам 10 шүүгч 5 захиргааны ажилтан сургалтад хамруулж, шүүгчдийн уулзалт, хэлэлцүүлгийн тодорхой сэдвийн хүрээнд өрнүүлж байлаа. Тайваны шүүх эрх мэдлийн тогтолцоо, шүүхийн үйл ажиллагаатай танилцах аяллыг 13 жил дараалан жил тутам 13-15 шүүгч, захиргааны ажилтныг хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд Ковид цар тахалын улмаас харилцаа түр зогссон харилцаагаа сэргээх талаар холбогдох арга хэмжээг авч байна.

- 2013 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн сангийн "Засаглал, ил тод байдлыг дэмжих", Дэлхийн банкны санхүүжилттэй "Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах", Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах", "ЖАЙКА" Олон улсын байгууллагын "Эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог сайжруулах", Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын "Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийн чадавхыг бэхжүүлэх", "Нээлттэй шүүх", 2022-2023 онд "Жендерийн мэдрэмжтэй, сайжирч хөгжсөн шүүхийн тогтолцооны үр шимийг Монгол Улсын иргэд хүртэх нь" төслийг Канад Улсын техникийн туслалцааны түншлэлийн хүрээнд "Канад Улсын Холбооны Шүүхийн Комиссарын албатай хамтран 7 сарын хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн.Төслийн үр дүнд Шүүхийн ерөнхий зөвлөл Канад Улсын шүүхийн тогтолцоотой танилцах, туршлага судлах, Монгол Улсын шүүхийн тогтолцоонд жендерийн мэдрэмжийг нэвтрүүлэх стратеги боловсруулах, Ёс зүй, жендерийн тэгш байдал, мэргэжлийн зан үйлтэй холбоотой шүүхийн хүний нөөцийг бэхжүүлэх, хөгжүүлэх, энэ талаарх арга барил, туршлагын талаар гол оролцогч талуудад танилцуулах, олон нийтийг мэдлэг, мэдээллээр хангах, тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч олон талын арга хэмжээг хамтран зохион байгуулж ажиллав.

- 2015 онд Аргентин улсад болсон Олон улсын шүүгч эмэгтэйчүүдийн холбооны 14 дүгээр их хуралд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2 шүүгч, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн дарга нар оролцжээ.

- 2017 оны 10 дугаар сарын 04-06-нд БНТУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор тус улсын Хууль зүйн академиас зохион байгуулсан "Эрх зүйн боловсролын олон улсын симпозиум"-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн оролцсон.

- 2018 оны 06 дугаар сарын 13-ний өдөр "Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар" сэдэвт онол-практикийн олон улсын бага хуралд оролцохоор ирсэн Олон улсын эрх зүйн байгууллагын зөвлөх, удирдлагын багийн гишүүн Клифф Жонссон, Төв Ази, Зүүн Европын хөтөлбөрүүдийн бүсийн менежер Маргарита Милих, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Хуулийн ерөнхий зөвлөх, удирдах зөвлөлийн гишүүн Марие-Анне Биркен, Эрх зүйн шилжилтийн багийн дарга Мичел Нуссбаумер нарыг Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хүлээн авч уулзсан бөгөөд Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлалын төслийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран ажиллах саналтай байгаагаа Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төлөөлөгчид илэрхийлсэн. Мөн төлөөлөгчид "Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар" сэдэвт онол-практикийн олон улсын бага хуралд илтгэл тавьж оролцсон.

- 2022 оны 11 сард Бүгд Найрамдах Финланд Улсын Хельсинки хотод Олон Улсын шүүхийн захиргааны холбооны хуралд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс анх удаа оролцсон ба хурал "Ковидын дараах нөхцөл байдалд иргэн төвтэй шударга ёсыг бэхжүүлэх нь" сэдвийн дор болсон ба гишүүн Л.Энхбилэг оролцсон.

- 2022 оны 10 дугаар сарын 24-28-ний өдрүүдэд Олон Улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-аас Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр "Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг

бэхжүүлэх” төслийг 2019-2023 онд манай Улсад хэрэгжүүлж буй. Энэ хүрээнд Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран Канад Улсын Онтарио мужийн Торонто хотод туршлага судлах үйл ажиллагааг “Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд гэр бүлийн шүүх, гэр бүлийн хүчирхийллийн хэргийн дагнасан шүүхтэй танилцах Канад Улсын сайн туршлагыг судлах нь” сэдвээр зохион байгуулсан ба айлчлалд шүүхийн ерөнхий зөвлөлийн 3 гишүүн, УДШ-ийн 1 шүүгч оролцсон.

- 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Монгол Улс Канадын Холбооны Улсын Шүүхийн Комиссарын Албатай хамтран хоёр улсын жендерийн мэдрэмжтэй байдлыг шүүхийн тогтолцоонд нэвтрүүлэх төслийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, 2 гишүүн, ШСХ-ны дарга, 3 гишүүн Канад Улсын Оттава хотод айлчилсан ба айлчлалын хүрээнд Канадын Холбооны Шүүхийн асуудал эрхэлсэн Комиссын Тамгын газраас Монголын шүүхийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, шүүгчдийг томилох, тэдний ёс зүйн байдлыг хангах, олон нийтийн итгэлийг бий болгоход Канадын шүүхийн туршлагаас хуваалцав. Төслийн хүрээнд Монгол Улсын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтран ажиллаж, шударга ёсыг тогтоох, түүнчлэн эмэгтэйчүүдийн эрх зөрчигдсөн хууль бус үйлдэл, гэмт хэргээс ял шийтгэлгүй үлдэх байдлыг бууруулахаар зорьж байна. Энэ тал дээр Канадын мэргэжилтнүүдийн бодлого, туршлага, гарсан ахиц дэвшлийг судалж үзсэний дараа шүүхийн тогтолцоонд жендерийн асуудлаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд илүү үр дүнтэй, нухацтай хариу арга хэмжээ авдаг байдлыг идэвхжүүлнэ.

- 2022 оны 11 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн буцалтгүй тусламжаар Монгол Улсад 2020-2025 онд хэрэгжүүлж буй “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чадамжийг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга тэргүүтэй төлөөлөгчид ХБНГУ-ын Хессен мужид ажиллаж, Хессен муж Улсын Хууль зүйн яам, Улсын Дээд шүүх, Шүүхийн мэдээллийн технологийн нэгдсэн алба, Франкфурт хот дахь анхан шатны шүүх, Ротенбург а.д.Фулда дахь Санхүүгийн удирдлага, шүүхийн захиргааны сургууль, ГОУХА-ны нийгэмлэг (GIZ)-ийн төвд зочилж, шүүхийн захиргааны мэргэшсэн албан хаагч бэлтгэх болон мэргэшүүлэх сургалтын тогтолцоо, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаа болон шүүхийн байгууллагын цахимжуулалтын үйл явцтай танилцаж, туршлага судлав.

### *5.7.2.Монгол Улсын шүүх, бусад орны шүүхийн хооронд мэргэжлийн харилцаа, холбоо тогтоох, хөгжүүлэх*

1.2014 онд Бүгд Найрамдах Турк Улсын Хууль Зүйн Академи, 2015 онд БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль, 2015 онд БНХАУ-ын Чанчуны Техникийн Их сургуулийн Хууль Зүйн Сургууль, 2015 онд ХБНГУ-ын Ханнс-Зайделийн Сангийн "Эрх зүйн боловсрол" академи, 2018 онд БНСУ-ын Чонбукын Үндэсний Их Сургуулийн Зүүн Хойд Азийн Эрх Зүйн Хүрээлэн зэрэг байгууллагатай Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийг төлөөлөн харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэргэшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулж, нийтдээ 100 орчим шүүгч, 20 гаруй захиргааны ажилтан хамрагджээ.

2.Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах талаар Европын холбооны Техникийн туслалцаа, мэдээлэл солилцооны (TAIEX)” хөтөлбөрт санал өгснөөр 2023 онд уг хөтөлбөр хэрэгжиж шүүхийн мэдээллийн технологийн ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 20-31-ний өдрүүдэд Итали

Улсын Шүүгч асан, Итали улсын Писа дахь Шүүхийн Ассамблейн ерөнхийлөгч, Шүүхийн үр нөлөөт байдлын төлөөх Европын Комиссын зөвлөл (СЕРЕJ)-ийн КИБЕР ШҮҮХ ажлын хэсгийн ерөнхийлөгч Хатагтай Мария Жулиана Сивинини, Австри Улсын Вена хот дахь Захиргааны хэргийн шүүгч, Цахим шүүх ба суурь эрхийн олон улсын байгууллагын Гүйцэтгэх захирал Ноён Гернот Пош, Эстони Улсын Хууль зүйн яамны Зөвлөх Хатагтай Маргит Лаури нарын илтгэл хэлэлцүүлэгт оролцуулах харилцан мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүллээ.

3.АНУ-ын Муж улсуудын Шүүхийн Үндэсний Төв, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 5 жилийн хугацаатай /2020.05.13-2025.05.13/ “Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургах, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, шүүх эрх мэдлийн тогтолцоог сайжруулах, шүүхийн захиргааны удирдлагын орчин үеийн чиг хандлага, арга барилыг Монгол Улсын шүүхэд нэвтрүүлж, хэрэгжүүлэх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны чадавхыг нэмэгдүүлэх” зорилгоор байгуулсан санамж бичгийн хүрээнд туршлага судлах, хамтарсан сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2023 оны 04 дүгээр сарын 12-нд “Орчин үеийн шүүхийн байр, шүүхийн шинэлэг үйл ажиллагаа ба орон зай” сэдвээр, 19-ний өдөр “Хэргийн хөдөлгөөний менежмент: Зарчим, сайн туршлага, стратеги” сэдвээр тус тус сургалт зохион байгуулж шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, хууль өмгөөлөгч нийтдээ 1800 орчим оролцогч хамрагдлаа.

## **Суурь үнэлэхүй 6. БҮТЭЭМЖТЭЙ БАЙХ**

*“Хуулийг чанд баримталж улсын хэмжээнд хуулийг нэг мөр хэрэглэх чадвар”*

Стратеги зорилт 6.1. Хэрэг, маргааныг бүтээмжтэй шийдвэрлэх зорилгоор дагнасан шүүх болон шүүхийн дагнасан танхимыг байгуулна.

*Арга хэмжээ 6.1.1.Зарим орны захиргааны болон бусад дагнасан шүүхийн тухай хууль, тэдгээрийн үйл ажиллагаатай танилцаж хэрэгжүүлэх арга замыг судлах*

Үндсэн хуулийн Дөчин ёсдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “...Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно...” гэж заасан.

1.Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд тухайн үед Австри, АНУ, БНСУ, Япон зэрэг улсад танилцах аялал зохиосон байна.

2.ШЭЗШ төслийн санхүүжилт, Ханнс-Зайделийн сангийн зохицуулалт, тусламжтайгаар ХБНГУ-ын Үндсэн хуулийн болон захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаатай Үндсэн хуулийн цэц, УДШ, ХЗДХЯ-ны ажилтнууд болон судлаагчид тухайлан биечлэн танилцаж, эрх зүйн зохицуулалт, практикийн судалгаа хийжээ.

3.Захиргааны хэргийн шүүхийн үүсэл хөгжлийн болон эрх зүйн зохицуулалтын асуудлаар монголын судлаачид ХБНГУ, АНУ-ын эрдэмтдийн хамтарсан эрдэм шинжилгээний ажил хийсэн нь онолын судалгааны гол ололт нь болжээ. Түүний үр дүнд “Захиргааны хэргийн шүүх” сэдэвт томоохон зохиол бичиж, монголын хуульчдын хүртээл болгосон байна.

*Арга хэмжээ 6.1.2.Захиргааны болон бусад дагнасан шүүх буюу танхимын ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх*



1. Улсын Их Хурал Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг 2002 онд баталснаар Монгол Улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулах хуулийн үндэс тавигджээ.

2. Захиргааны хэргийн шүүх 2004 онд байгуулагдсанаар захиргааны хэргийн шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүхийн тогтолцоо бий болсон байна.

3. Улсын Их Хурал 2010 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хуулийг баталсан бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2011 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллаж эхэлсэн.

4. Улсын Их Хурал 2015 онд Шүүх байгуулах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, 2016 онд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус баталсан бөгөөд нийслэл, 21 аймагт захиргааны хэргийн анхан шатны шүүх, улсын хэмжээнд давж заалдах шатны шүүх, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим ажиллаж байна.

5. Захиргааны хэргийн шүүх нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага зэрэг нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлдэг онцлогтой бөгөөд газрын, төрийн алба, ашигт малтмал, татвар, тусгай зөвшөөрөл, Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгч, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаан, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан зэрэг Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж байна.

*Арга хэмжээ 6.1.3. Хуульчид, шүүгчдийг тодорхой төрлийн хэргээр мэргэшүүлэн ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах*

1. Монгол Улсад 2004 оноос эхлэн Захиргааны хэргийн шүүх ажиллах болсноор дагнасан шүүх ажиллах эхлэл тавигдсан юм.

2. 2013 оны Шүүх байгуулах тухай хуулиар шүүхүүдийн байршил, нутаг дэвсгэрийн харьяалалд өөрчлөлт оруулан, нийслэл болон зарим орон нутгийн анхан болон давж заалдах шатны шүүхийг иргэн, эрүү, захиргааны хэргийн төрлөөр нь бие даан дагнуулж байгуулсан.

3. Эрүүгийн болон Иргэний хэргийн анхан шатны шүүх 21 аймаг, 9 дүүрэгт, захиргааны хэргийн анхан шатны шүүх 21 аймаг, нийслэлд ажиллаж байна.

4. 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар орон нутаг дахь сум дундын 8 шүүхээс бусад анхан шатны болон давж заалдах шатны бүх шүүх иргэн, эрүү, захиргааны хэргийн төрлөөр шүүн таслах ажиллагаагаар дагнан ажиллаж байна. Үүний үр дүнд шүүгч эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажлын төрлөөр мэргэшиж, ур чадвар дээшлэх, хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг шуурхай, үр бүтээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоо бүрдсэн байна.

5. Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтыг шүүн таслах ажлын төрлөөр ялгаатай байдлаар авч байгаа нь шүүгч дагнан мэргэших нэгэн нөхцөл болж байна.

6.Шүүгчийн сургалтын хөтөлбөрийг шүүн таслах ажлын төрлөөр ялгамжтай боловсруулан сургалт явуулж айгаа шүүгчийг дагнан мэргэших нөхцөлийг бүрдүүлж байна.

## **Стратеги зорилт: 6.2. Шүүн таслах ажиллагааны менежментийг боловсронгуй болгоно.**

*Арга хэмжээ 6.2.1.Шүүх хуралдааны танхимын зохион байгуулалтыг хэргийн оролцогчид харилцан ойлголцох, тайван уур амьсгалыг бүрдүүлэхүйц, зохих харуул хамгаалалттайгаар зохион байгуулах асуудлыг тусгай журам, заавраар зохицуулах асуудлыг хуульд тусгах*

Шүүн таслах үйл ажиллагааны гол хэлбэр нь шүүх хуралдаан юм. Шүүх хуралдааны танхим нь шүүгч хэрэг маргааныг хараат бусаар шийдвэрлэх, хэргийн оролцогч нэхэмжлэл, гомдлоо чөлөөтэй танилцуулах, хүсэлт гаргах нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Энэ арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх 2 асуудал байдаг.

### **Нэг.Стандартад нийцсэн шүүх хуралдааны танхимтай байх**

1.Өмнө нь Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2006 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолоор “Шүүх хуралдааны танхимын загвар”-ыг баталсан байдаг.

2.2012 оны Шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т “Шүүх , шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим ... хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.” гэж заасан. Энэ хүрээнд Шүүхийн Ерөнхий зөвлөл 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 100 дугаар тогтоолоор “Шүүхийн байрны нийтлэг шаардлага буюу Шүүх хуралдааны танхимын бүрэлдэхүүн хэсэг, зохион байгуулалт, оролцогчдын байршлын зураглал”-ыг шинэчлэн баталсан. Энэ нь эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдааны танхимын зохион байгуулалтын нэгдсэн стандартыг бий болгосон ач холбогдолтой.

3.2016 онд Нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд иргэнээ дээдэлсэн, нээлттэй, орчин үеийн стандарт бүхий шүүх хуралдааны жишиг танхимыг байгуулсан.

4.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.4-д “Шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах стандартад нийцсэн шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, зураг төсвийг захиалан боловсруулах, гүйцэтгэлийг хангах;”, 74.2-д “Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Ерөнхий зөвлөл тогтооно.” гэж заасан. Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн байрны стандартыг шинэчлэн боловсруулж байна.

5.Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шүүх хуралдааны танхимын нийтлэг стандартыг баталсан хэдий ч төсөв хөрөнгийн асуудлаас шалтгаалан практик дээр

тус стандарт төдийлөн хэрэгжихгүй байна. Тухайлбал “Шүүхийн байрны нийтлэг шаардлага”-ын 3.3-д “...шүүх хуралдааны танхим зөвлөлдөх тасалгаатай байна.” гэжээ. Гэвч өнөөдрийн байдлаар шүүх хуралдааны танхим бүрийг зөвлөлдөх тасалгаатай болгож чадаагүй байна. Анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн 41 тамгын газар 128 шүүх хурлын танхим 62 зөвлөлдөх тасалгаатай байна. Зөвлөлдөх тасалгаагүй 66 танхим байна.

Шүүхийн хэмжээнд 127 шүүх хуралдааны танхим байгаагаас цахим хурал хийх боломжтой дууны, дуу-дүрсний төхөөрөмж бүхий танхим одоогоор 71 байна. Үүнээс 30 танхимын тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа бол 41 танхимын тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан байна. 2022 онд 28 ширхэг дууны, дуу-дүрсний төхөөрөмжийг шинэчилсэн байна.

### **Хоёр.Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах**

1.2002 оны Шүүхийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүгдэгчийг хуяглан хүргэх ... үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.”, 75.3-т “Шүүхийн хуяг нь шүүх хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй цагдаагийн байгууллагын ажилтан байна.” гэж заасны дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг Цагдаагийн байгууллага хангаж иржээ.

2.2012 оны Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг тахарын алба гүйцэтгэнэ.”, 30.3-т “Энэ хуулийн 30.2-т заасан үүргийг гүйцэтгэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж тус тус заасан

2.2013 онд Тахарын албаны тухай хууль батлагдаж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, энэ хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Тахарын алба байгуулагдсан. Тахарын ерөнхий газар, тойрог, хэсгийн тахарын алба нийт 79 шүүхийн 41 тамгын газрын 43 албан байрыг шинээр тогтоосон хамгаалалтын бүсийн хүрээнд 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хамгаалалтад авч хуулийн дагуу ажиллаж эхэлсэн.

Шүүхийн тухай багц хууль, Тахарын албаны тухай хуульд заасны дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, Хууль Зүйн сайдын хамтарсан тушаалаар “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг батлан хэрэгжүүлснээр шүүхийн байр, шүүгчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн. Үүний үр дүнд шүүгч шүүн таслах ажиллагааг явуулахдаа аливаа халдлагаас хамгаалагдах, сэтгэл зүйн таатай орчин бий болж, шүүгч хараат бус, шүүхийн хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн байсан.

Гэвч 2016 онд Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болгож, Тахарын албыг татан буулгаж, чиг үүргийг нь цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тус тус шилжүүлсэн.

Үүнтэй холбоотойгоор 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаартай Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны сайдын хамтарсан тушаалаар “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

21 аймгийн шүүх, Улаанбаатар хотод байрлах Эрүү, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг нэгдсэн шилэн кабелийн сүлжээнд холбогдсоноор Интернэт түгээх байгууллагатай холболтын гэрээ байгуулан Шүүхийн Ерөнхий зөвлөл, Нийслэл, дүүрэг, орон нутгийн нийт шүүхийн интернэтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлснээр сүлжээний тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж өндөр хурдны /1000Mbps/ интернэтэд холбосон.

Одоогийн байдлаар, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцан ажиллаж байна.

*Арга хэмжээ 6.2.2.Иргэдэд учирч болох бэрхшээлийг багасгах үүднээс шүүхэд хандаж гаргах бичиг баримтын эх загвар, маягтыг нэгдсэн стандартад оруулах*

Иргэн болон захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн загварыг боловсруулж, нэгдсэн стандартад оруулж байна.

Шүүн таслах ажиллагаатай холбоотой мэдээлэл, улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээ, түүнийг тушаах банкны дансны дугаар зэрэг мэдээллийг Shuukh.mn цахим хуудас болон тухайн шүүхийн цахим хуудаснаас үзэх, хэвлэмэл байдлаар авах мэдээллийн боломж хүртээмж нэмэгдсэн байна.

*Арга хэмжээ 6.2.3.Шүүхийн менежментийн асуудлыг мэргэжлийн түвшинд хариуцаж гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэж ажиллуулах, шүүхүүдийг компьютерийн нэгдсэн сүлжээнд холбох зэрэг шүүн таслах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлийн судалгаа хийх, холбогдох арга хэмжээ авах*

1. Бүх аймгийн шүүх, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүд шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдсон.

2. Шүүхийн ерөнхий зөвлөл, нийслэл, дүүргийн болон аймаг, сум дахь нийт шүүхийн интернэтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын зардлыг төсөвт үе шаттай тусган санхүүжүүлж ирсэн бөгөөд сүлжээний тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилснээр өндөр хурдны /1000Mbps/ интернэтэд бүрэн холбогдсон.

3. Шүүн таслах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр 3 төрлийн программ хангамжийг боловсруулан 2013, 2015 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэж байна. Тухайлбал,

- Иргэн хэргийн программ талаар: 2013 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төслийн санхүүжилт, дэмжлэгээр “Иргэн-1” программыг иргэний хэргийн шүүхүүдэд анх нэвтрүүлсэн бөгөөд тус программын баазыг 2014 онд “Иргэн-2014” Иргэний хэргийн нэгдсэн системд нэгтгэснээр нийт шүүхийн хэмжээнд Оффис-2013 программ хангамжийг нэвтрүүлэн хэвийн ажиллагааг хангагдан ажиллаж байна.



- Захиргааны хэргийн программ талаар: 2013 оноос эхлэн Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”-тэй хамтран Захиргааны хэргийн бүртгэл, мониторингийн программыг боловсруулж, захиргааны хэргийн шүүхүүд нэвтрүүлж эхэлснээр хэвийн ажиллагааг нь хангагдан ажиллаж байна.

- Эрүүгийн хэргийн программ талаар: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2015 оноос эхлэн Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын төрийн холбооны суурь сүлжээний орчинд суурилсан нэгдсэн сүлжээний орчин үүсгэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг дамжуулах, хүлээн авах боломжтой, процессын ажиллагааг дэмжсэн шүүхийн бүртгэлийн систем болох Эрүүгийн хэргийн нэгдсэн программ хангамжийг шүүхүүдэд нэвтрүүлжээ.

4.2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т “..шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг ... зохион байгуулах” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасан бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Шүүхийн захиргааны ажилтан Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн тогтмол сургалтад заавал хамрагдана.” гэж хуульчилсан байдаг. Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэдээлэл, судалгаа, сургалтын хүрээлэнгээс хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу шүүхийн захиргааг мэргэшүүлэх, шүүхийн тамгын газрыг мэргэшсэн шүүхийн захиргааны ажилтнаар бүрдүүлэх зорилгоор шүүхийн ажилтнуудыг мэргэшүүлэх, дадлагажуулах дотоод сургалтуудыг тогтмол зохион байгуулж ирсэн.

5.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.6-д “... шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Улсын дээд шүүх болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн Тамгын газрын мэдээллийн технологийн ажилтнуудад жил бүр сургалт явуулж, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх арга хэмжээ авч байна.

*Стратеги зорилт: 6.3. Монгол Улсын хуулийн албан ёсны тайлбарыг цаг тухайд нь гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.*

Улсын дээд шүүх хуулийн тайлбарыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) болон Улсын дээд шүүхийн цахим хуудаст тухай бүр байршуулж байгаагийн зэрэгцээ “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлж байна.

*Арга хэмжээ 6.3.1.Шинээр гарсан болон эргэлзээтэй, хоёрдмол утгаар ойлгож болох хуулийн зүйл, заалтуудыг Улсын дээд шүүхээс тайлбарлах ажиллагааг шуурхай, боловсронгуй болгох асуудлыг судлах*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 4-т Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргахаар заасан.

2.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтад Улсын дээд шүүх “шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах ...” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.”, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “... Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, ... бэлтгэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.” гэж заажээ.

Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхим шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулахаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-т зохицуулжээ.

3.Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллаж байна.

4.Улсын дээд шүүхээс 2022 онд 5, 2023 онд 2 удаа хуулийн албан ёсны тайлбар гаргасан байна.

*Арга хэмжээ 6.3.2.Хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан Улсын дээд шүүхийн тогтоолыг боловсруулах, хэлэлцэж батлах, цаг тухайд нь гаргаж байх ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох*

2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтад Улсын дээд шүүх “шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах ...” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасны дагуу Улсын дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан Улсын дээд шүүхийн тогтоол гаргах ажиллагаа жигдэрсэн байна.

*Арга хэмжээ 6.3.3.Улсын дээд шүүхийн тайлбарыг цаг тухайд нь шуурхай хүргэх механизм бүрдүүлэх, тайлбарын эмхэтгэлээр хуулийн байгууллагын албан хаагчдыг хангах*

1.Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлэн нийтийн хүртээл болгож байна.

2.Улсын дээд шүүхийн албан ёсны [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) сайтад хууль тайлбарласан тогтоолын сан бүхий мэдээллийн цонхноос Улсын дээд шүүхийн тогтоолтой танилцах боломжтой болсон.

3.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст Улсын дээд шүүхийн тогтоолыг байршуулж хэвшсэн.

4.Монгол Улсын бүх шүүхийн шийдвэрүүдийн нэгдсэн сан болох [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад Улсын дээд шүүхийн шийдвэрүүд тогтмол байршуулж байна.

**Стратеги зорилт 6.4.Хуульчдыг бэлтгэж байгаа сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгад судалгаа хийж, сургалтын хөтөлбөрт тавигдах стандартыг тогтоох, хяналт тавих тогтолцооны талаар санал гаргана**

*Арга хэмжээ: 6.4.1.Хуулийн сургуулиудыг магадлан итгэмжилж баталгаажуулах, магадлан итгэмжлэлийн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох санал гаргах*

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь дээд боловсролын сургалтын байгууллагыг тус зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг хангаж буй эсэхийг үнэлэн магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг Хөтөлбөрийн төлөвлөлт, Сургалтын үйл ажиллагаа, Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа, Багшийн үйл ажиллагаа, Чанарын үнэлгээ, баталгаажилт гэсэн үндсэн шалгуураар магадлан итгэмжлэхээр тогтоосон байна. Суралцагч дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хамрагдсанаар олж авах мэдлэг, ур чадвараас гадна хувь хүний ямар чадвар, чадамжид суралцсан байх шаардлагыг оруулсан байна.

*Арга хэмжээ 6.4.2.хуулийн сургуулиудад заавал заах хичээлүүдийн нэгдсэн агуулга, хөтөлбөрийн талаарх санал гаргах*

Хууль зүйн их, дээд сургуулиуд 2018 онд батлагдсан “Эрх зүйн боловсролын бакалаврын стандарт”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

**Стратеги зорилт 6.5.Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны мэдлэг, боловсролыг цаг үеийн шаардлагад нийцүүлнэ.**

*Арга хэмжээ:6.5.1.Хуульчдыг давтан сургаж бэлтгэх ажлыг эрхлэх шүүгчдийн сургалтын байгууллага /төв/ байгуулах*

1.”Хууль зүйн үндэсний төв”-ийг Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хууль зүйн мэдээллийн төв, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Прокурорын давтан сургалтын төв, Цагдаагийн академийн дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэн болон Хуульчдыг давтан сургах төвийг нэгтгэн байгуулжээ. Мөн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 222 дугаар тушаалаар баталсан байна.

3.Хууль зүйн үндэсний төвийг Засгийн газрын 2009 оны 18 дугаар тогтоолоор “Хууль зүйн үндэсний хүрээлэн” болгож өөрчлөн зохион байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 33 дугаар тушаалаар тус хүрээлэнгийн дүрэм, 62 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталжээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн чиг үүргийн нэг нь эрх зүйч, хуульчдын мэдлэг, хуулийн байгууллагын ажилтны ёс зүй, ур чадварыг

дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу болон захиалгаар зохион байгуулах ажил байдаг.

4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн 2014 онд байгуулагдан шүүгч, шүүхийн захиргааны ажилтны сургалтыг зохион байгуулж ирсэн.

5.2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд байгуулагдсан. Тус хүрээлэн шүүгчийн сургалтыг зохион байгуулж байна.

*Арга хэмжээ: 6.5.2.хуульчдыг сургах, давтан сургах хөтөлбөр тус бүрийн хүрээнд хуульчдын ёс зүйн тухай хичээлийг заадаг болох*

Шүүгчийн сургалтыг 2012 оноос 2021 он хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, 2021 оноос өнөөдрийг хүртэл Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн зохион байгуулж байгаа бөгөөд шүүгчийн сургалтын хөтөлбөрт хуульчдын ёс зүй, сахилга хариуцлагын талаар тусгайлсан сэдвийг оруулан хичээл зааж байна.

*Арга хэмжээ: 6.5.3.шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтныг сургах, давтан сургах хөтөлбөрийг үндэслэн шаардлагатай зардлыг төсөвлөсөн хэмжээгээр тухайн байгууллагын төсөвт тусган баталж байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх*

1.2012 оны Шүүхийн тухай хуулийн 28.2-д “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд Монгол Улсын шүүхийн төсөв нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.”, 2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5.6-д “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэж заасны дагуу шүүгч, шүүхийн захиргааны ажилтын сургалтыг танхимын хэлбэрээр тасралтгүй явуулж ирсэн.

2.Улсын Их Хурлаас 2022 онд баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх,” гэж зааснаар сургалтын төсвийн асуудал хүндэрсэн.

*Арга хэмжээ: 6.5.4.шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны үйл ажиллагаанд зориулсан гарын авлага, ном, сурах бичгээр хангах, тэдгээрийг тухай бүр шинэчлэн баяжуулж байх*

1.2014 оноос 2021 он хүртэл хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс шүүгч, шүүхийн захиргааны ажилтны сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан, сургалтын гарын авлага, сурах бичгийг зохион хэвлүүлж ирсэн. Энэ хүрээнд Үндсэн хууль ба Хүний эрх, Шүүгчийн ёс зүй, эрүү, иргэн, захиргааны сургалтуудын гарын авлагуудыг гаргаж байсан.

2.Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлийг бэлтгэн хэвлүүлж нийтийн хүртээл болгож ирсэн.



3.Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургалтын нэгдсэн мэдээллээр хангах “Шүүхийн сургалтын каталоги”, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл, Шүүхийн захиргааны ажилтны сургалтын бодлого зэргийг жил бүр шинэчлэн боловсруулж, агуулгыг баяжуулан ажилтнуудын хүртээл болгож байна.

*Арга хэмжээ: 6.5.5.Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудыг тодорхой хугацааны давтамжтайгаар давтан сургалтад заавал хамруулж байх сургалтын цикл бий болгож мөрдүүлэх*

1.Шүүхийн ерөнхий зөвлөл 2014 оноос шүүхийн захиргааны ажилтныг сургах, давтан сургах хөтөлбөр гарган шүүхийн тамгын газрын даргын, шүүгчийн туслахын, шүүх хуралдааны нарийн бичгийн, шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний, мэдээллийн технологийн мэргэжилтний, эвлэрүүлэн зуучлагчийн, архивчийн, нягтлан бодогчийн сургалтыг зохион байгуулж ирсэн.

2.2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72.1.6-д “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Улсын дээд шүүх болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;” мөн хуулийн 94.1-д “Шүүхийн захиргааны ажилтан Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдана.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл цогц чадамж бүхий шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх болон мэргэшүүлэх, мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор “Шүүхийн захиргааны ажилтны сургалтын бодлого”-ыг 2022 онд баталсан.

3.Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв 2022 онд бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх чиглэлээр 21 удаагийн сургалтыг 97 өдрийн турш зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1951 шүүхийн захиргааны ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.

*Арга хэмжээ: 6.5.6.Шүүх эрх мэдлийн байгууллагын зүгээс нийт хуульчдыг сургах, давтан сургах хөтөлбөрт оруулах ерөнхий шаардлагын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх*

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах журмыг Монголын хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо батлахаар хуульчилжээ.

Хуульчийн үргэлжилсэн сургалтаар гурван жил тутам хангах ба хуулийн багц цагийн гуравны хоёроос доошгүй нь тухайн мэргэшсэн чиглэлийн сургалтын агуулгыг багтаасан байхаар хуульд заажээ.

Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж батлуулах үүргийг хуулиар хүлээсэн байна.

Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо нь хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ

хийх болон хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох, хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг хариуцахаар хуульд заажээ.

*Арга хэмжээ: 6.5.7. Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтанд хуульчдыг сургах, давтан сургах хөтөлбөрт хамрагдан мэргэшлийн шалгалт өгсөн байдлыг үндэслэн зэрэг дэв, мэргэшлийн зэрэг олгодог механизм бий болгох*

2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагуу шүүгчид зэрэг дэвийн болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохгүй байна.

Шүүхийн захиргааны ажилтнуудад зэрэг дэв олгох, мэргэшлийн зэрэг олгох ажлыг Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” болон санхүү, архив, албан хэрэг хөтлөлтийн зэрэг салбарын хууль тогтоомжид заасны дагуу зэрэг дэв, мэргэшлийн зэргийг шийдвэрлэж байна.

*Арга хэмжээ 6.5.8. Дагнасан шүүхийн буюу танхимын шүүгчийг өөрийнх нь дагнасан салбар, чиглэлийн сургалтад оролцуулж, мэргэшүүлэх нөхцөл бүрдүүлэх;*

2012 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 3.1.2. "дагнасан шүүх" гэж эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг ойлгоно гэж, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 3.1.1-д "дагнасан шүүх" гэж эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулсан шүүхийг ойлгоно гээд, мөн хуулийн 13.3-д “Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан байна.

2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 10.1.4-д “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Хуульчдын холбоо, Төрийн албаны зөвлөл болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;” гэж, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24.1-д “Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.” хуульчилсан. Шүүгчийн сургалтын хөтөлбөрийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан боловсруулж, хичээлийн сэдвийг бүр нарийвчлан маргааны төрлөөр сургалт явуулж байна.

*Арга хэмжээ 6.5.9. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтныг сургах, давтан сургах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх*

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны А/274 дүгээр тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад хамруулах журам”-ыг баталсан байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны А/234 дүгээр тушаалаар тус журамд өөрчлөлт оруулсан байна.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ахлагч болон офицерийн хүний нөөцийг Хууль сахиулах их сургуулийн харьяа Ахлагчийн сургууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуульд сургаж бэлтгэдэг байна.

4.Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор Хууль сахиулах их сургуульд бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад хамруулах зэрэгцээ албаны болон мэргэшлийн сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулдаг байна.

*Арга хэмжээ: 6.5.10.шүүхийн захиргааны ажилтнуудыг шүүхийн менежментийн чиглэлээр сургах сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулж мөрдүүлэх*

2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72.1.6-д “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Улсын дээд шүүх болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;” мөн хуулийн 94.1-д “Шүүхийн захиргааны ажилтан Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдана.” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 64 дүгээр тогтоолоор “Шүүхийн захиргааны ажилтны сургалтын бодлого”-ын баримт бичгийг баталсан. Энэ бодлогыг баталснаар шүүхийн захиргааны ажилтны сургалтыг зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг харилцан уялдаатай, цогц байдлаар хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

*Арга хэмжээ: 6.5.11.хуульчдыг болон шүүгчдийг сургах, давтан сургах ажилд төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах, тэдэнтэй хамтран ажиллах боломжийг судалж хэрэгжүүлэх*

Шүүхийн захиргааны ажилтныг сургах, давтан сургах үйл ажиллагаанд ЖАЙКА, ГИЗ, Нээлттэй нийгэм форум, Ханнс-Зайделийн сан зэрэг гадаадын төсөл, хөтөлбөрийн байгууллагууд болон нарийн мэргэжлийн чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.

## **ХОЁР.СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээг 6 суурь үнэлэхүйн, тэдгээрийн хүрээнд дэвшүүлсэн зорилт тус бүрээр дор гаргав.

### **Нэг.Хараат бус байх**

Энэ суурь үнэлэхүйг хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн харилцан тэнцвэрийг хангахуйц шүүх эрх мэдлийн улс төр, эдийн засаг, зохион байгуулалтын болон шийдвэр гаргах хараат бус байдлаа хамгаалах чадвараар үнэлэхээр тодорхойлсон байна.

Шүүхийн хараат бус байдал нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал гэсэн хоёр хэсгээс бүрдэхээр Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улсын Их Хурлаас 2021 онд шинэчлэн баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүхийн бие байдал, шүүгчийн хараат бус байдлын эрх зүйн баталгааг бүрдүүлж чадсан байна.

Уг суурь үнэлэхүйн хүрээнд 7 зорилт, 21 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Суурь үнэлэхүйн 1 дэх зорилт нь шүүгч бие дааж шийдвэр гаргах боломжийг хангахуйцаар бүх шатны шүүхийн хоорондын харилцааг боловсронгуй болгоход чиглэгдсэн байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүхийн шатлал хоорондын хараат бус байдал хангагдсан бөгөөд доод шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх бүрэн өөрчлөх хуулийн зохицуулалт, практик хэрэгжиж байна.

Суурь үнэлэхүйн 2 дахь зорилт нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль бус шийдвэрт тавих хяналтын механизм бий болгоход чиглэгдсэн байна. Монгол Улсад захиргааны хэргийн дагнасан шүүхийн тогтолцоо бий болсноор энэ зорилт хангагдсан байна.

Суурь үнэлэхүйн 3 дахь зорилт нь Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн байна. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улсын Их Хурлаас 2021 онд шинэчлэн баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилыг хорооны эрх хэмжээг тогтоож, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай харилцах эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгаснаар энэ зорилтыг биелсэн гэж үзэж байна.

Суурь үнэлэхүйн 4 дэх зорилт нь Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн байна. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улсын Их Хурлаас 2021 онд шинэчлэн баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилыг хорооны эрх хэмжээг тогтоож, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай харилцах эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгаснаар энэ зорилтыг биелсэн гэж үзэж байна.



## **ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

УИХ-аас “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлээд 23 жил болж байна.

Энэ хугацаанд шүүх эрх мэдлийн салбарт хийгдсэн эрх зүйн шинэчлэл, тогтолцооны шинэтгэлийн үр дүнд Стратеги төлөвлөгөөний Хараат бус байх, Хариуцлага хүлээдэг байх, Мэдрэмжтэй байх, Шударга байх суурь үнэлэхүйн хүрээнд дэвшүүлсэн стратеги зорилтууд үндсэндээ хэрэгжсэн, Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, УИХ-аас 2021 онд шинэчлэн найруулж баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн үндэслэл, зохицуулалт сайжирсан байна.

Харин шүүхийн төсөв, хөрөнгө оруулалтын зардлыг хүрэлцэхүйц хэмжээнд баталж байгаагүйгээс шалтгаалан шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход чиглэгдсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн түвшин хангалтгүй байдалтай, энэ нь шүүхийн эдийн засгийн баталгаа алдагдах, шүүхийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар иргэд, олон нийтэд шүүхийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэхэд хүндрэл бэрхшээл учруулах хүчин зүйл болж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэгт заасны дагуу “Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлого”-ыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн бодлого, чиглэлтэй уялдуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний тухай хуульд нийцүүлэн боловсруулах батлах шаардлага үүссэн байна.

Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний стратеги зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн гаргахад зарим зорилт, арга хэмжээ давхардсан байдал ажиглагдсан тул цаашдын бодлогыг боловсруулахдаа зорилт, арга хэмжээг оновчтой, давхардалгүй байхад анхаарах нь зүйтэй байна.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулахад дараах асуудлуудыг судлан тусгахыг зөвлөж байна.

**Нэг.** Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүхэд мэдүүлэх иргэний эрхийг хангах, зөрчигдсэн эрх, эрх чөлөөг хамгаалах нь шүүхийн үндсэн үүрэг билээ. Тиймээс иргэдээс шүүхэд хандахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг судлах, тэдгээрийг арилгахад чиглэсэн бодлого, зорилтоо тодорхойлон оруулах нь зүйтэй. Энэ хүрээнд шүүхийн үйлчилгээг сайжруулах төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог идэвхжүүлэх, шүүхээр үйлчлүүлэхэд учирдаг хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлох санал асуулгын оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь чухал юм.

Мөн хууль зүйн үйлчилгээний туслалцааг эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлахгүйгээр төлбөрийн чадваргүй иргэнээс гадна захиргааны зарим хэрэг, маргаанд оролцогч болон гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогч болсон насан хүрээгүй хүн зэрэг зорилтот бүлгийн иргэнд улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын өмгөөлөл үзүүлэх байгууллагын чадавхыг бэхжүүлэх, улсын өмгөөлөгчийн орон тоо, төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх

нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Монгол Улсын Үндсэн хуулийн эрхэм зорилгод нийцнэ.

Түүнчлэн иргэдэд шүүхэд мэдүүлэх эрхээ хангах, хамгаалуулахад чиглэсэн мэдээлэл, мэдлэгийг шүүх, шүүхийн захиргааны байгууллагаас мэргэжлийн түвшинд оновчтой, ойлгомжтой байдлаар олон талт хэлбэрээр тасралтгүй хүргэх, шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа -2050”-д туссан иргэн төвтэй шүүхийг төлөвшүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

**Хоёр.**Хуулийн засаглал, шударга ёсыг төлөвшүүлэхэд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, сахилга хариуцлага, ёс зүй шийдвэрлэх үүрэгтэй. Тиймээс шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, хариуцлага байдлыг бэхжүүлэх асуудлыг цогцоор авч үзэж шүүх эрх мэдлийн бодлогод тусгахыг зөвлөж байна.

Шүүхийн бие даасан байдлыг хангах хүрээнд Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийн бодлого, хувийн эрх зүйн цаашдын бодлого, чиглэл, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг нийцүүлэн шинэчлэх, шүүхийн хөрөнгө оруулалтыг үр ашгийг нэмэгдүүлэх, нөөцийн оновчтой хуваарилалтын механизмыг бий болгоход анхаарах нь зүйтэй.

Шүүгчийн хараат бус байдлыг хангах хүрээнд шүүгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой чадавхыг бэхжүүлэх, шүүгчид нөлөөлөхөөр оролдсон этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шүүгчийн цалин хөлсийг шилдэг хуульчдыг татах хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх асуудал чухал байна. Шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн үндсэн зохицуулалт болсон нөлөөллийн мэдүүлгийг шүүгч хөтөлж, ирүүлсэн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл нөлөөлөхийн оролдсон этгээдийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад хандах, мэдэгдэл гаргах арга хэмжээ авч байна. Цаашид шүүгчид нөлөөлөхийг оролдсон этгээдэд Шүүхийн ерөнхий зөвлөл шаардлага хүргүүлж, холбогдох этгээдийг түүнийг заавал биелүүлж эргэж мэдэгддэг хариуцлагын үр дүнтэй механизм дутагдаж байгааг цаашдын бодлогод тусган ажил хэрэг болгох нь зүйтэй.

Нөгөө талаар хэрэг маргааны хянан шийдвэрлэж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах онцгой эрхтэй шүүгчийн хариуцлага чанга, хараат бус байдал баталгаатай байхын зэрэгцээ цалин хангамж өндөр байх учиртай. Тиймээс шүүгчийн цалин хөлсийг амьдралд хүрэлцэхээр, чадварлаг хуульч нар шүүгчид нэр дэвших хэмжээнд байлгах шаардлагатай юм.

Шүүхийн хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх хүрээнд шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хариуцлага хүлээх чадварыг дээшлүүлэх, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үр дүнтэй тогтолцоог төлөвшүүлэх, шүүгчийн сахилгын хэргийн лавлагаа, мэдээллийн сан бий болгож нийтэд нээлттэй байлгах нь шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

**Гурав.**Шүүхийн үйлчилгээг иргэний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх, иргэн төвтэй шүүхийг төлөвшүүлэх асуудал шүүх эрх мэдлийн байгууллагын менежментээс шууд хамаарна.

Мэдээллийн технологийн дэвшил, орчин үеийн программ хангамж, удирдлагын систем, хиймэл оюун ухааны хэрэглээнд үндэслэсэн, цахимжсан, ил

тод, нээлттэй шүүхийн үйлчилгээг цогц чадамжтай хүний нөөцийн тусламжтайгаар үзүүлэх нь өнөөгийн нийгмийн хүлээлт, шаардлага болж байна.

Энэ хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах, шүүхээс үзүүлдэг бусад үйлчилгээг цахимд шилжүүлэх, шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч прокурор, хууль сахиулах байгууллагууд хооронд мэдээлэл солилцооны цахим систем, мэдээллийн нэгдсэн төвийг бий болгох эрх зүй, зохион байгуулалтын болон дэд бүтэц, техник, технологийн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Шүүхийн мэдээллийн технологи, цахим шилжилтэд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт жил бүр үе шаттай тусгаж байж энэ ажил үр дүнтэй хэрэгжинэ. Тиймээс шүүхийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлыг “цахим монгол” болох төрийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх зорилтоо тодорхойлон хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Нөгөө талаар мэдлэг, ур чадвар сайтай, зан харилцаа, ёс зүйн төлөвшилтэй буюу цогц чадамжтай шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэх, энэ ажлын хүрээнд шилдэг хуульчдыг шүүгчээр шилж ажиллуулах ил тод, нээлттэй, цахимжсан сонгон шалгаруулалтын арга, туршлагаа байнга сайжруулах, шүүгчид тавигдах шалгуур, шаардлагыг илүү оновчтой, боловсронгуй болгох нь бодлогын төвд байх ажлын нэг байна.

Шүүн таслах ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг шүүхийн захиргааны ажилтныг системтэй бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгох, тогтвортой ажиллуулахад чиглэсэн цалин хөлсний болон шатлан дэвших тогтолцоог төлөвшүүлэх шаардлагатай.

Нөгөө талаас Хүн амын тоо, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээ, хэрэг маргааны тоо зэргийг харгалзан шүүгчийн орон тоо шүүгчийн ажлын ачааллын зохист хэмжээг тодорхойлж, түүнд үндэслэн шүүгчийн орон тоог тогтоож цалингийн санг төсөв бүрэн тусган, ажил, амралтын хэвийн горимоор ажиллах бололцоогоор хангах шаардлагатай байна. Түүнчлэн шүүхийн захиргааны ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын зохист ачааллын хэмжээг албан тушаал бүрээр оновчтой тогтоон мөрдүүлэх нь ажлын бүтээмжтэй байдлыг дээшлүүлэх гол арга зам юм.

**Дөрөв.** Шүүхийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шүүхийн шийдвэрийн хуулийн үндэслэл сайн байхын тулд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь чухал байдаг.

2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг, арга зүйн зохицуулалтыг бий болгосонтой холбогдуулан Улсын дээд шүүхээс хуулийн тайлбар гаргах судалгааны чадавхыг бэхжүүлэх, хууль хэрэглээний талаар шүүгчдийг аргачлал, зөвлөмжөөр тогтмол хангах, шүүгчдээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, санаачилгыг урамшуулан дэмжих асуудал ихээхэн ач холбогдолтой.

Нөгөө талаар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжрах нь иргэдэд чирэгдэл учруулах, цаг хугацаа, зардал мөнгөний болон сэтгэл зүйн дарамт үүсгэх, улмаар шүүхэд итгэх иргэдийн итгэл буурахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэрэг маргааны төрөл, ээдрээ түвэгтэй байдал, бусад онцлог байдалд тохируулан ялгамжтай тогтоох, жижиг үнийн дүнтэй хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хэрэг маргааныг

цахимаар явуулах талаар хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бодлогод тусган үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах, дагнасан шүүх, танхимын төрлийг олшруулах замаар шүүхэд мэдүүлэх иргэний эрхийг хангах, шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх нөхцөлийг сайжруулахад анхаарах хэрэгтэй.

Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ын дэмжлэгтэйгээр 2013 оноос Монгол Улсад амжилттай нэвтрүүлж, иргэний хэргийн 20 орчим хувийн ачааллыг шүүхийн шатнаас өмнө шийдвэрлэдэг болсон эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг цаашид өргөжүүлж, эрүү, захиргааны зарим хэрэг, маргаанд хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь иргэд хэрэг, маргаанаа шүүхийн бус аргаар, түргэн шуурхай, зардал багатай шийдвэрлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр цаашдын бодлого, зорилтоо тодорхойлох нь зүйтэй.

2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар иргэдийн төлөөгчийн санал, дүгнэлтийг шүүгч шийдвэртээ тусгадаг болсонтой холбогдуулан шүүхийн иргэдийн төлөөгчийн хуулиар хүлээсэн эрх үүрэг, оролцоо, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг бодлогын түвшин авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

**Тав.** Шүүхийн эдийн засгийн баталгааг хангахгүйгээр, шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэхгүйгээр шүүхийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх боломж, нөхцөл бүрдэхгүй. Өөрөөр хэлбэл, шүүхийн төсөв бол Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон шүүхэд мэдүүлэх, зөрчигдсэн эрх, эрх чөлөөгөө сэргээлгэн эдлэх иргэний эрхийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаанд оруулж буй хөрөнгө оруулалт юм.

Тиймээс Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооноос боловсруулсан төсвийг бууруулахгүйгээр батлах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Харин шүүхийн санхүүжилтийг гүйцэтгэл, үр дүнд суурилан төлөвлөх, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шүүхийн төсвийн үр ашиг, удирдлагыг сайжруулах асуудлыг бодлогодоо тусган хэрэгжүүлэх хэрэгтэй.

Мөн шүүхийн байрны өрөө тасалгааг цэвэрлэх, тээврийн хэрэгслээр үйлчлэх, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх зэрэг шүүхийн захиргааны зарим үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлж, шүүхийн захиргааны зардлын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэл баримтлах нь зүйтэй юм.